

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ  
“Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл хэрэгжүүлэх нэгж ”

2020 оны 06 дугаар сарын 02-ны өдөр

“ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН СТАНЦЫН ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ  
НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОХ” ЗӨВЛӨХИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН  
БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалт/ гэрээний нэр: “ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН СТАНЦЫН  
ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН  
НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЗӨВЛӨХ  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОХ” ЗӨВЛӨХИЙГ  
СОНГОН ШАЛГАРУУЛАХ

Дугаар: ЭБУЦС/202004002

## ЗӨВЛӨХИЙН ТЕНДЕРИЙН УРИЛГА

2020 оны 06 дугаар сарын 02

1. Эрчим хүчний яамны “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан хийлгэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтыг зохион байгуулж байгаа тул уг ажлыг гүйцэтгэх саналаа ирүүлэхийг урьж байна.
2. Зөвлөх үйлчилгээний тендерт оролцох урилгыг хураангуй жагсаалтад орсон дараах зөвлөхүүдэд хүргүүлж байна:
  - Экологи бүтээмж ХХК
  - Тэкол ХХК
  - Найчралсастайнэблэ ХХК
  - Санни трейд ХХК
  - Гидропроект ХХК, Енко ХХК түншлэл
3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцүүлэн энэхүү зөвлөх үйлчилгээний тендерийн баримт бичигт тодорхойлсон журам болон хосолмол үнэлгээний аргад үндэслэн зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгоно.
4. Зөвлөхийн саналын баримт бичиг нь дараах бүрдэл хэсгүүдтэй байна. Үүнд:
  - Бүлэг 1 - Урилга
  - Бүлэг 2 - Зөвлөхийн санал бэлтгэх зааварчилгаа (Тендерийн өгөгдлийн хүснэгтийн хамт)
  - Бүлэг 3 - Техникийн санал - жишиг маягт
  - Бүлэг 4 - Санхүүгийн санал - жишиг маягт
  - Бүлэг 5 - Ажлын даалгавар
  - Бүлэг 6 - Гэрээний жишиг маягт
  - Бүлэг 7- Тендерийн баталгаа
5. Зөвлөхийн саналын баримт бичгийг худалдан авах хүсэлтээ албан ёсоор гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгөөр иж бүрдэл бүрийг нь 50 000.0 /тавин мянга/ төгрөгөөр худалдан авч болно.
6. Оролцогч саналыг 2020 оны 07 дүгээр сарын 03-ны өдрийн 11.00 цагаас өмнө ирүүлэх ба тухайн өдрийн 11.30 цагт техникийн саналыг нээнэ.
7. Санал нь түүнийг нээсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор хүчинтэй байна.
8. Энэхүү урилгыг хүлээн авсан тухайгаа албан ёсоор манай байгууллагад мэдэгдэнэ үү.
9. Оролцогч этгээд саналын баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Эрчим хүчний яам “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл хэрэгжүүлэх нэгж”  
Улаанбаатар хот-17042, Хан-Уул дүүрэг 3-р хороо, Б.Шаравын гудамж  
“Хан-Уул” цамхаг 10 давхар 1004 тоот, Утас: 75553938, 99114604  
Имэйл хаяг: tuguldur@energy.gov.mn

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### ЗӨВЛӨХИЙН САНАЛ БЭЛТГЭХ ЗААВАРЧИЛГАА

---

#### 1. Ерөнхий зүйл

- 1.1. Захиалагч нь урилгад дурдсан зөвлөхүүдээс тендерийн өгөгдөлийн хүснэгтэд (цаашид ТӨХ гэх) заасан үнэлгээний аргаар зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч (зөвлөх)-ийг сонгоно.
- 1.2. Зөвлөх нь ТӨХ-д дурдсаны дагуу техникийн болон санхүүгийн саналаа нэгэн зэрэг эсхүл техникийн саналаа дангаар ирүүлнэ. Эдгээр санал нь шалгарсан зөвлөхтэй хэлэлцээр хийх болон гэрээ байгуулах гол үндэслэл байх болно.
- 1.3. Зөвлөхийн үйлчилгээг ТӨХ-д заасан ажлын хуваарийн дагуу хэрэгжүүлнэ. Ажлын хуваарь нь хэд хэдэн үе шаттай байх тохиолдолд үе шат бүрийн ажил нь дараагийн шатны ажил эхлэхийн өмнө захиалагчийн шаардлагад нийцсэн хэмжээнд хийгдсэн байх ёстой.
- 1.4. Зөвлөх нь тендерээ бэлтгэхдээ хийгдэх ажлын нөхцөл байдлыг харгалзаж үзсэн байна. Зөвлөх нь энэ тухай мэдээллийг олж авахын тулд захиалагчид хандах болон ТӨХ-д заасан бол санал ирүүлэхийн өмнөх уулзалтад оролцох эрхтэй. Зөвлөх нь ТӨХ-д заасан албан тушаалтанд санал ирүүлэхийн өмнөх уулзалтад оролцох тухайгаа мэдэгдэх ба түүнээс нэмэлт мэдээллийг авч болно.
- 1.5. Захиалагч нь ТӨХ-д заасан зөвлөхөд үзүүлэх дэмжлэг туслалцааг зохистой хугацааны дотор үнэ төлбөргүйгээр үзүүлж, тухайн үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах тусгай зөвшөөрөл болон бусад зөвшөөрлийг авахад тусалж, төслийн холбогдох мэдээ, тайланг гаргаж өгнө.
- 1.6. Зөвлөхийн санал бэлтгэх болон гэрээ байгуулах хэлэлцээр хийхтэй холбогдож гарах зардлыг зөвлөх өөрөө хариуцна. Захиалагч нь зөвлөхийн өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүйгээр гэрээ байгуулах эрх олгохоос өмнө тендерээс үндэслэлгүйгээр татгалзахыг хориглоно.
- 1.7. Зөвлөхийн үзүүлэх үйлчилгээ нь мэргэжлийн түвшинд, бодитой, үнэн зөв байх бөгөөд захиалагчийн ашиг сонирхлыг үргэлж нэн тэргүүнд тавьж, өөр бусад ажил болон өөрийн бизнесийн ашиг сонирхолтой зөрчилдөхгүй байх ёстой. Зөвлөх нь бусад захиалагчийн өмнө, эсхүл одоо хүлээсэн үүрэгтэй зөрчилдөх, эсхүл захиалагчийн бүрэн ашиг сонирхлын үүднээс ажиллах боломжгүй байдалд хүргэх аливаа ажлын гүйцэтгэгчээр түүнийг сонгохгүй.
  - 1.7.1. Дээрх 1.7-д заасан ерөнхий нөхцөлөөс үл хамааран дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд тухайн зөвлөх болон түүний салбар нэгжийг ашиг сонирхолын зөрчилтэй гэж тооцох бөгөөд түүний саналыг сонгохгүй.  
Үүнд:

- (1) Тодорхой төслийн хүрээнд бараа, ажил эсхүл зөвлөхийн бус үйлчилгээний гүйцэтгэгчээр сонгогдсон этгээд болон түүний аль нэгэн салбар нэгж нь тухайн төслийн хүрээнд зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрхгүй. Нөгөө талаас, тодорхой төслийг бэлтгэх, хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр сонгогдсон этгээд, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой аливаа этгээд нь тухайн төслийн хүрээн дэх зөвлөхийн үйлчилгээ болон үүнтэй шууд уялдан үүсэх үйлчилгээнээс бусад бараа, ажил, зөвлөхийн бус үйлчилгээний гүйцэтгэгчээр ажиллаж болохгүй.
- (2) Үндсэн шинж чанарын хувьд зөвлөх (түүний ажилтан болон туслан зөвлөгчийг оролцуулан)болон түүний салбар этгээдийн зүгээс тухайн захиалагч буюу өөр захиалагчтай хэрэгжүүлэх бусад үйл ажиллагаатай зөрчилдөж болох аливаа төсөл арга хэмжээнд уг этгээдийг зөвлөхөөр сонгохгүй. Тухайлбал, дэд бүтцийн төслийн инженерийн шийдлийг бэлтгэхээр сонгогдсон зөвлөх этгээд тухайн төслийн хувьд байгаль орчны бие даасан үнэлгээг бэлтгэхэд оролцож болохгүй ба төрийн өмч хөрөнгийг хувьчлаж буй захиалагчид зөвлөхийн үйлчилгээ үзүүлж буй этгээд тухайн өмчийг худалдан авах эсхүл худалдан авагч этгээдэд зөвлөж болохгүй. Үүний нэгэн адил, төсөл арга хэмжээний ажлын даалгаварыг бэлтгэхээр сонгогдсон зөвлөх хэрэгжих гэж байгаа уг төсөл арга хэмжээнд оролцох эрхгүй.
- (3) Захиалагчийн эрх ашигт бүрэн нийцүүлэн үйлчлэх боломжийг хязгаарлаж болох бодит буюу болзошгүй ашиг сонирхлын зөрчил эсхүл ийм үр дагаварт хүрч болохуйц гэж тооцогдохоор аливаа нөхцөл байдлын талаар зөвлөх мэдэгдэх үүрэгтэй. Ийм нөхцөл байдлыг мэдэгдээгүй нь зөвлөхийг шалгаруулалтаас хасах эсхүл гэрээ цуцлахад хүргэх үндэслэл болно.

1.7.2. Энэ бүлгийн 1.7.1-ийн (1)-д заасны дагуу зөвлөхийг ажлын зайлшгүй шаардлагаар дараагийн шатны ажлын гүйцэтгэгчээр үргэлжлүүлэн ажиллуулж болно. Энэ боломжийг ТӨХ-д заавал тусгах ба зөвлөхийг сонгох шалгуур үзүүлэлт нь төслийн өмнөх үе шатанд ажилласан байдлыг харгалзсан байна.

- 1.8. Захиалагч болон зөвлөх нь зөвлөхийн сонгон шалгаруулах ажиллагаа болон гэрээг хэрэгжүүлэх явцад ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөнө.
- 1.9. Худалдан авах ажиллагаанд оролцож байгаа төрийн албан хаагч болон тендерт оролцогч нь Авилгын эсрэг хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авилгал, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх,

айлган сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон талаар бодитой мэдээлэл байгаа бол холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад зохих ёсоор мэдэгдэнэ.

**Эрх бүхий зөвлөх**

- 1.10. Тендерийн урилга нь хураангуй жагсаалтад багтсан эрх бүхий зөвлөх бүрт нээлттэй. Хууль 9.3 дахь хэсэгт заасныг үндэслэн гадаадын этгээдийг тендерт оролцуулахгүй байхаар шийдвэрлэж тендерийн урилгад зааснаас бусад тохиолдолд зөвлөх болон түншлэлийн гишүүн бүр нь аль ч улсын харъяалалтай байж болно.
- 1.11. Дараах тохиолдолд зөвлөх (түншлэлийн гишүүн бүрт нэгэн адил хамаарна)-ийг эрх бүхий бус гэж үзнэ. Үүнд:
  - 1.11.1. Төлбөрийн чадваргүй болсон, татан буугдаж байгаа, дампуурлаас зайлсхийх зорилгоор зээлдүүлэгчтэй тохиролцсон, бизнесийн үйл ажиллагааг нь зогсоосон, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу дээр дурдсантай адилтгах нөхцөлд байгаа;
  - 1.11.2. Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлөөгүй;
  - 1.11.3. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь захиалагчаас хараат байдлаар үйл ажиллагаа явуулдаг;
  - 1.11.4. Сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй, эсхүл мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасныг шүүх, эрх бүхий байгууллага тогтоосон;
  - 1.11.5. Тендерт оролцогч нь бараа, ажил, үйлчилгээний зураг төсөл, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхолтой;
  - 1.11.6. Илт худал мэдээлэл бүхий тендер ирүүлснийг эрх бүхий байгууллага тогтоосон;
  - 1.11.7. Сүүлийн 3 жилийн хугацаанд Авилгын эсрэг хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авилгын, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлган сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон болохыг шүүх тогтоосон;
  - 1.11.8. Зөвлөх нь (туслан гүйцэтгэгч бүрийг оролцуулан) уг төслийн зураг төсөл, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээг хянах зөвлөхөд нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхолтой бол;
  - 1.11.9. Тухайн тендер шалгаруулалтын хоёр буюу түүнээс дээш тооны тендерт оролцогчийн хууль ёсны төлөөлөгч нь нэг этгээд бол;

1.11.10. Энэхүү тендерийн баримт бичигт хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрснөөс бусад тохиолдолд тухайн тендер шалгаруулалтад аливаа тендерт оролцогч нэгээс дээш тендер ирүүлсэн бол; (Гэвч энэхүү заалт нь аливаа этгээдийг нэгээс дээш тендерт туслан гүйцэтгэгчээр оролцохыг, эсхүл нэг тендер шалгаруулалтад нэгээс олон багцад тендер ирүүлэхийг хязгаарлахгүй)

1.11.11. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд бүтэц зохион байгуулалт болон санхүүгийн хувьд захиалагчаас хараат байдлаар үйл ажиллагаа явуулдаг бол /Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд зааснаар төр ашгийн төлөө үйл ажиллагааг зөвхөн төрийн өмчит үйлдвэрийн газар болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээр дамжуулан явуулахаар заасан тул эдгээрээс бусад төрийн байгууллага, албан газар тендерт оролцох эрхгүй/.

1.12. Тендерт оролцогч 1.11.1 - 1.11.11-д дурдсан нөхцөл үүссэн эсэх тухай мэдэгдлийг захиалагчид бичгээр гаргаж өгөх үүрэгтэй. Эдгээр нөхцөл үүссэн эсэхийг магадлах зорилгоор захиалагчаас тавьсан шаардлагын дагуу тендерт оролцогч холбогдох баримт, нотолгоог захиалагчид ирүүлнэ.

**2. Зөвлөх үйлчилгээний тендерийн баримт бичгийг тайлбарлах, засварлах**

2.1. Зөвлөх нь зөвлөх үйлчилгээний тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтээ бичгээр, эсхүл утсан холбоо ("утсан холбоо"-нд зөвхөн телекс болон факсыг хамруулна)-гоор урилгад заасан захиалагчийн хаягаар мэдэгдэнэ. Захиалагч санал хүлээн авах эцсийн хугацаанаас ТӨХ-д заасан хоногийн өмнө хүлээн авсан хүсэлтэд хариу өгнө. Хүсэлтийн агуулга, түүнд өгөх захиалагчийн хариуг хүсэлтийн эх сурвалжийг дурдалгүйгээр зөвлөхийн санал ирүүлэхээр уригдсан бүх зөвлөхөд бичгээр, эсхүл утсан холбоогоор мэдэгдэнэ.

2.2. Санал ирүүлэх эцсийн хугацаанаас өмнө захиалагч өөрийн санаачилгаар, эсхүл уригдсан зөвлөхүүдийн тодруулгын хариуд зөвлөх үйлчилгээний тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулж болно. Нэмэлт өөрчлөлт нь зөвлөхийн санал авах баримт бичгийн салшгүй хэсэг болох бөгөөд түүнийг уригдсан бүх зөвлөхүүдэд бичгээр, эсхүл утсан холбоогоор мэдэгдэнэ. Шаардлагатай бол захиалагч зөвлөхийн санал хүлээн авах эцсийн хугацааг сунгана.

**3. Тендерийн баталгаа**

3.1. Тендерт оролцогч нь мөн ТӨХ-д заасан дүнтэй тендерийн баталгааг ирүүлнэ.

3.2. Тендер шалгаруулалт олон багцтай бол нэг тендерийн баталгаа гаргаж, түүнд багц тус бүрээр тодорхойлж ирүүлнэ

3.3. Захиалагч тендерийн баталгааны хэмжээг багц тус бүрийн төсөвт өртгийн 1-2 хувиар тооцож ТӨХ-д заана.

3.4. Тендерийн баталгаа нь Монгол улсын, эсхүл гадаадын банкны гаргасан баталгаа байна. Тендерийн баталгааг 4 дүгээр бүлэгт

заасан маягтаар, эсхүл тендер хүлээн авахаас өмнө захиалагчийн урьдчилан хүлээн зөвшөөрсөн маягтаар ирүүлнэ. Тендерийн баталгаа нь тендер хүчинтэй байх эцсийн хугацаанаас хойш 28 хоногбайна.

- 3.5. Тендерийн баталгааны эх хувийг ирүүлэхдээ хүчинтэй байх хугацааг захиалагчийн ТӨХ-д заасан хоног (он, сар, өдөр)-оор тооцож ирүүлнэ.
- 3.6. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.
- 3.7. Зааварчилгааны 3.1-д шаардсаны дагуу хүлээн зөвшөөрөхүйц тендерийн баталгаа ирүүлээгүй аливаа тендерийг захиалагч үндсэн шаардлага хангаагүй гэж үзэж, татгалзана.
- 3.8. Тендер нь шалгараагүй оролцогчийн тендерийн баталгаа нь тендер хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоногийн дотор захиалагч хүчингүй болгоно.
- 3.9. Тендерийн баталгааг хуулийн 20.7-д заасан нөхцөл үүссэн тохиолдолд улсын орлого болгоно.

#### **4. Санал бэлтгэх Техникийн санал**

- 4.1. Зөвлөх ТӨХ-д заасан хэл дээр техникийн болон санхүүгийн саналыг бэлтгэнэ.
- 4.2. Зөвлөх үйлчилгээний тендерийн баримт бичгийг бүрэн судалсны үндсэн дээр зөвлөх нь техникийн саналыг бэлтгэнэ. Захиалагч техникийн саналыг үнэлэх ерөнхий болон дэд шалгуур үзүүлэлтийг оновчтой гаргаж зохих оноог өгөх бөгөөд техникийн саналд авбал зохих доод оноо 70 байхаар ТӨХ-д заана.
- 4.3. Зөвлөхийн санал нь мөн түүнд хавсарган ирүүлсэн мэдээлэл нь уг баримт бичигт тусгасан шалгуур үзүүлэлт, шаардлагаас материаллаг зөрүүтэй байгаа нь түүний тендерээс татгалзах үндэслэл болно.
- 4.4. Зөвлөх нь техникийн саналыг бэлтгэхдээ дараах зүйлийг онцлон анхаарна. Үүнд:

(1) Хураангуй жагсаалтанд орсон зөвлөх нь төсөл арга хэмжээг гүйцэтгэх туршлага, чадвараа нэмэгдүүлэх нь зүйтэй гэж үзсэн тохиолдолд зөвлөх хувь хүн, бусад компанитай түншлэлийн, эсхүл туслан гүйцэтгүүлэх гэрээ байгуулж болно. Ингэхдээ ТӨХ-д тусгайлан заасан тохиолдолд зөвлөх нь хураангуй жагсаалтад орсон эсхүл уг жагсаалтад ороогүй бусад зөвлөхтэй хамтарч тендерээ ирүүлж болно. Түншлэл болон туслан зөвлөх хувь хүнтэй хамтрах хүсэлтэй зөвлөх нь энэ талаар захиалагчид урьдчилан мэдэгдэж зөвшөөрөл авах ёстой бөгөөд хэрэв жагсаалтад ороогүй бусад зөвлөх этгээдтэй хамтрах бол өөрөө түншлэлийг төлөөлөх эрх бүхий гишүүн байх ёстой.

(2) Захиалагч төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх төсвийн тооцоо эсхүл хүн-сард үндэслэсэн ажилтны тоо хоёрын аль нэгийг

л ТӨХ-д заана. Гэхдээ зөвлөх нь өөрийн тооцоонд үндэслэн тендерээ ирүүлнэ.

Чанарын үнэлгээний аргад үндэслэх төсөл арга хэмжээний хувьд төсвийн хэмжээг ТӨХ-д заасан байх бөгөөд тендерт оролцогч уг хэмжээнээс хэтрээгүй санхүүгийн санал ирүүлэх ёстой, ингэхдээ хүн-сарын аргад үндэслэсэн ажилтны тоог нууцална.

- (3) Санал болгож буй голлох мэргэжилтнүүдийн олонхи нь тухайн зөвлөх компанийн үндсэн ажилтан, эсхүл түүнтэй тогтвортой хамтран ажилладаг байвал зохино.
- (4) Санал болгож буй ажилтан ТӨХ-д заасан туршлагын доод шалгуурыг хангасан байх шаардлагатай.
- (5) Нэг ажлын байранд нэг ажилтанг санал болгох бөгөөд хувилбарт саналыг зөвшөөрөхгүй.
- (6) Энэ ажлын хүрээнд зөвлөхийн боловсруулах тайлан нь ТӨХ-д заасан хэл дээр байна.

**Техникийн саналын хэлбэр, агуулга**

4.5. Зөвлөх нь тухайн төсөл арга хэмжээний онцлог, цар хүрээнээс хамааран ТӨХ-д тодорхойлсон техникийн саналын дагуу, Бүрэн хэмжээний техникийн санал (БХТС) эсхүл Хялбарчилсан техникийн санал (ХТС) ирүүлнэ. Техникийн санал ирүүлэх хэлбэрээс өөрөөр ирүүлсэн саналыг шаардлагад нийцээгүй гэж тооцон түүнээс татгалзана. Техникийн санал нь 3 дугаар бүлэгт заасан маягтуудын дагуу дараах мэдээллийг агуулсан байна. Үүнд:

- (1) а/ БХТС-ын хувьд: Зөвлөх компаний танилцуулга, ижил төстэй ажлын туршлага (Маягт 3.2). Үүнд санал болгосон ажилтнуудын танилцуулга, хийгдсэн ажлын хугацаа, гэрээний дүн болон тухайн компаний оролцсон байдлыг өмнө хийгдсэн ажил тус бүрээр харуулна.  
б/ ХТС-ын хувьд: Дээрх мэдээлэлийг ирүүлэх шаардлагагүй бөгөөд Маягт 3.2 –ыг бөглөхгүй.
- (2) а/ БХТС-ын хувьд: Төсөл арга хэмжээний чанар/үр нөлөөг сайжруулах талаар ажлын даалгаварт өгөх ажил хэрэгч санал, зөвлөмж болон зөвлөхийн зүгээс гарган өгч болох өгөгдөл, үйлчилгээний жагсаалт болон ажлын байр техник хэрэгслийн талаарх аливаа санал, (Маягт 3.3).  
б/ ХТС-ын хувьд: Маягт 3.3-ыг бөглөхгүй санал, зөвлөмж гаргах бол ажлын аргачлалтай нэгтгэн ирүүлнэ
- (3) БХТС болон ХТС-ын хувьд: Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх ажлын хөтөлбөр болон аргачлалын талаарх танилцуулга (Маягт 3.4).  
ХТС-ын хувьд: Ажлын хөтөлбөр болон аргачлалын талаарх танилцуулга болон хэрэв ажлын даалгаврын талаар гаргах санал, зөвлөмж байгаа бол эдгээр нь ерөнхийдөө 10 хуудаст багтсан байна.



- (4) Ажиллах багийн бүрэлдэхүүн, багийн гишүүн тус бүрийн мэргэжил, хариуцах ажил болон түүнийг хэрэгжүүлэх хугацаа (Маягт 3.5).
- (5) Санал болгож буй мэргэжлтний намтар. Намтар нь тухайн мэргэжилтэн болон санал ирүүлж буй эрх бүхий этгээдээр гарын үсэг зурагдсан байх бөгөөд тухайн байгууллагад ажилласан жил, сүүлийн 10жилийн хугацаанд түүний хариуцаж байсан ажил, албан тушаалын талаарх мэдээллийг агуулсан байна (Маягт 3.6).
- (6) Ажилтны (мэргэжлийн болон туслах ажилтан, хүн-цагаар) ажлыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай оролцоог харуулсан тооцоог хүн тус бүрээр харуулсан хугацааны хуваарийн хамт (Маягт 3.7, 3.8).
- (7) БХТС-ын хувьд: Санал болгож буй аргачлал, багийн бүрэлдэхүүн, сургалтын (ТӨХэд хийгдэх ажлын нэг гол хэсэг гэж заасан бол) зохион байгуулалтын талаар дэлгэрэнгүй танилцуулга.
- (8) ТӨХ-д шаардсан бусад нэмэлт мэдээлэл.

4.6. Техникийн саналд үнэтэй холбоотой аливаа мэдээллийг оруулж үл болно. Санхүүгийн мэдээлэл агуулсан техникийн саналыг шаардлагад нийцээгүй гэж тооцно.

**Санхүүгийн санал**

4.7. Санхүүгийн саналыг зөвлөх үйлчилгээний тендерийн баримт бичигт заасан нөхцөл, шаардлагыг харгалзан 4 дүгээр бүлэгт заасан жишиг маягтын дагуу бэлтгэнэ. Санхүүгийн саналд тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардагдах бүх зардлыг тусгана. Үүнд:

- (а) цалин хөлсний зардал (гадаад болон дотоодын мэргэжилтэнг томиллолтоор болон ажлын байрандаа ажиллах),
- (б) ТӨХ-д заасан нөхөн төлөгдөх зардал, тухайлбал, томилолтын зардал (байр, хоол), тээврийн зардал (гадаад болон дотоод, ажил эхлүүлэх болон дуусгахад зориулсан), бараа, үйлчилгээний зардал (машин, албан тасалгааны тоног төхөөрөмж, тавилга болон бичиг хэргийн зардал), байрны түрээс, даатгал, баримт бичиг хэвлэх, судалгаа болон сургалтын (хийгдэх ажлын нэг гол хэсэг гэж заасан бол) зардал. Эдгээр зардлуудыг үйл ажиллагаа нэг бүрээр болон гадаад, дотоодын зардлын зүйл бүрээр ангилан гаргах ба техникийн саналд дурьдсан боловч зардлыг тусгаагүй аливаа ажиллагааны зардал бусад ажлын зардалд шингэсэн гэж тооцогдоно. .

4.8. ТӨХ-д өөрөөр заагаагүй бол, санхүүгийн саналд зөвлөх, туслан гүйцэтгэгч болон тэдгээрийн ажилтнуудад хуулийн дагуу төлөх татвар, хураамж, шимтгэлийн (эрүүл мэнд, нийгмийн даатгал болон бусад даатгалын шимтгэлийг оруулан) дүнг тусад нь зааж оруулна.

4.9. Зөвлөх санхүүгийн саналыг ТӨХ-д заасан валютаар илэрхийлнэ.

4.10. Санхүүгийн санал нь ТӨХ-д заасан хугацаанд хүчинтэй байна. Энэ хугацаанд зөвлөх тухайн ажилд санал болгосон ажилтнуудыг зөвлөхийн үйлчилгээг гүйцэтгэхэд бэлэн байлгана. Захиалагч энэ хугацаанд багтаж гэрээний хэлэлцээрийг дуусгаж гэрээ байгуулна. Захиалагчаас үл хамаарах шалтгаанаар хүчинтэй хугацаанд гэрээ байгуулах боломжгүй болсон бол хуулийн 29.4-т заасны дагуу саналын хүчинтэй байх хугацааг сунгана.

**5. Санал ирүүлэх, хүлээн авах ба нээх**

5.1. Саналын эх хувийг арилдаггүй бэхээр бичнэ. Зөвлөх өөрийн саналын аль нэг хуудсанд алдааг залруулах зорилгоор засвар хийсэн бол түүнийг техникийн болон санхүүгийн саналд гарын үсэг зурсан этгээд (гарын үсэг зурах эрх бүхий этгээд, эсхүл түүний итгэмжлэгдсэн этгээд) үзэглэнэ.

5.2. Дээрх этгээд саналын хуудас бүрийг үзэглэсэн байна. Итгэмжлэгдсэн этгээдийн хувьд гарын үсэг зурах итгэмжлэлийг саналд хавсаргана.

5.3. Зөвлөх ТӨХ-д заасан хуулбар хувийг ирүүлнэ. Техникийн болон санхүүгийн санал бүрийг “ЭХ ХУВЬ”, эсхүл “ХУУЛБАР ХУВЬ” гэж тэмдэглэнэ. Эх хувь болон хуулбар хувь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд эх хувийг баримтлана.

5.4. Техникийн саналын эх хувь болон бүх хуулбар хувийг нэг дугтуйнд хийн битүүмжилж, “ТЕХНИКИЙН САНАЛ” гэж тэмдэглэнэ. Санхүүгийн саналын эх хувь болон бүх хуулбар хувийг өөр нэг дугтуйнд хийн битүүмжилж, “САНХҮҮГИЙН САНАЛ. ТЕХНИКИЙН САНАЛТАЙ ХАМТ НЭЭЖ ҮЛ БОЛНО” гэж тэмдэглэнэ. Үүний дараа эдгээр хоёр дугтуй бүхий саналуудыг нэг дугтуйнд хийн битүүмжилж ТӨХ-д заасан санал ирүүлэх хаяг болон бусад мэдээллийг бичиж, “ҮНЭЛГЭЭНИЙ ХЭСГИЙН ОРОЛЦООГҮЙГЭЭР НЭЭЖ ҮЛ БОЛНО” гэж анхааруулж тэмдэглэнэ.

5.5. Техникийн болон санхүүгийн саналыг заасан хаягаар ТӨХ-д товлосон хугацаанд ирүүлнэ. Хэрэв бүх дугтуйг 5.4-т заасан шаардлагын дагуу битүүмжилж, бичиглэл хийгээгүй нөхцөлд уг тендер буруу хаягаар хүргэгдсэн, эсхүл тендер нээхээс өмнө задарсан тохиолдолд захиалагч хариуцлага хүлээхгүй. Хугацаа хоцорч ирсэн саналыг нээлгүй буцаана.

5.6. Санал ирүүлэх эцсийн хугацаа дуусмагц үнэлгээний хэсэг техникийн саналыг нээнэ. Энэ үед санхүүгийн саналыг нээлгүй үлдээж нийтийн өмнө нээх хүртэл битүүмжлэлийг хангасан нөхцөлд хадгална.

5.7. Зөвлөх тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.

**6. Саналын үнэлгээ**

<b>Ерөнхий зүйл</b>	<p>6.1. Саналыг нээснээс хойш гэрээ байгуулах эрх олгох хүртэлх хугацаанд захиалагчтай техникийн болон санхүүгийн саналын талаарх асуудлаар зөвхөн албан бичгээр харилцана. Саналыг үнэлэх, тэдгээрийг харьцуулах болон гэрээ байгуулах эрх олгох ажиллагаанд нөлөөлөхийг завдсан аливаа зөвлөхийн үйлдэл нь түүний тендерээс татгалзах үндэслэл болж болно.</p> <p>Санхүүгийн саналыг зөвхөн техникийн саналын үнэлгээний дүнг баталсны дараа нээнэ.</p>
<b>Техникийн саналыг үнэлэх</b>	<p>6.2. Үнэлгээний хороо нь ажлын даалгаврын шаардлагад үндэслэн ТӨХ-д заасан үнэлгээний шалгуур, туслах шалгуурууд (ихэнх тохиолдолд нэг шалгуурт гурваас илүүгүй дэд шалгуур) болон онооны системийг ашиглаж техникийн саналын үнэлгээг хийнэ. Санал бүрт техникийн оноо (St) өгнө. Энэ шатанд техникийн даалгаврын үндсэн нөхцөл, эсхүл ТӨХ-д заасан техникийн доод оноог хангаагүй тендерээс татгалзана.</p>
<b>Чанарын үнэлгээний арга болон санхүүгийн санал</b>	<p>6.3. Чанарын үнэлгээний аргыг ашигласан тохиолдолд хамгийн өндөр техникийн оноо авсан зөвлөхтэй тендерийн өгөгдөлийн хүснэгт болон зөвлөхийн санал бэлтгэх зааварчилгын 1.2-т заасны дагуу түүний ирүүлсэн техникийн болон санхүүгийн саналд үндэслэн уг санал болон гэрээний нөхцөлийн талаар хэлэлцээр хийнэ. Шууд гэрээ байгуулах аргыг ашигласан тохиолдолд мөн энэ заалтыг мөрдөнө.</p>
<b>Санхүүгийн саналыг нийтийн өмнө нээх, үүнийг онооны системээр нэлэх: (Зөвхөн хосолмол үнэлгээний болон бага үнийн арга хэрэглэх үед)</b>	<p>6.4. Захиалагч техникийн саналыг үнэлэн техникийн доод онооны шалгуурыг хангаагүй, эсхүл ажлын даалгавар болон зөвлөх үйлчилгээний тендерийн баримт бичигт заасан шаардлагад нийцээгүй санал ирүүлсэн зөвлөхөд энэ тухай мэдэгдэж, зөвлөхийг сонгох ажиллагаа дууссаны дараа тэдгээрийн санхүүгийн саналыг нээлгүй буцаах тухай дурдана. Үүний зэрэгцээ техникийн доод оноог хангасан зөвлөхөд санхүүгийн саналыг нээх өдөр, цагийг албан бичгээр болон утсан холбоогоор мэдэгдэнэ. Энэ өдөр нь дээрх мэдэгдлийг гаргасан өдрөөс хойш таваас багагүй бөгөөд санал нээлтэнд оролцох хүсэлтэй зөвлөхөд энэ боломжийг олгохуйц хоногийн дараа байна.</p> <p>6.5. Санхүүгийн саналыг нийтийн өмнө нээлтэнд оролцох хүсэлтэй илэрхийлсэн зөвлөхийг төлөөлөх этгээдийг байлцуулан нээнэ. Санхүүгийн саналыг нээх үед зөвлөхийн нэр, түүний авсан техникийн оноо болон санал болгосон үнийг чангаар уншиж, нээлтийн тэмдэглэл хөтөлнө.</p> <p>6.6. Үнэлгээний хороо санхүүгийн санал бүрэн эсэх (жишээлбэл, техникийн саналтай холбогдох бүх нэр төрөлд үнийн санал өгсөн эсэх; үгүй бол орхисон нэр төрлийн өртгийг захиалагч зөвлөхийн санал болгосон үнэд нэмж тооцно)-ийг хянан үзэж, арифметик алдааг залруулна. Санхүүгийн саналыг төгрөгөөс өөр мөнгөн тэмдэгтээр илэрхийлсэн бол ТӨХ-д заасан өдрийн Монголбанкны албан ёсны ханшийг ашиглан төгрөгт хөрвүүлнэ.</p> <p>6.7. Хосолмол үнэлгээний аргыг хэрэглэх үед хамгийн бага үнэ бүхий санхүүгийн санал (Fm)-д 100 оноо өгнө. Бусад санхүүгийн саналын оноог (Sf) ТӨХ-д заасан томъёогоор тооцоолж гаргана. ТӨХ-д заасан хувийн жин (T=техникийн саналын хувийн жин;</p>

$P$ =санхүүгийн саналын хувийн жин;  $T+P=1$ )-г ашиглаж тухайн зөвлөхийн үнэлгээний нийт оноо( $S$ )-г дараах томъёогоор тооцоолж гаргана:  $S=St \times T + Sf \times P$ . Техникийн болон санхүүгийн хосолсон оноо нь хамгийн өндөр гэж тооцогдсон зөвлөхийг сонгож хэлэлцээрт урина.

6.8. Чанарын үнэлгээний аргыг хэрэглэх тохиолдолд, захиалагч нь тухайн төсөвт багтсан бөгөөд хамгийн өндөр оноо бүхий техникийн санал ирүүлсэн зөвлөхийг сонгоно. Тогтсон төсвөөс хэтэрсэн тендерээс татгалзана. Бага үнийн үнэлгээний аргыг хэрэглэх тохиолдолд техникийн доод үнэлгээний шалгуурыг хангасан бөгөөд хамгийн бага үнийн санал ирүүлсэн зөвлөхийг сонгож хэлэлцээрт урина.

## 7. Хэлэлцээр

7.1. Хэлэлцээрийг ТӨХ-д заасан хаягаар, товлосон хугацаанд явуулна. Бүх асуудлаар зөвшилцөлд хүрч, гэрээнд гарын үсэг зурахад хэлэлцээрийн зорилго оршино.

7.2. Хэлэлцээрийн үед техникийн санал, санал болгож буй аргачлал (ажлын төлөвлөгөө), боловсон хүчин ба ажлын даалгаврыг сайжруулах тухайн зөвлөхийн санал зэргийг хэлэлцэнэ. Дараа нь захиалагч болон зөвлөх ажлын даалгавар, ажиллах хүчин, төв байр болон ажлын талбайд хийгдэх үйл ажиллагаа, түүнийг гүйцэтгэх ажилтан, хугацаа зэргийг харуулсан ажлын график, хүн-сар, тайлан болон бусад асуудлыг эцэслэн тогтооно. Тохиролцсон ажлын төлөвлөгөө ба ажлын даалгаврыг гэрээний хэсэг болох “Үйлчилгээний танилцуулга”-д оруулна. Гэрээг амжилттай хэрэгжүүлэх зорилгоор зөвлөхийн санал батлагдсан төсөвт багтсан байх, нөгөө талаас захиалагчийн оролцоо шаардлагатай хэмжээнд тодорхой тусгагдсан байхад анхаарна. Захиалагч хэлэлцээрийн тэмдэглэлийг хөтлөх бөгөөд талууд гарын үсэг зурж баталгаажуулна.

7.3. Санхүүгийн хэлэлцээрээр зөвлөхийн төлөх татвар хураамж, түүнийг гэрээнд хэрхэн тусгах асуудлыг тодотгож (шаардлагатай бол), тохиролцсон техникийн өөрчлөлтүүдийг үйлчилгээний зардалд тусгана. Хосолмол үнэлгээ, тогтмол үнийн болон бага үнийн аргуудыг хэрэглэхдээ онцгой тохиолдлоос бусад үед санхүүгийн хэлэлцээрээр ажилтнуудын ажлын хөлсний (зардлын задаргаагүй) болон санал болгосон бусад зардлын нэгж үнийн тухай хэлэлцэхгүй. Бусад арга (чанарын үнэлгээний арга болон шууд гэрээ)-ыг ашигласан үед зөвлөх нь хавсралтад тодорхойлсон ажлын хөлсний нэгж үнийн талаарх мэдээллийг захиалагчид гаргаж өгнө.

7.4. Захиалагч нь санал болгож буй голлох мэргэжилтнүүдийн үнэлгээ болон бусад шалгуур үзүүлэлтийг харгалзан сонгосон зөвлөхтэй хэлэлцээр хийхдээ түүний саналд нэр заагдсан мэргэжилтнүүдэд үндэслэнэ. Гэрээний хэлэлцээр хийхийн өмнө захиалагч зөвлөхөөс тухайн ажилтан ажиллах боломжтойг баталгаажуулахыг шаардана. Зөвлөхийг сонгох ажиллагаа удааширсан нь ажилтныг солиход хүргэсэн, эсхүл энэ өөрчлөлт нь тухайн гэрээний зорилгыг хангахад зайлшгүй шаардлагатай гэж талууд тохиролцсоноос бусад тохиолдолд гэрээний хэлэлцээрийн үед санал болгосон ажилтныг солих асуудлыг авч хэлэлцэхгүй. Дээр дурдсан шаардлагыг хангаагүй болон санал

болгосон голлох мэргэжилтнүүдийн ажиллах боломжийг баталгаажуулаагүй бол тухайн зөвлөхийн тендерээс татгалзана.

- 7.5. Хэлэлцээрийн эцэст талууд гэрээний төслийг хэлэлцэнэ. Захиалагч болон зөвлөх тохиролцсон гэрээний төслийг үзэглэж хэлэлцээрийг дуусгана. Хэрэв хэлэлцээр амжилтгүй болсон бол захиалагч үнэлгээний нийт оноогоор удаах байр эзэлсэн зөвлөхийг гэрээний хэлэлцээрт урина.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох**
- 8.1. Хэлэлцээрийн дараа гэрээ байгуулах эрх олгоно. Хэлэлцээр дууссаны дараа захиалагч хураангуй жагсаалтад орсон бусад зөвлөхүүдэд тэдний санал шалгараагүй тухай даруй мэдэгдэж, техникийн саналын үнэлгээгээр шалгараагүй зөвлөхийн нээгдээгүй санхүүгийн саналыг буцаана. (5.3-г үз).
- 8.2. Шалгарсан зөвлөх нь ТӨХ-д заасан газарт товлосон өдөр зөвлөхийн үйлчилгээг эхэлбэл зохино.
- 9. Гүйцэтгэлийн баталгаа**
- 9.1. Шалгарсан тендерт оролцогч ТӨХ-д тусгайлан заагаагүй тохиолдолд гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхгүй байж болно. Гүйцэтгэлийн баталгаагээрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор гэрээний тусгай нөхцөлд заасан мөнгөн дүнтэй байхаар ТӨХ-д заасан маягтаар үйлдэж, гэрээний нөхцөлийн дагуу захиалагчид ирүүлнэ.
- 9.2. Гүйцэтгэлийн баталгааг:
- (а) тендерт оролцогчийн сонголтоор Монгол Улсад байрладаг банкаар буюу гадаадын банкны Монгол Улсад байрладаг харилцагч банкаар, эсхүл
  - (б) захиалагчийн хүлээн зөвшөөрсөн гадаадын банкаар,
  - (в) Засгийн газрын бонд болон засгийн газраас хүлээн зөвшөөрсөн ТӨХ-д тусгайлан заасан үнэт цаасны хэлбэрээр гаргуулж болно.
- 9.3. Шалгарсан тендерт оролцогч зааварчилгааны 9.1-д заасан шаардлагыг биелүүлээгүй нь түүнд олгосон гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгох болон тендерийн баталгааг гүйцэтгүүлэх хангалттай үндэслэл болно.
- 10. Нууцлал**
- 10.1. Гэрээ байгуулах эрх олгох хүртэлх хугацаанд саналын үнэлгээ болон гэрээ байгуулах эрх олгох тухай зөвлөмжтэй холбоотой мэдээллийг санал ирүүлсэн зөвлөхүүд болон энэ ажиллагаанд албан ёсоор холбогдолгүй этгээдэд задруулж үл болно.

**ТЕНДЕРИЙН ӨГӨГДӨЛИЙН ХҮСНЭГТ (ТӨХ)**

ТӨХ-ын холбогдох заалт	Ерөнхий зүйл				
ТӨЗ 1.1	Захиалагч нь: Эрчим хүчний яам “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл хэрэгжүүлэх нэгж” Үнэлгээний арга: <i>Хосолмол үнэлгээ</i>				
ТӨЗ 1.2	Техникийн болон санхүүгийн саналаа нэгэн зэрэг ирүүлэх: <i>Тийм</i>				
ТӨЗ 1.3	Зөвлөх үйлчилгээ үе шатад хуваагдана: <i>Үгүй</i>				
ТӨЗ 1.4.	Санал ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулагдана: <i>Үгүй</i>				
ТӨЗ 1.5	Захиалагчийн оролцоо, үзүүлэх дэмжлэг, байр, тоног төхөөрөмж: <i>Үгүй</i>				
ТӨЗ 1.7.2	Зөвлөх үйлчилгээг цаашид үргэлжлүүлэн гүйцэтгэх шаардлагатай: <i>Үгүй</i>				
ТӨЗ 2.1	Санал хүлээн авах хугацаанаас <i>ажлын 5-аас доошгүй</i> хоногийн өмнө ирсэн тодруулгад хариу өгнө. Улаанбаатар хот-17042, Хан-Уул дүүрэг 3-р хороо, Б.Шаравын гудамж “Хан-Уул” цамхаг 10 давхар 1004 тоот, Утас: 75553938. 99114604 Имэйл хаяг: tuguldur@energy.gov.mn				
ТӨЗ 3.3	Тендерийн баталгааны үнийн дүн: 5,160,000 /таван сая нэг зуун жаран мянган/ төгрөг				
ТӨЗ 3.5	Тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа: 2020 оны 07 дугаар сарын 02-ны өдрийг дуустал байна. Цахим тендерт оролцогч цахим баталгаа гаргах эрх бүхий арилжааны банкаар цахим тендерийн баталгаа гаргуулсан байна. Анхааруулга: Цахим тендерт оролцогч тендерийн материалд цахим тендерийн баталгааг хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан гаргасан цахим тендерийн баталгааны мэдээлэл үнэн зөв эсэхийг шалгах, нягтлах үүрэгтэйг анхаарна уу.				
ТӨЗ 4.1	Саналыг <i>Монгол</i> хэл дээр ирүүлнэ. Гадаад хэл дээрх бүх материалыг баталгаат орчуулгаар орчуулж ирүүлнэ. Зөвлөх нь дараах тусгай зөвшөөрөлтэй байна. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Байгаль орчны нөлөөллийн нарийвчлалсан үнэлгээ хийх хүчин төгөлдөр зөвшөөрөлтэй байх шаардлагатай.				
ТӨЗ 4.4	Хураангуй жагсаалтад орсон компани мөн жагсаалтад орсон бусад компанитай хамтран ажиллаж болно: <i>Тийм</i>				
ТӨЗ 4.4.1	Зөвлөхийн үйлчилгээг 2020 оны 11 дугаар сарын 30-ний дотор багтаан гүйцэтгэнэ.				
ТӨЗ 4.4.4	Зөвлөхийн санал болгох ажилтанд шаардагдах туршлагын доод түвшин:				
	<b>ГОЛЛОХ МЭРГЭЖИЛТНИЙ ШАЛГУУРЫН ДООД ҮЗҮҮЛЭЛТ</b>				
	Албан тушаал	тоо	Мэргэжил боловсрол	Ижил төстөй төсөлд ажилласан туршлага	Туршлага /жилээс доошгүй/
	Багийн ахлагч	1	Байгаль орчны менежмент, нөлөөллийн үнэлгээ, орчны төлөвлөлт мэргэжлийн чиглэлээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй	Олон улсын стандартаар хийгдсэн байгаль орчны нөлөөллийн янз бүрийн шатны үнэлгээний ажилд оролцсон туршлагатай байх	15

	Байгаль орчны үнэлгээний ахлах мэргэжилтэн	1	Байгаль, орчны менежмент, нөлөөллийн үнэлгээ, орчны төлөвлөлт зэрэг мэргэжлээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй	стратегийн болон салбарын байгаль орчны нөлөөллийн үнэлгээний ажил хийж байсан туршлагатай байх, усан цахилгаан, эрчим хүчний төслүүдэд ажиллаж байсан туршлагатай байх	15
	Загас судлаач	1	Загас судлаач мэргэжлээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй	Ижил төстэй бүс нутагт биологийн төрөл зүйлийн судалгаа, усны амьтад, загасны судалгааны ажлын арвин туршлагатай байх	10
	Цэвэр усны экологич/ лимнологич	1	Усны экологич мэргэжлээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй	Олон улсын стандартаар хэрэгжүүлж байсан байгаль орчны нөлөөллийн янз бүрийн шатны үнэлгээний ажилд оролцсон туршлагатай байх	10
	Гидрологич	1	Гидрологич, ус зүйч мэргэжлээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй	Монгол оронд хэрэгжсэн ижил төстэй төсөл дээр оролцон ажиллаж байсан туршлагатай байх	10
	Цаг уурч	1	Цаг уурч мэргэжлийн магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх, мэргэжилээрээ э 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай	Уур амьсгалын өөрчлөлтийн ирээдүйн хандлагыг загварчлалын аргаар тооцон гаргаж байсан туршлагатай байх	10
	Гидрогеологи	1	Гидрогеологич мэргэжилээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй	Хуурай бүс нутаг, Монгол оронд эсвэл ижил төстэй бүс нутагт газрын доорх усны хайгуул судалгааны чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх,	10

				Монгол оронд хэрэгжсэн ижил төстэй төсөл дээр оролцон ажиллаж байсан туршлагатай	
Геологийн инженер	1	Мэргэжилтэн нь геологийн инженер мэргэжилтэй	Хуурай бүс, Монгол Улс эсвэл ижил төстэй бүс нутагт хэрэгжиж байсан гидравликийн төслийн геологийн хайгуул, судалгааны чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх	10	
Экологич	1	Экологич мэргэжлээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй	Монгол оронд хэрэгжсэн ижил төстэй төслүүдэд оролцон ажиллаж байсан туршлагатай, Олон улсын стандартаар хэрэгжүүлж байсан байгаль орчны нөлөөллийн янз бүрийн шатны үнэлгээний ажилд оролцсон туршлагатай байх	10	
Биологич	1	Биологич мэргэжлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй	Бүс нутгийн биологийн олон янз байдалд үнэлгээ хийж байсан туршлагатай байх	10	
Ургамал судлаач	1	Ургамал судлаач мэргэжлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй	Ижил төстэй төсөл дээр оролцон жилласан бүс нутгийн биологийн олон янз байдалд үнэлгээ хийж байсан туршлагатай байх		
Социологч, нийгэм судлаач	1	Нийгэм судлал эсвэл эдийн засагч мэргэжлээр Магистр болон	Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ болон газар ашиглалт төлөвлөлт,	10	



		түүнээс дээш зэрэгтэй байх	нийгмийн нөлөөллийн үнэлгээний чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх	
Археологич	1	Археологи ба бусад холбогдох мэргэжлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх	Соёлын биет ба биет бус өвийг үнэлэх, холбогдох асуудлаар менежментийн төлөвлөгөө боловсруулах туршлагатай байх	10
Антропологич	1	Антропологи ба бусад холбогдох мэргэжлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй	Төслийн талбайд соёлын эмзэг бүлгийн соёлын биет ба биет бус өвийг үнэлэх, холбогдох асуудлаар менежментийн төлөвлөгөө боловсруулах туршлагатай байх	10
Газар ашиглалтын мэргэжилтэн	1	Газар зохион байгуулалт мэргэжлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй	Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ болон байгалийн нөөц ашиглалтын төлөвлөлт, усны менежмент, газар эзэмшлийн албан ба албан бус тогтолцооны аль алиныг хамарсан төслүүд, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний туршлагатай	5
Газарзүйн мэдээллийн системийн мэргэжилтэн	1	Газарзүй, ус судлал, экологич болон бусад байгаль орчны салбарын мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй	Газарзүйн мэдээллийн системийн мэргэжилтнээр ажилласан, БОАЖ-ын яамны ашигладаг албан ёсны газарзүйн мэдээллийн системийн программ дээр 1-ээс багагүй жил	8

				ажилласан туршлагатай байх	
	Хөрс судлаач	1	Хөрс судлаач мэргэжлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй	Хөрсний тархацын зураглал гаргаж байсан туршлагатай байх, мэдээллийг боловсруулах мэргэжлийн өндөр ур чадвартай байх	10
ТӨЗ 4.4.6	Зөвлөхийн үйлчилгээний хүрээнд хийгдэх тайланг монгол англи хэлээр цаасаар тус бүр 3 хувь бэлтгэж мөн СД хэлбэрээр 4 хувь хүлээлгэн өгнө.				
	Хийгдэх ажлын үндсэн хэсэгт сургалт орсон: <i>Үгүй</i>				
ТӨЗ 4.5	Техникийн санал ирүүлэх хэлбэр нь: <i>Бүрэн хэмжээний техникийн санал байна</i>				
ТӨЗ 4.5.8	<p>Техникийн саналтай холбоотой дараах нэмэлт мэдээллийг ирүүлнэ:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Байгууллагын ерөнхий танилцуулга, байгууллагын Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг нотариатаар баталгаажуулж ирүүлнэ.</li> <li>• Сүүлийн 3 жил буюу 2017, 2018, 2019 онуудын санхүүгийн тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн <a href="http://www.e-balance.mof.gov.mn">www.e-balance.mof.gov.mn</a> мэдээллийн системээс тендерт оролцогчдын санхүүгийн тайлангаас сүүлийн 3 жилийн борлуулалтын орлого, болон бусад шаардлагатай мэдээллийг шалгана.</li> <li>• Сүүлийн 3 жилийн /2017, 2018, 2019 он/ борлуулалтын орлогын дундаж нь батлагдсан төсөвт өртгийн 20 хувиас багагүй байна.</li> <li>• Сүүлийн 3 жилийн аль нэг жилд гүйцэтгэсэн ижил төстэй ажлын туршлагын талаарх мэдээлэл ирүүлнэ. /Гэрээ болон ажил хүлээлгэж өгсөн акт, захиалагчийн тодорхойлолтын хамт ирүүлнэ/</li> <li>• Түншлэлийн гишүүнд техникийн саналтай холбоотой бусад нэмэлт мэдээлэл мөн хамаарна.</li> <li>• Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт,</li> <li>• Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт,</li> <li>• Зөвлөхийн санал болгох ажилтнуудын зөвлөх үйлчилгээ гүйцэтгэсэн ажлын туршлага, мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадварыг нотлох баримтууд. /Ажилчдын мэргэжлийн гэрчилгээ, дипломын хуулбар/</li> </ul>				
ТӨЗ 4.8	<p>Татвар:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Зөвлөх нь ажлыг гүйцэтгэхтэй холбогдон төлөгдөх бүх татвар, хураамжийг төлөх асуудлыг өөрсдөө хариуцна.</li> <li>• Зөвлөхийн ирүүлэх үнийн саналд татвар, хураамж багтсан байна.</li> <li>• Нийгмийн даатгалын газраас хураамж, шимтгэлээ төлсөн тодорхойлолт ирүүлнэ.</li> <li>• Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Татварын байгууллагын тодорхойлолтыг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим систем, Татварын ерөнхий газрын татвар төлөгчдийн мэдээллийн сангаас тендерт оролцогчдын татвар төлөлтийн байдлыг тендер нээсэн өдрийн байдлаар шалгана.</li> <li>• Мөн тендерт оролцогч нь Нийгмийн даатгалын газар, харилцагч банк, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон бусад холбогдох газруудаас лавлагаа авахад татгалзах зүйлгүй тухай албан мэдэгдэл ирүүлнэ.</li> </ul>				
ТӨЗ 4.9	Зөвлөх санхүүгийн саналыг Монгол төгрөгөөр илэрхийлнэ.				
ТӨЗ 4.10	Санхүүгийн санал нь түүнийг ирүүлснээс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.				
ТӨЗ 5.3	Хуулбар хувь ирүүлэх тоо: 0				

ТӨЗ 5.4	<p>Санал хүлээн авах захиалагчийн хаяг: Төрийн худалдан авах ажиллагааны газар.</p> <p>Тендер хүлээн авах этгээд: Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>)-д өөрийн аж ахуйн нэгжийн үндэсний тоон гарын үсгээр нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ.</p> <p>Байгууллагын хаяг: Баянзүрх дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө-16А, Засгийн газрын IX байр, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар</p> <p>Аймаг, хот: Улаанбаатар хот</p> <p>Улс: Монгол улс</p>
ТӨЗ 5.5	Саналыг 2020 оны 06 дүгээр сарын 29-ны өдрийн 11 цагаас өмнө ирүүлсэн байх ёстой.
ТӨЗ 6.2	<p>Үнэлгээний шалгуур үзүүлэлтийн оноо:</p> <p style="text-align: right;">Оноо</p> <p>(1) Зөвлөхийн ажлын даалгаварт заасан ажил, үйлчилгээг гүйцэтгэж байсан тусгайлсан туршлага: <span style="float: right;">[0-30]</span></p> <p><i>Зөвлөхийн үйлчилгээ үзүүлж байсан туршлага-</i> <span style="float: right;">0-10</span></p> <p><i>Компанийн санхүүгийн чадавхи, өр авлагын байдал-</i> <span style="float: right;">0-5</span></p> <p><i>Урьд өмнө гүйцэтгэсэн төсөл үйлчилгээний гэрээ дүгнэсэн актууд, захиалагчийн тодорхойлолт</i> <span style="float: right;">0-15</span></p> <p>(2) Зөвлөхийн санал болгож буй ажлын хөтөлбөр болон аргачлал нь ажлын даалгаврын шаардлагад нийцсэн байдал <span style="float: right;">[0-20]</span></p> <p><i>УЦС-ын төсөлд БОННУ зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр ажилласан туршлага</i> <span style="float: right;">0-15</span></p> <p><i>УЦС-ын төсөлд БОННУ тодотголоор ажилласан</i> <span style="float: right;">0-5</span></p> <p>(3) Төслийн удирдагчийн ур чадвар, туршлага <span style="float: right;">[0-15]</span></p> <p><i>Мэргэжлийн ур чадвар, ижил төстэй зөвлөхийн үйлчилгээний туршлага-</i> <span style="float: right;">0-10</span></p> <p><i>Багийн ахлагчаар ажилласан туршлага, өмнө гүйцэтгэсэн гэрээний биелэлт</i> <span style="float: right;">0-5</span></p>
	<p>(4) Голлох мэргэжилтний мэргэжлийн ур чадвар, туршлага <span style="float: right;">[0-35]</span></p> <p><i>Байгаль орчны үнэлгээний ахлах мэргэжилтэн</i> <span style="float: right;">3</span></p> <p><i>Загас судлаач</i> <span style="float: right;">3</span></p> <p><i>Цэвэр усны экологич/ лимнологич</i> <span style="float: right;">3</span></p> <p><i>Гидрологич</i> <span style="float: right;">2</span></p> <p><i>Биологич</i> <span style="float: right;">2</span></p> <p><i>Цаг уурч</i> <span style="float: right;">2</span></p> <p><i>Гидрогеологи</i> <span style="float: right;">2</span></p> <p><i>Геологийн инженер</i> <span style="float: right;">2</span></p> <p><i>Экологич</i> <span style="float: right;">2</span></p> <p><i>Ургамал судлаач</i> <span style="float: right;">2</span></p> <p><i>Социологч, нийгэм судлаач</i> <span style="float: right;">2</span></p> <p><i>Археологич</i> <span style="float: right;">2</span></p> <p><i>Антропологич</i> <span style="float: right;">2</span></p> <p><i>Газар ашиглалтын мэргэжилтэн</i> <span style="float: right;">2</span></p> <p><i>Газарзүйн мэдээллийн системийн мэргэжилтэн</i> <span style="float: right;">2</span></p>

	<i>Хөрс судлаач</i>	2
	<i>Нийт оноо:</i>	100
Авбал зохих техникийн доод оноо:80 оноо		
ТӨЗ 6.7	Санхүүгийн саналын оноог дараах томъёогоор тооцоолж гаргана: $Sf=100 \times Fm/F$ <i>Sf - санхүүгийн саналын оноо,</i> <i>Fm - хамгийн бага үнэ бүхий санхүүгийн санал,</i> <i>F - тухайн зөвлөхийн санал болгосон үнэ]</i>	
	Техникийн болон санхүүгийн саналын хувийн жин (T+P=1): T= 0.8 P= 0.2	
ТӨЗ 7.1	Хэлэлцээр хийх газрын хаяг: Улаанбаатар хот-17042, Хан-Уул дүүрэг 3-р хороо, Б.Шаравын гудамж “Хан-Уул” цамхаг 10 давхар 1004 тоот	
ТӨЗ 8.2	Зөвлөх үйлчилгээг гэрээ байгуулсан өдрөөс эхлүүлнэ.	
ТӨЗ 9.1	Тохирох маягтын дагуу Гүйцэтгэлийн баталгааг гаргуулж гэрээнд гарын үсэг зурахаас өмнө захиалагчид ирүүлэх шаардлагатай. Гүйцэтгэлийн баталгааны хэмжээ буюу мөнгөн дүн нь гэрээний үнийн дүнгийн 5 хувь байна.	

## Санхүүгийн хэлэлцээр

### Цалин хөлсний үнийн задаргаа

#### Нэг. Цалин хөлс

1.1 Ажилтнуудад олгох цалин хөлсөнд цалин, нийгмийн хамгааллын зардал, нэмэлт зардал, ашиг болон үндсэн ажлын байрнаас гадна ажилласан аливаа томилолтын зардал орно. Санхүүгийн хэлэлцээрт бэлтгэхэд зөвлөхөд туслах зорилгоор цалин хөлсний задаргааг харуулсан жишиг маягтыг хавсаргав (Техникийн саналд үнийн тухай мэдээллийг оруулахгүй). Тохиролцсон цалин хөлсний задаргааг харуулсан хүснэгт нь хэлэлцэж тохирсон гэрээний нэг хэсэг болно.

1.2 Захиалагч хөрөнгийг үр ашигтай зарцуулах зорилгоор зөвлөхийн санхүүгийн санал аль болох бодитой байхад анхаарна. Хэлэлцээрийн үед тухайн зөвлөхийн санал болгосон цалин хөлсийг хөндлөнгийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланд үндэслэж магадлана. Зөвлөх сүүлийн гурван жилийн баталгаажуулсан санхүүгийн тайланг, дүгнэлтийн хамт ирүүлж, түүний санал болгосон цалин хөлс болон бусад үнийг захиалагч нарийвчлан хянах эрхтэй болохыг хүлээн зөвшөөрнө. Цалин хөлсний зардлын задаргааг дор тайлбарласан болно.

#### (1) Цалин

Энэ нь зөвлөхийн ажилтнуудын үндсэн ажлын байранд ажилласан нийт үндсэн цалин. Энэ зардалд томилолтын хөлс, шагнал, урамшуулал (хууль, тогтоомжид өөрөөр заагаагүй бол)-ыг оруулахгүй.

#### (2) Шагнал

Шагналыг ихэвчлэн ашгаас төлдөг. Иймд ажилтнуудад олгох шагналыг цалин хөлсний зардалд оруулахгүй. Зөвлөхийн үндсэн үйл ажиллагаа явуулж буй улсын нягтлан бодох бүртгэлийн систем нь нийгмийн хамгааллын болон бусад зардлыг нийт орлогоос хувиар тооцдог бол эдгээр хувиудыг үндэслэж тооцно. Тухайн орны төрийн бодлогын хэмжээнд ажилтанд 13 дахь сарын цалинг төлөхийг шаарддаг бол түүнээс ашиг тооцохгүй. Шагналтай холбоотой асуудлыг аудитаар баталгаажуулсан баримт бичигт үндэслэн хэлэлцэх ба эдгээр баримт бичгийн нууцлалыг хадгална.

#### (3) Нийгмийн хамгааллын зардал

Нийгмийн хамгааллын зардал нь ажилтнуудад мөнгөн бус хэлбэрээр очих урамшуулал юм. Үүнд тэтгэврийн, эрүүл мэндийн болон амь насны даатгалаас гадна түр хүчээ алдсаны тэтгэмж болон амралтын цалин хамаарна. Зөвлөхийн үйлчилгээний хугацаанд нийтээр амрах баяр ёслолын өдрийн цалин болон ажилтан орлон ажиллаагүй зардлыг нийгмийн хамгааллын зардалд оруулахгүй.

#### (4) Чөлөөний зардал

Үндсэн цалинд харьцах жилийн чөлөөний зардлыг дараах байдлаар тооцно:

$$\text{Чөлөөний зардал (цалингаас бодох \%)} = \frac{\text{нийт чөлөөний хоног} * 100}{[365 - w - ph - v - s];}$$

Зөвхөн захиалагч чөлөөний зардлыг тусад нь төлөхгүй бол энэ зардлыг нийгмийн хамгааллын зардалд оруулдаг болохыг анхаарах хэрэгтэй.

## **(5) Нэмэлт зардал**

Нэмэлт зардал гэдэг нь тухайн зөвлөхийн үйлчилгээг гүйцэтгэхэд гарсан зардалтай шууд холбоогүй, гэрээнд тусгай зүйл болж нөхөн төлөгдөхгүй, тухайн зөвлөхийн бизнесийн зардлыг хэлнэ.Нэмэлт зардалд ихэвчлэн ажлын байранд гарсан зардал (хамтрагчийн ажилласан цаг, цалингүй ажилласан цаг, ахлах ажилтны төслийг удирдахад зарцуулсан цаг, түрээс, туслах ажилтан, судалгаа шинжилгээ, сургалт, маркетингийн зэрэг зардал), ашгийн төлөө төсөлд ажиллаагүй ажилтны зардал болон бизнесийн урамшууллын зардлууд багтана.Зөвлөх хэлэлцээрийн үед хөндлөнгийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан болон сүүлийн гурван жилийн нэмэлт зардлыг зүйл бүрээр ангилж, үндсэн цалинд харьцах хувийг гарган, хэлэлцээр хийх үед танилцуулах боломжтой байх ёстой.Захиалагч зөвлөхийн үндсэн бус ажилтны нийгмийн болон нэмэлт гэх мэт зардлыг хүлээн зөвшөөрөхгүй.Энэ тохиолдолд зөвхөн захиргааны зардал болон туслах гэрээгээр ажиллах ажилтанд олгох сар бүрийн төлбөрийг оруулан тооцож болно.

## **(6) Ашиг**

Цалин, нийгмийн хамгааллын зардал болон нэмэлт зардлын нийлбэрээс ашгийг тооцно.Тогтмол олгодог шагнал байгаа бол түүнийг ашгаас хасч тооцно.Нөхөн төлөгдөх зардлаас өндөр үнэтэй тоног төхөөрөмж худалдан авахаас бусад тохиолдолд дээрх зардал болон томилолтын зардлаас ашиг тооцохгүй.Захиалагч гэрээний төсөлд заасны дагуу урьдчилан тохиролцож тооцсон төлбөрийн хуваарийг үндэслэн төлбөрийг хийнэ гэдгийг анхаарах ёстой.

## **(7) Томилолтын зардал**

Зарим зөвлөх төв байрнаас гадна ажиллаж буй ажилтанд томилолтын зардал олгодог.Энэ зардал нь цалингийн хувиар тооцогдох ба түүн дээр нэмэлт зардал болон ашиг нэмж тооцохгүй.Зарим орны хуулиар томилолтын зардлаас нийгмийн хамгааллын зардлыг тооцдог.Энэ тохиолдолд томилолтын зардал болон түүнээс бодогдсон нийгмийн хамгааллын зардлыг нийт нийгмийн хамгааллын зардалд тусгай зүйл болгон харуулна.Холбогдох ажилтны хувьд энэ зардалд гэрээр боловсрол эзэмших зэрэг зардлууд орсон байх ба уг зардал болон түүнтэй адилтгах зүйлсийг нөхөн төлөгдөх зардал гэж үзэхгүй.

## **(8) Өдөр хоногийн зардал**

Өдөр хоногийн зардлыг цалин хөлсөнд оруулалгүй тусгай зүйл болгон төгрөгөөр төлбөрийг хийнэ.Энэ зардлыг ажилтны тэтгэмжид байдаг хүмүүст төлөхгүй бөгөөд гэр бүлтэй, гэр бүлгүй гэж ялгалгүй адил төлнө.

### **Хоёр. Нөхөн төлөгдөх зардал**

2.1 Санхүүгийн хэлэлцээрээр нөхөн төлөгдөх зардлыг авч хэлэлцэнэ.Эдгээр зардалд судалгаа, тоног төхөөрөмж, байрны түрээс, бичиг хэрэг, олон улсын болон орон нутгийн аялал, компьютерийн түрээс, ажлыг эхлүүлэх, дуусгах, даатгал, хэвлэх болон бусад зардлуудыг хамруулж болно.Эдгээр зардал нь тогтмол, эсхүл нөхөн төлөгдөхөөр байх ба гадаадын болон үндэсний валютаар илэрхийлэгдсэн байж болно.

### **Гурав. Банкны баталгаа**

3.1Зөвлөхөд төлөх төлбөр болон аливаа урьдчилгаа төлбөр нь урьдчилан тохиролцсон төлбөрийн хуваарь болон ажил, үйлчилгээ нь төлөвлөгөөний дагуу явагдаж буйд үндэслэн дотоод болон гадаад валютаар хийгдэнэ.Урьдчилгаа төлбөр нь урьдчилан тооцсон бэлэн мөнгөний урсгалын тооцоонд үндэслэн хийгдэх бөгөөд банкны баталгаагаар баталгаажсан байна.

[Төслийн нэр:]

[Зөвлөх үйлчилгээний нэр]

ТОХИРОЛЦСОН ЦАЛИН ХӨЛСНИЙ ЗАДАРГАА

[Валют: \_\_\_\_\_]

Зөвлөх	1	2	3	4	5	6	7	8
Нэр, албан тушаал	Үндсэн цалин	Нийгмийн хамгааллын зардал (1*%)	Нэмэлт зардал (1*%)	Бүгд	Ашиг (4*%)	Томилолт (1*%)	Тохиролцсон нийт цалин хөлс	Нэгж цалин хөлс (1-ийн_%)
Томилолт								
Ажлын байр								

Зөвлөхийн гарын үсэг: \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ / Огноо: \_\_\_\_\_

Эрх бүхий этгээдийн гарын үсэг \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /

Нэр: \_\_\_\_\_

Албан тушаал: \_\_\_\_\_

## ТЕХНИКИЙН САНАЛ – ЖИШИГ МАЯГТУУД

- 3.1. Техникийн санал ирүүлэх маягт
- 3.2. Зөвлөхийн танилцуулга
- 3.3. Ажлын даалгавар болон захиалагчийн үзүүлэх үйлчилгээ, мэдээлэл, байгууламжийн талаарх зөвлөхийн санал, зөвлөмж
- 3.4. Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх ажлын хөтөлбөр болон аргачлалын талаарх танилцуулга
- 3.5. Багийн бүрэлдэхүүн болон ажлын хуваарилалт
- 3.6. Санал болгож буй мэргэжилтний намтар(CV)-ын жишиг маягт
- 3.7. Ажиллах хүчний ажиллах хуваарь
- 3.8. Ажлын хуваарь



### 3.1. ТЕХНИКИЙН САНАЛ ИРҮҮЛЭХ МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

Танай [он, сар, өдөр]-ийн зөвлөх үйлчилгээний тендерийн баримт бичиг болон өөрсдийн энэ саналын дагуу бид [Зөвлөхийн үйлчилгээний нэр] үзүүлэхээр санал болгож байна. Бид техникийн болон санхүүгийн саналаа тус тусад нь битүүмжилсэн дугтуйд хийж үүгээр хүргүүлж байна.

Саналын хүчинтэй байх хугацаа тендерийн санал хүргүүлсэнээс хойш 45 хоногийн дотор буюу [он, сар, өдөр]-аас өмнө хэлэлцээр хийгдэх бол санал болгож буй ажилтнуудад үндэслэж оролцоно. Гэрээний хэлэлцээрийн үр дүнд өөрчлөлт оруулахаас бусад тохиолдолд энэхүү санал өөрчлөгдөхгүй.

Ирсэн аливаа саналаас та татгалзах эрхтэй болохыг бид хүлээн зөвшөөрч байна.

Хүндэтгэсэн,

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Зөвлөх үйлчилгээний байгууллагын нэр:

Хаяг:

### 3.2. ЗӨВЛӨХИЙН ТАНИЛЦУУЛГА

#### Байгууллагын чадварыг харуулж чадах сүүлийн 5 жилд үзүүлсэн ижил, төстэй үйлчилгээний мэдээлэл

Доорх хүснэгтийн дагуу танай байгууллагын дангаараа болон хамтарч албан ёсоор үзүүлсэн үйлчилгээ бүрийн тухай мэдээлнэ үү.

Зөвлөх үйлчилгээний нэр:		Улсын нэр:
Байршил:		Танай байгууллагаас ажилласан мэргэжилтэн (чиглэл):
Захиалагчийн нэр:		Ажилтны тоо:
Хаяг:		Гүйцэтгэсэн ажлын хугацаа, хүнс-сарын тоо:
Эхэлсэн он сар өдөр:	Дууссан он сар өдөр:	Зөвлөх үйлчилгээний өртөг (сая төгрөгөөр) ойролцоогоор:
Түншлэн ажилласан зөвлөхийн нэр (хэрэв байвал):		Түншлэн ажилласан зөвлөхийн ажилтнуудын ажилласан сарын тоо:
Голлох мэргэжилтэн: (Төслийн удирдагч/зохицуулагч, төслийн ахлагч)-ийн гүйцэтгэсэн ажил, үүргүүд:		
Төслийн талаарх товч танилцуулга:		
Төслийн хүрээнд танай ажилтны гүйцэтгэсэн үндсэн үйлчилгээний талаарх танилцуулга:		

Зөвлөх компанийн нэр: \_\_\_\_\_

**3.3. АЖЛЫН ДААЛГАВАР БОЛОН ЗАХИАЛАГЧИЙН ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ,  
МЭДЭЭЛЭЛ, БАЙГУУЛАМЖИЙН ТАЛААРХ  
ЗӨВЛӨХИЙН САНАЛ, ЗӨВЛӨМЖ**

Ажлын даалгаврын хувьд:

- 1.
- 2.

Захиалагчийн үзүүлэх үйлчилгээ, мэдээлэл, байгууламжийн хувьд:

- 1.
- 2.

**3.4. ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭГ ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ХӨТӨЛБӨР  
БОЛОН АРГАЧЛАЛЫН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА**

---

**3.5. БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН БОЛОН АЖЛЫН ХУВААРИЛАЛТ**

<b>1. Техникийн болон удирдах ажилтнууд</b>			
Нэр	Албан тушаал	Ажлын туршлага	Хариуцах ажил

<b>2. Туслах ажилтнууд</b>			
Нэр	Албан тушаал	Ажлын туршлага	Хариуцах ажил

### 3.6. САНАЛ БОЛГОЖ БУЙ МЭРГЭЖИЛТНИЙ НАМТАР(СV)-ЫН ЖИШИГ МАЯГТ

Санал болгож буй албан тушаал: \_\_\_\_\_

Байгууллагын нэр: \_\_\_\_\_

Мэргэжилтний нэр: \_\_\_\_\_

Мэргэжил: \_\_\_\_\_

Төрсөн он, сар, өдөр: \_\_\_\_\_

Тухайн байгууллагад ажилласан жил: \_\_\_\_\_ Иргэншил: \_\_\_\_\_

Мэргэжлийн холбооны гишүүнчлэл: \_\_\_\_\_

Хариуцах ажил: \_\_\_\_\_

#### Ур чадварын:

*[Хариуцах ажлын чиглэлээр туршлагажсан, сургалтад хамрагдсан байдлыг товч харуулна.Өмнө гүйцэтгэж байсан ижил төрлийн зөвлөх үйлчилгээнд хариуцаж байсан ажил, хугацаа, байршлыг зааж харуулах.Эдгээр мэдээллийг хагас хуудсанд багтааж бичнэ.]*

#### Боловсрол:

*[Мэргэжилтний их, дээд сургууль, коллеж болон бусад эзэмшсэн мэргэжлийн боловсролын байдал, сургуулийн нэрс, оролцсон/дүүргэсэн хугацаа болон хамгаалсан эрдмийн зэргийн хамт нэгтгэж харуулах.Эдгээр мэдээллийг хуудасны дөрөвний нэгт багтааж бичнэ.]*

#### Ажилласан туршлага:

*[Өнөөгийн байдлаас эхлэн эсрэг дарааллаар ажилласан туршлагыг бич.Сургууль төгссөнөөс хойш ажилласан бүх албан тушаалын нэр, ажил эрхэлсэн хугацаа, ажил олгогч байгууллага, байршил зэргийг бичнэ.Сүүлийн 10 жилийн туршлагын хувьд гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ болон шаардлагатай бол харилцагчийн тодорхойлолтыг хавсаргана.Эдгээр мэдээллийг бичгийн 2 хуудсанд багтаан бичнэ.]*

#### Хэлний мэдлэг:

*[Эзэмшсэн хэлний мэдлэгийн түвшинг ярих, унших, бичих тус бүрт онц, сайн, дунд эсхүл муу гэж тодорхойлно.]*

#### Батламж:

Дээрх мэдээлэл нь миний мэдлэг, чадвар, туршлагыг үнэн зөв харуулсан болохыг үүгээр баталж байна.

Мэргэжилтний овог, нэр, гарын үсэг: \_\_\_\_\_

Огноо: \_\_\_\_\_

Эрх бүхий этгээдийн овог, нэр, гарын үсэг: \_\_\_\_\_ Огноо: \_\_\_\_\_

### 3.7. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ АЖИЛЛАХ ХУВААРЬ

Нэр	Албан тушаал	Тайлан гаргах	Сарууд (хөндлөн зураасаар тэмдэглэх)												Сар	
			1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12		
Гадаадын зөвлөх																
1																
2																
3																
Дотоодын зөвлөх																
1																
2																
3																

Үндсэн ажилтнаар: \_\_\_\_\_  
 Тайлангийн тоо: \_\_\_\_\_  
 Гүйцэтгэх хугацаа: \_\_\_\_\_

Цагийн ажилтнаар: \_\_\_\_\_

Гарын үсэг: \_\_\_\_\_  
 (Эрх бүхий этгээдийн)

Овог нэр: \_\_\_\_\_

Албан тушаал: \_\_\_\_\_

Хаяг: \_\_\_\_\_

### 3.8 АЖЛЫН ХУВААРЬ

#### А. Ажлын талбайд хийх шинжилгээ, судалгаа

	<i>[Зөвлөхийн үйлчилгээг эхэлсэн нэг дэх сар, хоёр дахь сар гэх мэт]</i>											
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Үйл ажиллагаа (ажлууд)												
-----												
-----												
-----												
-----												
-----												

#### В. Ажлыг дуусгаж тайлан өгөх

Тайлан	Он, сар, өдөр
1. Эхлэлийн тайлан	
2. Явцын тайлан (а) 1 дэх тайлан (б) 2 дахь тайлан	
3. Тайлангийн төсөл	
4. Эцсийн тайлан	

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.

САНХҮҮГИЙН САНАЛ - ЖИШИГ МАЯГТУУД

- 4.1. Санхүүгийн санал өгөх маягт
- 4.2. Зардлын товчоо
- 4.3. Үйл ажиллагаа бүрийн үнийн задаргаа
- 4.4. Үйл ажиллагаа бүрийн цалин хөлсний задаргаа
- 4.5. Үйл ажиллагаа бүрийн нөхөн төлөгдөх зардал

#### 4.1. САНХҮҮГИЙН САНАЛ ИРҮҮЛЭХ МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

Танай [он, сар, өдөр]-ийн зөвлөх үйлчилгээний тендерийн баримт бичиг болон өөрсдийн энэ саналын дагуу бид [зөвлөхийн үйлчилгээний нэр]-г [санхүүгийн саналын дүнг тоогоор болон үсгээр бичнэ] төгрөгөөр гүйцэтгэхээр санал болгож байна. Энэ үнэд [татварын дүнг тоогоор болон үсгээр] төгрөгийн дотоодын татвар, хураамж орсон болно.

Саналын хүчинтэй байх хугацаань санал хүргүүлсэнээс хойш 45 хоногт буюу [он, сар, өдөр]-аас өмнө хийгдэх гэрээний хэлэлцээрийн үр дүнд өөрчлөлт оруулахаас бусад тохиолдолд бидний санхүүгийн санал өөрчлөгдөхгүй.

Ирсэн аливаа саналаас та татгалзах эрхтэй болохыг бид хүлээн зөвшөөрч байна.

Хүндэтгэсэн,

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Зөвлөх үйлчилгээний байгууллагын нэр:

Хаяг:



#### 4.2. ЗАРДЛЫН ТОВЧОО

Зардал	Валют	Дүн
----- ----- -----		
Дүн		
Дотоодын татвар, хураамж		
Санхүүгийн саналын нийт дүн		_____

#### 4.3. ҮЙЛ АЖИЛЛАГАА БҮРИЙН ҮНИЙН ЗАДАРГАА

Үйл ажиллагааны № \_\_\_\_\_ нэр \_\_\_\_\_

Үнэ	Валют	Дүн
Цалин хөлс		
Нөхөн төлөгдөх зардал		
Магадлашгүй зардал		
Бүгд		_____

#### 4.4. ҮЙЛ АЖИЛЛАГАА БҮРИЙН ЦАЛИН ХӨЛСНИЙ ЗАДАРГАА

Үйл ажиллагааны № \_\_\_\_\_ нэр \_\_\_\_\_

Нэрс	Албан тушаал	Оролцоо	Цалин хөлсний нэгж үнэ	Дүн
Үндсэн ажилтнууд				
Дотоодын ажилтнууд				
Зөвлөхүүд				
Бүгд дүн				_____

#### 4.5. ҮЙЛ АЖИЛЛАГАА БҮРИЙН НӨХӨН ТӨЛӨГДӨХ ЗАРДАЛ

Үйл ажиллагааны № \_\_\_\_\_ нэр \_\_\_\_\_

№	Зардлын зүйл	Нэгж	Тоо, хэмжээ	НБҮнэ	Нийт дүн
1.	Олон улсын нислэг _____	Аялал			
2.	Аялалын бусад зардал	Аялал			
3.	Томилолтын зардал	Өдөр			
4.	Дотоодын тээврийн зардал				
5.	Байрны түрээс (буудлын зардал)				
	Бүгд дүн				_____

## БҮЛЭГ 5. АЖЛЫН ДААЛГАВАР

**БҮЛЭГ 6. ГЭРЭЭНИЙ ЖИШИГ МАЯГТ**

**МОНГОЛ УЛСЫН  
САНГИЙН ЯАМ**

**ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ГЭРЭЭНИЙ ЗАГВАР  
(НИЙТ ҮНЭД ҮНДЭСЛЭСЭН ГЭРЭЭ)**

**ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ  
БОДЛОГЫН ГАЗАР**

Улаанбаатар  
2013 он



## Агуулга

Оршил .....	<u>80</u>
I. Гэрээний загвар.....	<u>81</u>
II. Гэрээний ерөнхий нөхцөл (ГЕН).....	<u>85</u>
1. Ерөнхий заалт.....	<u>85</u>
1.1 Нэр томъёоны тайлбар.....	<u>85</u>
1.2 Гэрээнд хэрэглэгдэх хууль.....	44
1.3 Гэрээний хэл .....	45
1.4 Мэдэгдэл .....	45
1.5 Байрлал.....	45
1.6 Төлөөлөх эрх бүхий гишүүний эрх хэмжээ .....	45
1.7 Итгэмжлэгдсэн төлөөлөгч .....	45
1.8 Татвар, хураамж .....	<u>86</u>
1.9 Авилга болон залилан мэхлэх үйлдэл .....	<u>86</u>
2. Гэрээ эхлэх, дуусгавар болох, түүнд өөрчлөлт оруулах ба цуцлах .....	<u>87</u>
2.1 Гэрээ хүчин төгөлдөр болох.....	45
2.2 Үйлчилгээ эхлэх .....	45
2.3 Гэрээний хугацаа дуусгавар болох .....	46
2.4 Гэрээний өөрчлөлт буюу засвар.....	46
2.5 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл.....	46
2.6 Гэрээг цуцлах .....	46
3. Зөвлөхийн хүлээх үүрэг .....	<u>89</u>
3.1 Ерөнхий зүйл.....	47
3.2 Ашиг сонирхолын зөрчил .....	<u>89</u>
3.3 Нууцлал .....	<u>89</u>
3.4 Зөвлөхийн хийвэл зохих даатгал .....	<u>89</u>
3.5 Захиалагчаас урьдчилан зөвшөөрөл авах Зөвлөхийн үйл ажиллагаа .....	<u>89</u>
3.6 Тайлан .....	48
3.7 Зөвлөхийн бэлтгэсэн баримт бичиг нь Захиалагчийн өмч болох нь .....	48
3.8 Нягтлан бодох бүртгэл, Хяналт шалгалт болон Аудит .....	48
4. Зөвлөхийн ажиллах хүчин .....	<u>90</u>
4.1 Ажиллах хүчний тодорхойлолт .....	48
4.2 Ажиллах хүчнийг халах эсвэл солих .....	49
5. Захиалагчийн хүлээх үүрэг .....	<u>91</u>
5.1 Туслалцаа болон Зөвшөөрөл олгох.....	49
5.2 Гэрээнд хэрэглэх хуулинд татвар болон хураамжийн талаар орсон өөрчлөлт.....	49
5.3 Захиалагчийн үзүүлэх үйлчилгээ, байгууламж.....	49

6. Зөвлөхөд төлөх төлбөр .....	<u>91</u>
6.1 Нийт үнэд үндэслэсэн төлбөр.....	49
6.2 Гэрээний үнэ .....	50
6.3 Нэмэлт үйлчилгээний төлбөр .....	50
6.4 Төлбөр хийх хугацаа, болзол.....	50
6.5 Хугацаа хоцорсон төлбөрийн хүү .....	50
7. Шударга байдал .....	<u>92</u>
7.1 Шударга байдал.....	50
8. Маргааныг шийдвэрлэх.....	<u>92</u>
8.1 Эв зүйгээр шийдвэрлэх .....	50
8.2 Маргаан шийдвэрлэх.....	50
III. Гэрээний тусгай нөхцөл (ГТН).....	<u>93</u>
IV. Хавсралт .....	<u>96</u>
Хавсралт №1 – Ажлын даалгавар, Үйлчилгээний цар хүрээ .....	<u>96</u>
Хавсралт №2 – Тайлан гаргах хуваарь .....	<u>96</u>
Хавсралт №3 – Голлох мэргэжилтэн болон туслан гүйцэтгэгч.....	<u>96</u>
Хавсралт №4 – Үйлчилгээний төсөвт өртөг (Гадаад мөнгөн тэмдэгтээр).....	<u>96</u>
Хавсралт №5 - Үйлчилгээний төсөвт өртөг (Төгрөгөөр) .....	<u>97</u>
Хавсралт №6 - Захиалагчийн үзүүлэх үйлчилгээ, байгууламж, тоног төхөөрөмж.....	<u>97</u>
Хавсралт №7 – Урьдчилгаа төлбөрийн баталгааны маягт .....	54

Зөвлөх үйлчилгээний гэрээ

Нийт үнэд үндэслэсэн

---

[Захиалагчийн нэр]

болон

---

[Зөвлөхийн нэр]

Огноо: \_\_\_\_\_



**БАТЛАВ**

**ЗАХИАЛАГЧ**

*Салбарын яам*

**ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА**

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)  
тушаал)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

**ГҮЙЦЭТГЭГЧ**

*Аж ауйн нэгж*

**ЗАХИРАЛ**

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан

*[Зөвлөх үйлчилгээний нэр]*гэрээ.

**Дугаар № [гэрээний дугаар]**

---

**хот/аймаг**

Нэг талаас *[захиалагчийн нэр]* (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас *[зөвлөхийн нэр]* (цаашид “зөвлөх” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Зөвлөх нь энэхүү гэрээ болон гэрээний салшгүй хэсэг болох Хавсралт №-д тодорхойлсон “Ажлын даалгавар болон үйлчилгээний цар хүрээ”-нд заасан зөвлөх үйлчилгээг (цаашид “үйлчилгээ” гэх) үзүүлэх үүрэгтэй.
2. Зөвлөх нь захиалагчаас шаардаж буй мэргэжлийн дадлага туршлага, ажиллах хүчин болон техникийн эх үүсвэртэй бөгөөд гэрээнд заасан нөхцөл, болзлын дагуу үйлчилгээг үзүүлэхийг хүлээн зөвшөөрсөн болно.
3. Захиалагч нь *[гэрээний нэр, дугаар]*-г (цаашид “ажил” гэх) *[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]* (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн Зөвлөхийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
4. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
  - Гэрээний ерөнхийн өхцөл;
  - Гэрээний тусгай нөхцөл;
  - Хавсралт
  - Хавсралт №1 Ажлын даалгавар, үйлчилгээний цар хүрээ
  - Хавсралт №2 Тайлан гаргах хуваарь
  - Хавсралт №3 Ажиллах хүчин-Туслан гүйцэтгэгч-Голлох Мэргэжилтний ажлын хуваарь
  - Хавсралт №4 Гадаад мөнгөн тэмдэгтээр тодорхойлсон төсөвт өртөг
  - Хавсралт №5 Төгрөгөөр тодорхойлсон төсөвт өртөг
  - Хавсралт №6 Захиалагчийн хүлээх үүрэг
  - Хавсралт №7 Урьдчилгаа төлбөрийн загварын маягт

[Тэмдэглэл: Дээр дурдсан хавсралтаас тухайн гэрээнд хэрэглэхгүй тохиолдолд түүнийг хасч бичнэ. ]

Гэрээ нь энд дурдсан Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно.

5. Захиалагч болон зөвлөх нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.
6. Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага нь гэрээний хэрэгжилт, ажлын явц, гүйцэтгэлтэй танилцаж болох бөгөөд шаардлагатай тохиолдолд гэрээний ерөнхий нөхцлийн 2, 8 дугаарт заасныг шийдвэрлэхэд оролцоно.
7. Зөвлөх нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
8. Захиалагч нь гэрээний дагуу Зөвлөхийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ  
ТӨЛӨӨЛЖ:**

**ТӨСВИЙН  
ЕРӨНХИЙЛӨН  
ЗАХИРАГЧ**

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ  
ТӨЛӨӨЛЖ:**

**АЖ АУЙН НЭГЖ**

ТАМГА

(Захиалагчийн хаяг) (ХАА-ны газрын хаяг)

(Утас/факсны дугаар) (Утас/факсны дугаар)

(Харилцагч банкны нэр, дансны дугаар)(Харилцагч банкны нэр, дансны дугаар)

ТАМГА

(Гүйцэтгэгчийн хаяг)

(Утас/факсны дугаар)

ТАМГА

## II. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

## 1. ЕРӨНХИЙ ЗААЛТ

### 1.1 Нэр томъёоны тайлбар

1.1 Энэ гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

- (а) “Гэрээнд хэрэглэх хууль” гэж Гэрээний тусгай нөхцөл ГТН-д заасан Монгол улсын хүчин төгөлдөр хууль болон бусад эрх зүйн актыг хэлнэ.
- (б) “ Зөвлөх” гэж захиалагчтай байгуулсан энэхүү гэрээнд заасан үйлчилгээг үзүүлж байгаа аливаа хувийн болон төрийн хуулийн этгээдийг хэлнэ.
- (в) “Гэрээ” гэж талуудын гарын үсэг зурсан гэрээний маягт болон түүний 1 дүгээр заалтад дурдсан бусад баримт бичгүүд болох Гэрээний ерөнхий нөхцөл, Гэрээний тусгай нөхцөл болон хавсралт баримт бичгүүдийг хэлнэ.
- (г) “Хоног” гэж хуанлийн хоногийг хэлнэ.
- (е) “Гэрээ хүчин төгөлдөр болох огноо” гэж ГЕН-ийн 2.1-д заасан гэрээ хүчин төгөлдөр болох огноог хэлнэ.
- (д) “Гэрээний үнэ” гэж ГЕН-ийн 6 дугаар зүйлд заасны дагуу Үйлчилгээний гүйцэтгэлийн төлөө Зөвлөхөд төлөх төлбөрийн хэмжээг хэлнэ.
- (е) “ГЕН” гэж Гэрээний ерөнхий нөхцлийг хэлнэ.
- (ё) “Гишүүн” гэж түншлэл/консорциум/холбоог бүрдүүлж байгаа аль нэгэн хуулийн этгээдийг “ Гишүүд” гэж эдгээр хуулийн этгээдийг хамтад нь хэлнэ.
- (ж) “Гэрээний тал гэж” Захиалагч эсхүл Зөвлөхийн аль нэгийг, харин “Талууд” гэж хоёуланг нь хэлнэ.
- (з) “Нөхөн төлөх зардал” гэж зөвлөхийн ажлын хөлснөөс бусад үйл ажилгаатай холбоотой бүх зардлуудыг хэлнэ.
- (л) “ГТН” гэж гэрээний ерөнхий нөхцөлийг тодотгож байгаа Гэрээний тусгай нөхцлийг хэлнэ.
- (м) “Үйлчилгээ” гэж Хавсралт №1-т тодорхойлсон, энэхүү гэрээнд заасны дагуу Зөвлөхийн хийж гүйцэтгэвэл зохих ажлыг хэлнэ.
- (о) “Туслан гүйцэтгэгч” гэж үйлчилгээний аль нэгэн хэсгийг туслан гүйцэтгэхээр Зөвлөхтэй гэрээ байгуулсан хувь хүн, хуулийн этгээдийг хэлнэ.
- (ө) “Ажиллах хүчин ” гэж Үйлчилгээ буюу түүний аль нэгэн хэсгийг гүйцэтгүүлэхээр Зөвлөхийн эсхүл туслан гүйцэтгэгчийн хөлсөлсөн хувь хүнийг хэлнэ.

### 1.2 Гэрээнд хэрэглэгдэх хууль

Энэхүү гэрээ, түүний агуулга болон тайлбар, мөн талуудын харилцааг ГТН-д заасан хууль тогтоомжоор зохицуулна.

- 1.3 Гэрээнд ашиглах хэл** Энэхүү гэрээ нь ГТН-д заасан улсын хэл дээр боловсруулагдсан бөгөөд гэрээний агуулга, тайлбартай холбоотой бүх асуудалд уг хэлийг ашиглана. Талууд хоорондын харилцах бичиг баримт нь энэ хэл дээр байна.
- 1.4 Мэдэгдэл** Энэхүү гэрээний дагуу олгогдсон эсхүл шаардагдах аливаа мэдэгдэл, хүсэлт буюу зөвшөөрөл зэргийг бичгээр үйлдсэн байх ёстой. Эдгээр мэдэгдэл, хүсэлт буюу зөвшөөрөл нь харилцаж байгаа талын итгэмжлэгдсэн төлөөлөгчид биечлэн хүргэгдсэн эсхүл ГТН-д заасан хаягаар илгээсэн тохиолдолд олгогдсон гэж тооцогдох ёстой.
- 1.5 Байршил** Үйлчилгээг, гэрээний хавсралт №1-т заасан нутаг дэвсгэрт, хэрэв тодорхой төсөл арга хэмжээний байрлалыг заагаагүй тохиолдолд захиалагчийн харъяа улс эсхүл түүний тодорхойлж өгсөн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх ёстой.
- 1.6 Төлөөлөх эрх бүхий гишүүний эрх хэмжээ** Зөвлөх нь түншлэл/консорциум/ хоёр буюу түүнээс дээш хуулийн этгээдийн холбооноос бүрдэж байгаа тохиолдолд, эдгээр гишүүд гэрээний дагуу захиалагчтай үүсэх харилцаанд бүх гишүүний нэрийн өмнөөс оролцох, эрх хэрэгжүүлэх болон үүрэг хүлээх, зааварчилгаа болон төлбөр хүлээн авахад тэднийг төлөөлөх эрх бүхий нэг гишүүнийг томилно.
- 1.7 Итгэмжлэгдсэн төлөөлөгч** Гэрээний дагуу захиалагч эсхүл зөвлөхийн гүйцэтгэвэл зохих аливаа үйл ажиллагаа болон баримт бичгийг ГТН-д заасан албан тушаалтан хариуцан хийнэ.
- 1.8 Татвар, хураамж** Зөвлөх, туслан гүйцэтгэгч болон тэдгээрийн ажиллах хүчин нь ГТН-д заасан гэрээнд хэрэглэх хуулийн дагуу төлбөл зохих татвар, хураамж болон төлбөрийг төлөх ёстой.
- 1.9 Авилгал болон залилан мэхлэх үйлдэл** Захиалагчийг төлөөлөн худалдан авах ажиллагаанд оролцож байгаа төрийн албан хаагч болон тендерт оролцогч, гэрээ хэрэгжүүлэгч зөвлөх бүр худалдан авах ажиллагаанд оролцох, худалдан авах гэрээг хэрэгжүүлэхдээ ёс суртахууны өндөр хэм хэмжээг сахин биелүүлэх ёстой.

Худалдан авах ажиллагаанд оролцож байгаа төрийн албан хаагч болон зөвлөх нь Авилгын эсрэг хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авилгал, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлган сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон талаар бодитой мэдээлэл байгаа бол холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад зохих ёсоор мэдэгдэнэ.

## **2. ГЭРЭЭ ЭХЛЭХ, ДУУСГАВАР БОЛОХ, ТҮҮНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ БОЛОН ЦУЦЛАХ**

- 2.1 Гэрээ хүчин төгөлдөр болох** Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурсан, эсхүл ГТН-д заасан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Гэрээг хүчин төгөлдөр болох өдрийг гэрээ хүчин төгөлдөр болох огноо гэж хэлнэ.
- 2.2 Үйлчилгээг эхлэх** Зөвлөх нь гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш ГТН-д заасан хоногт багтаан үйлчилгээг эхлэх ёстой.

- 2.3 Гэрээний хугацаа дуусгавар болох** ГЕН-ийн 2.6-д заасны дагуу цуцлагдаагүй бол гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш ГТН-д заасан хугацааны дараагаар энэхүү гэрээний хугацаа дуусгавар болно.
- 2.4 Гэрээний өөрчлөлт буюу засвар** Гагцхүү бичгээр үйлдэн талууд гарын үсэг зурж баталгаажуулсан тохиолдолд гэрээний нөхцөл, болзол болон үйлчилгээний цар хүрээг засварлах, эсхүл өөрчилж болно.
- 2.5 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл** 2.5.1 Дайн, иргэний бослого, түймэр, үер, халдварт өвчин, газар хөдлөлт, хорио цээр, тээврийн хориг болон бусад гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдалүүссэнээс захиалагч, эсхүлнийлүүлэгч, эсхүлтуслангүйцэтгэгчийнгэрээнийүүргийнгүйцэтгэлхугацаааахоцорсонбол талууд тохиролцон гүйцэтгэххугацаагсунгана.

Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэн тохиолдолд нийлүүлэгч нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ. Захиалагч бичгээр өөрөөр зааварлаагүй бол Зөвлөх гэрээний үүргээ боломжтой хэмжээнд үргэлжлүүлэн гүйцэтгэж, гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлаас үл шалтгаалан гэрээг хэрэгжүүлэх боломжит арга замыг хайна.

## **2.6 Гэрээ цуцлах**

### **2.6.1 Захиалагч гэрээг цуцлах**

Энэхүү зүйлд заасан дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд захиалагч өөрийн санаачлагаар гэрээг цуцлах эрхтэй.

- (а) Зөвлөх гэрээний дагуу хүлээсэн үүргээ зөрчсөн талаарх мэдэгдлийг хүлээн авсны дараагаар 30 хоног, эсхүл захиалагчийн бичгээр зөвшөөрөн сунгасан хугацаанд багтаан мэдэгдэлд дурдсан зөрчлийг арилган үүргийн гүйцэтгэлийг хангаагүй;
- (б) Зөвлөх (эсхүл түншлэлийн аль нэг гишүүн) төлбөрийн чадваргүй болсон, эсхүл дампуурсан, эсхүл дампуурлаас зайлсхийх зорилгоор зээлдүүлэгчтэй тохиролцсон, эсхүл сайн дураараа буюу албадан журмын дагуу татан буугдаж байгаа;
- (в) Зөвлөх нь тендерт оролцох буюу гэрээг гүйцэтгэх явцдаа авилгал, залилан мэхлэх үйлдэлд холбогдсон байж болох хангалттай үндэслэл захиалагчид байгаа;
- (г) Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл үүссэний улмаас Зөвлөх нь 60-аас дээш хоногийн хугацаанд үйлчилгээний голлох хэсгийг гүйцэтгэх боломжгүй болсон;
- (д) Захиалагч өөрийн санаачлагаар дээр зааснаас бусад үндэслэлээр гэрээг цуцлахаар шийдвэрлэсэн бол:

- (e) Зөвлөх ГЕН-ийн 7 зүйл заасны дагуу арбитрагийн ажиллагааны үр дүнд гаргасан эцсийн шийдвэрийг биелүүлээгүй:

**2.6.2 Зөвлөхийн санаачлагаар гэрээг цуцлах**

Энэхүү зүйлд заасан дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд зөвлөх өөрийн санаачлагаар гэрээг цуцлах эрхтэй

- (a) захиалагч нь ГЕН-ийн 7 дугаар зүйлд заасны дагуу ямар нэгэн маргаан үүсээгүй үед гэрээний дагуу төлбөл зохих аливаа төлбөрийг зөвлөхийн бичгээр гаргасан төлбөрийн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш 45 хоногийн дотор төлөөгүй
- (б) Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл үүссэний улмаас Зөвлөх нь 60-аас дээш хоногийн хугацаанд үйлчилгээний голлох хэсгийг гүйцэтгэх боломжгүй болсон:
- (в) Захиалагч ГЕН-ийн 7 зүйл заасны дагуу арбитрагийн ажиллагааны үр дүнд гаргасан эцсийн шийдвэрийг биелүүлээгүй:
- (г) Захиалагч гэрээний дагуу хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн бөгөөд энэхүү зөрчлийн талаарх мэдэгдлийг хүлээн авснаас хойш 45 хоногийн хугацаанд ( эсхүл зөвлөхийн бичгээр зөвшөөрөн сунгасан хоногт багтаан) тухайн зөрчлийг арилгаагүй:

**2.6.2 Гэрээг цуцласан үед хийх төлбөр**

ГЕН-ийн 2.9.1 болон 2.9.2 зүйлд заасны дагуу гэрээг цуцласан үед захиалагч дараах төлбөрийг зөвлөхөд төлөх ёстой:

- (a) Гэрээг цуцлах өдрөөс өмнө зохих ёсоор гүйцэтгэсэн бөгөөд ГЕН-ийн 6 дугаар зүйлд заасны дагуу төлбөл зохих үйлчилгээний хөлс:
- (б) ГЕН-ийн 2.6.1-ийн (a)-гаас (в) хүртлэх, мөн (e) заалтын дагуу гэрээг цуцалснаас бусад тохиолдолд зөвлөхийн ажилтнууд, тэдний хууль ёсны хамтран амьдрагч нарыг буцаах замын зардал зэрэг гэрээг цуцласны улмаас үүсэх аливаа бодит зардлын нөхөн олговор:

### **3. ЗӨВЛӨХИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ**

#### **3.1 Ерөнхий зүйл**

##### **3.1.1 Гүйцэтгэлийн чанар**

Зөвлөх нь гэрээний дагуу гүйцэтгэвэл зохих үүрэг болон үзүүлэх үйлчилгээг нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн болон бодит жишигт нийцүүлэн үр ашигтай, хэмнэлттэй байдлаар гүйцэтгэх ёстой бөгөөд тоног төхөөрөмж, машин механизм болон материаллын хувьд аюулгүй, үр дүнтэй болон зүй зохист арга зүйг ашиглан үйл ажиллагааны шуурхай удирдлагыг ханган ажиллах ёстой.

Зөвлөх нь гэрээ болон үйлчилгээтэй холбоотой ямарваа нэгэн асуудлаар ямагт захиалагчийн зөвлөхийн хувиар хандан ажиллах бөгөөд туслан гүйцэтгэгч буюу гуравдагч этгээдтэй хийх

аливаа харилцаанд захиалагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах ёстой.

**3.2 Ашиг сонирхлын зөрчил**

Зөвлөх нь ирээдүйд хийх ажилтай холбоотой ямар нэгэн зүйлийг үл харгалзан захиалагчийн ашиг сонирхлыг эн тэргүүнд тавих ёстой бөгөөд өөр төсөл арга хэмжээ буюу өөрийн байгууллагын эрх ашигтай, сонирхолын зөрчилд орохоос зайлсхийх ёстой.

**3.3 Нууцлал**

Зөвлөх, түүний ажилтнууд нь захиалагчаас урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр гэрээний хэрэгжилтийн явцад олж авсан аливаа нууц мэдээллийг ямар нэгэн хувь хүн, байгууллагад дамжуулах эрхгүй бөгөөд үйлчилгээний үр дүнд боловсруулсан зөвлөмжийг нийтэд нээлттэй болгох эрхгүй

**3.4 Зөвлөхийн хариуцах даатгал**

Зөвлөх нь захиалагчийн зөвшөөрсөн нөхцөл, болзолын дагуу болон ГТН-д тусгайлан заасан эрсдэлд хамаарах даатгалыг өөрийн зардлаар хариуцан хийлгэх бөгөөд даатгалын гэрээ, гэрчилгээг захиалагчид ирүүлнэ.

**3.5 Захиалагчаас урьдчилан зөвшөөрөл авбал зохих үйл ажиллагаа**

Зөвлөх нь дор дурдсан үйл ажиллагааг явуулахаас өмнө захиалагчийн зөвшөөрлийг бичгээр авсан байх ёстой. Үүнд:

(а) Үйлчилгээний аль нэг хэсгийн гүйцэтгэлийг туслан гүйцэтгэх гэрээгээр хийлгэх,

(б) Хавсралт №1-т заасан ажилтны жагсаалтанд ямар нэг өөрчлөлт, нэмэлт оруулах.

(в) ГТН-д тусгайлан заасан бусад үйл ажиллагаа

**3.6 Тайлагнах хуваарь**

Зөвлөх нь Хавсралт №2 -т заасан тайлан болон баримт бичгийг тухайн хавсралтад заасан маягтын дагуу тогтоосон хугацааны дотор хүргүүлэх ёстой.

**3.7 Зөвлөхийн боловсруулсан баримт бичиг захиалагчийн өмч болох нь**

Энэхүү гэрээний дагуу захиалагчид зориулж зөвлөхийн боловсруулсан аливаа судалгаа, тайлан, зураг, график, программ хангамж болон бусад материал, эд зүйл нь захиалагчийн өмч болж үлдэх бөгөөд гэрээ дуусгавар болох, гэрээ цуцлахаас өмнө эдгээр материалыг дэлгэрэнгүй жагсаалтын хамтаар захиалагчид хүргүүлнэ. Зөвлөх нь эдгээр бичиг баримт болон программ хангамжийн хувийг авч болно.

**3.8 Нягтлан бодох бүртгэл, Хяналт шалгалт болон Аудит**

Зөвлөх нь гэрээний гүйцэтгэлд хамаарах нягтлан бодох данс, бүртгэлийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмын дагуу хөтлөн явуулах бөгөөд захиалагч түүний томилсон төлөөлөгч эсхүл аудитор эдгээр данс, бүртгэлд хөндлөнгийн шалгалт хийх эрхтэй.

#### **4. ЗӨВЛӨХИЙН АЖИЛТНУУД**

**4.1 Ажиллах хүчний тодорхойлолт**

Зөвлөхийн санал болгож буй гол мэргэжилтэн бүрийн албан тушаал, ажлын байрны тодорхойлолт, мэргэжлийн түвшин болон үйлчилгээг гүйцэтгэхэд оролцох хугацаа зэргийн талаарх мэдээллийг Хавсралт №3-т тусгана. Захиалагчтай урьдчилан тохиролцсон гол мэргэжилтний мэдээллийг мөн хавсралтанд багтаана.

#### **4.2 Ажилтныг халах буюу солих**

- (а) Захиалагч зөвшөөрөөгүй бол ажиллах хүчний бүрэлдэхүүнд ямар нэгэн өөрчлөлт хийх ёсгүй. Зөвлөхийн эрх хэмжээнээс үл хамаарах, тухайлбал, тэтгэвэрт гарах, нас барах, эрүүл мэндийн хувьд чадваргүй болох, бусад шалтгааны улмаас ажилтныг солих зайлшгүй шаардлага гарвал түүнтэй тэнцүү буюу илүү чадвартай хүнээр солих асуудлыг цаг алдалгүй тавина.
- (б) Аль нэгэн ажилтан үүргээ ноцтой зөрчсөн буюу гэмт хэрэг үйлдсэн, эсхүл үүргийн гүйцэтгэл хангалтгүй байгаа талаар хангалттай үндэслэл захиалагчид байгаа тохиолдолд захиалагчаас бичгээр гаргасан үндэслэл бүхий шаардлагын дагуу түүний хүлээн зөвшөөрхүйц чадвар болон туршлага бүхий ажилтнаар солих ёстой.
- (в) Ажилтныг халах, эсхүл солихтой холбоотой үүсч болох ямар нэгэн нэмэлт зардлыг зөвлөх нэхэмжлэх эрхгүй болно.

### **5. ЗАХИАЛАГЧИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ**

#### **5.1 Дэмжлэг үзүүлэх болон зөвшөөрөл олгох**

Захиалагч нь ГТН-д заасан зөвлөхөд үзүүлэх дэмжлэг, туслалцаа болон холбогдох зөвшөөрлийг засгийн газрын зүгээс олгуулахын тулд бүх талын хүчин чармайлт гаргана.

#### **5.2 Гэрээнд хэрэглэх хуулинд татвар хураамжийн талаар орсон өөрчлөлт**

Хэрэв, гэрээ байгуулагдсанаас хойш гэрээнд хэрэглэх хуулинд татвар, хураамжийн талаар орсон өөрчлөлтийн улмаас үйлчилгээний гүйцэтгэлийн дагуу Зөвлөхийн хүлээн авах төлбөр нэмэгдэх буюу хасагдахаар байгаа бол, талууд тохиролцон гэрээний дагуу Зөвлөхөд төлөх цалин болон нөхөн төлөгдөх зардлын хэмжээг өөрчлөх бөгөөд энэхүү холбогдох үнийн тохируулга нь ГЕН-ийн 6.2 (а), (б), -д заасан төлбөрийн хэмжээнд нийцсэн байх ёстой.

#### **5.3 Захиалагчийн зүгээс үзүүлэх үйлчилгээ, тоног төхөөрөмж болон эд хөрөнгө**

Захиалагч нь үйлчилгээний зорилгоор ашиглуулахаар Хавсралт 3.3-д заасан үйлчилгээ, тоног төхөөрөмж болон эд хөрөнгийг тогтоосон хугацаанд үнэ төлбөргүйгээр Зөвлөхөд гарган өгөх ёстой.

### **6. ЗӨВЛӨХӨД ТӨЛӨХ ТӨЛБӨР**

#### **6.1 Нийт төлбөр**

Зөвлөхөд төлөх нийт төлбөрийн хэмжээ нь гэрээний хавсралт №1-т тодорхойлсон үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах бүх зардлыг тооцсон тогтмол нийт үнийг багтаасан гэрээний үнээс хэтрэх ёсгүй. ГЕН-ийн 5.2-т заасны дагуу өөрчлөснөөс бусад тохиолдолд ГЕН-ийн 6.2-т тодорхойлсон үнийн хэмжээг гагцхүү ГЕН-ийн 2.4-т зааснаар талууд нэмэлт төлбөр хийхийг зөвшөөрсөн тохиолдолд нэмэгдүүлж болно.



- 6.2 Гэрээний үнэ** (а) Гадаад мөнгөн тэмдэгтээр хийх төлбөрийн хэмжээг ГТН-д тодорхойлно.  
(б) Төгрөгөөр хийх төлбөрийн хэмжээг ГТН-д тодорхойлно.
- 6.3 Нэмэлт үйлчилгээний төлбөр** ГЕН-ийн 2.4-т заасны дагуу төлөхөөр зөвшөөрч болох нэмэлт үйлчилгээний цалингийн хэмжээг тодорхойлохын тулд нийт үнийн задаргааг Хавсралт №4 болон №5-д оруулна.
- 6.4 Төлбөр хийх нөхцөл.хуваарь** Төлбөрийг ГТН-д заасан төлбөр хийх хуваарийн дагуу, тэнд заасан зөвлөхийн дансанд хийнэ. ГТН-д өөрөөр заагаагүй бол, түүнд тогтоосон хугацаанд хүчинтэй байхаар тооцож, зөвлөхийн ирүүлсэн урьдчилгаа төлбөрийн баталгааны дүнтэй тэнцэх хэмжээгээр эхний төлбөрийг хийнэ. Энэхүү баталгааг Хавсралт №7-д заасан маягт, эсхүл захиалагчийн бичгээр гаргасан зөвшөөрсөн өөр маягтаар гарган ирүүлнэ.
- ГТН-д заасан нөхцөл болзолыг хангасны дараа, зөвлөхөд төлбөл зохих төлбөрийн хэмжээг тодорхойлсон нэхэмжлэлийг захиалагчид ирүүлснээр бусад төлбөр хийгдэх ёстой.
- 6.5 Хугацаа хоцорсон төлбөрийн хүү** Захиалагч нь ГТН-ийн 6.4–д тогтоосон төлбөр хийх хугацааг арван таван хоногоос (15) дээш хоногоор хэтрүүлсэн бол хугацаа хоцорсон хоног тутам ГТН-д тогтоосон хэмжээгээр зөвлөхөд хүү төлөх ёстой.

## **7. ШУДАРГА БАЙДАЛ**

- 7.1 Шударга байдал** Талууд энэхүү гэрээний дагуу үйл ажиллагаа явуулахдаа бие биенийхээ эрхийг хүндэтгэн, шударга байдлаар хандах ба гэрээний зорилгыг хэрэгжилтийг хангахын тулд бүхий л зохистой арга хэмжээг авна.

## **8. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ**

- 8.1 Маргааныг эв зүйгээр шийдвэрлэх** Маргаанаас зайлсхийх, эсхүл түүнийг цаг алдалгүй шийдвэрлэх нь гэрээний гүйцэтгэлийг сайтар хангах болон төсөл арга хэмжээний амжилтанд ихээхэн чухал гэдгийг талууд хүлээн зөвшөөрнө. Гэрээтэй холбоотой аливаа маргааныг талууд харилцан тохиролцож, эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэнэ.
- 8.2 Маргааныг шийдвэрлэх** Талууд гэрээний холбоотой аливаа маргааныг эв зүйгээр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд аль нэг тал нь ГТН-д заасан маргааныг шийдвэрлэх арга хэрэгслийг сонгох эрхтэй.

### III. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

(Хаалтанд байгаа зүйлийг { } сонгон хэрэглэнэ; эцэслэн боловсруулалт хийхэд тэмдэглэлийг хасна)

ГЕН-ийн зүйлийн дугаар	Гэрээний ерөнхий нөхцлийн холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах буюу өөрчлөнө.
{1.1(a)}	Гэрээнд хэрэглэх хууль нь { Монгол улсын хүчин төгөлдөр хууль болон бусад эрх зүйн актууд}
1.3	Гэрээний баримт бичгүүд нь <b>Монгол</b> хэл дээр байна.
1.4	<b>Захиалагчийн хаяг: Эрчим хүчний яам, Эрдэнэбүрэнгийн УЦС төсөл</b> <b>Харилцах хүн:</b> <b>Утас:</b>
{1.6}	{Төлөөлөх эрх бүхий гишүүн[ <b>гишүүний нэрийг оруул</b> ]}  <b>Тэмдэглэл: Зөвлөх нь түншлэл /консорциум/ хоёр буюу түүнээс дээш хуулийн этгээдийн холбооноос бүрдэж байгаа тохиолдолд ГТН-ийн 1.5-д байгаа хаягийг энд оруулна. Зөвлөх дангаар оролцож байгаа бол ГТН-ийн энэ зүйлийг бүхэлд нь хасна.</b>
1.7	<b>Итгэмжлэгдсэн төлөөлөгчид:</b> <b>Захиалагчийн:</b> <b>Зөвлөхийн:</b>
1.8	Татвар <b>Зөвлөх нь ажлыг гүйцэтгэхтэй холбогдон төлөгдөх бүх татвар, хураамж, шимтгэлийг төлөх асуудлыг өөрсдөө хариуцна. Зөвлөхийн ирүүлэх үнийн саналдхуулийн дагуу төлөх татвар, даатгал, хураамж, багтсан байна.</b>
2.2	<b>Тогтоосон хугацаа: Гэрээ байгуулсан өдрөөс эхлэнэ</b>
2.3	<b>Тогтоосон хугацаа: 2020 оны 11 дугаар сарын 30-ний дотор</b>
3.1.1	<b>Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн 0.05 хувь байна. Нийт гэрээний үнийн 10%-иас хэтрүүлэхгүй</b>
{3.5 (в)}	{Бусад үйл ажиллагаа: [ <b>захиалагчийн шаардлагтай гэж үзсэн үйл ажиллагааг оруул</b> ].}

6.2(a)	Гадаад мөнгөн тэмдэгтээр хийх төлбөрийн дээд хэмжээ: <b>[мөнгөн тэмдэгт бүрээр хэмжээг тоо болон үсгээр оруул]</b>
6.2(б)	Төгрөгөөр хийх төлбөрийн дээд хэмжээ: <b>[хэмжээг тоо болон үсгээр оруул]</b>
6.4	<p>Төлбөр хийх данснууд: Төгрөгийн хувьд:</p> <p><b>Төлбөрийг дараахь хуваарийн дагуу төлнө.</b> <i>Тэмдэглэл: (а) дор дурдсан төлбөрийн хуваарь нь зөвхөн дүн шинжилгээ хийх, жишээ болох зорилготой ; (б) гадаад мөнгөн тэмдэгт болон төгрөгөөр хийх хуваарь хаирлцан адилгүй бол салангид хуваарь гаргаж мөрдөнө</i></p> <p>(а) Гэрээний хэлэлцээрээр шийдвэрлэнэ</p>
6.5	<b>Хүүгийн хувь хэмжээ: [хүүгийн хэмжээг оруул].</b>
8.2	Гэрээтэй холбоотой үүссэн маргааныг талууд эв зүйгээр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

## IV. ХАВСРАЛТ

### ХАВСРАЛТ №1 – ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОДОРХОЙЛОЛТ

*Тэмдэглэл: Энэхүү хавсралт нь техникийн хэлэлцээрийн явцад захиалагч болон зөвлөхийн эцэслэн тохиролцсон ажлын даалгавар, тодорхой ажлуудыг дуусгавар болгох огноо, зарим ажлуудыг гүйцэтгэх байршил, захиалагчийн зөвшөөрлийг авбал зохих тодорхой ажлуудын талаарх мэдээллийг агуулна.*

### ХАВСРАЛТ №2 - ТАЙЛАН ГАРГАХ ХУВААРЬ

*Тэмдэглэл: Тайлангийн агуулга болон түүнийг гарган ирүүлэх маягт, давтамж: хүлээн авах хүн: ирүүлэх огнооны талаарх мэдээллийн жагсаалт.*

### ХАВСРАЛТ №3 - ГОЛЛОХ МЭРГЭЖИЛТЭН БОЛОН ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧ

*Тэмдэглэл: Дараах зүйлсийг багтаана:*

**C-1** *Үйлчилгээ үзүүлэх гадаадын голлох мэргэжилтний ажлын байрны дэлгэрэнгүй тодорхойлолт, шаардлагатай чадварын түвшин, Албан тушаал [боломжтой бол овог, нэрээр], болон голлох мэргэжилтэн бүрээр хүн-сараар ажиллах хугацааг оруул.*

**C-2** *Үйлчилгээтэй холбоотой ажлыг гадаадад гүйцэтгэх голлох мэргэжилтний ажлын байрны дэлгэрэнгүй тодорхойлолт, шаардлагатай чадварын түвшин, Албан тушаал [боломжтой бол овог, нэрээр], болон голлох мэргэжилтэн бүрээр хүн-сараар ажиллах хугацааг оруул.*

**C-3** *Зөвшөөрөгдсөн туслан гүйцэтгэгчийн жагсаалт: тэдгээрийн голлох ажилтантай холбоо бүхий дээрх хавсралт бүртэй ижил мэдээлэл*

**C-4** *Дотоодын голлох мэргэжилтний талаарх дээрхийн ижил мэдээлэл.*

### ХАВСРАЛТ №4 - ГЭРЭЭНИЙ ҮНИЙН ЗАДАРГАА (ГАДААД МӨНГӨН ТЭМДЭГТЭЭР)

*Тэмдэглэл: Гадаад мөнгөн тэмдэгтээр илэрхийлэгдэх нийт-үнэ өртгийн задаргаанд буй үнийн бүтцийн жагсаалтыг оруул:*

**1.** *Ажилтны сарын цалингийн хэмжээ (Голлох мэргэжилтэн болон бусад ажилтан)*

**2.** *Нөхөн төлөгдөх зардал.*

*Энэхүү хавсралтыг зөвхөн нэмэлт үйлчилгээний төлбөрийг тодорхойлохын тулд ашиглана.*

**ХАВСРАЛТ №5 - ГЭРЭЭНИЙ ҮНИЙН ЗАДАРГАА  
(ТӨГРӨГӨӨР)**

*Тэмдэглэл: Төгрөгөөр илэрхийлэгдэх нийт-үнэ өртгийн задаргаанд буй үнийн бүтцийн жагсаалтыг оруул:*

**1. Ажилтны сарын цалингийн хэмжээ (Голлох мэргэжилтэн болон бусад ажилтан)**

**2. Нөхөн төлөгдөх зардал.**

*Энэхүү хавсралтыг зөвхөн нэмэлт үйлчилгээний төлбөрийг тодорхойлохын тулд ашиглана.*

**ХАВСРАЛТ №6 - ЗАХИАЛАГЧИЙН ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ**

*Тэмдэглэл: Дараах зүйлсийг багтаана:*

**№-1 Захиалагчийн зүгээс зөвлөхөд үзүүлэх үйлчилгээ, байгууламж болон эд хөрөнгө.**

**Ы**

**ХАВСРАЛТ №7 - УРЬДЧИЛГАА ТӨЛБӨРИЙН  
БАТАЛГААНЫ МАЯГТ(БАНКНЫ БАТАЛГАА)**

***[Захиалагч байгууллагын нэр]***

***[Зөвлөхийн нэр]*** (цаашид “зөвлөх” гэх) ..... оны ... дугаар сарын ...-ний өдрийн ... тоот ***[Гэрээний нэр ба зөвлөх үйлчилгээний товч тодорхойлолт]*** гэрээ (цаашид “гэрээ” гэх)-ний ерөнхий нөхцөлийн 6.4 заалтын дагуу хүлээсэн үүргээ амжилттай биелүүлэхээ баталж ***[Захиалагчийн нэр]***-ийн өмнө хариуцлага хүлээж ***[Баталгааны мөнгөн дүн][үсгээр]***-ийн банкны баталгаа ирүүлэхтэй ХОЛБОГДУУЛАН,

***[Банк нэр]*** (цаашид “Банк” гэх) нь зөвлөхийн нэрийн өмнөөс ***[баталгааны дүн тоогоор, валют][дүн үсгээр, валют]***-ээс хэтрэхгүй мөнгөн дүнтэй төлбөрийг захиалагчийн өмнө хариуцаж, зөвлөх гэрээний үүргээ зөрчсөн тухай захиалагчийн бичгээр гаргасан анхны шаардлагыг хүлээн авсан даруй үл маргалдах журмаар энэхүү төлбөрийг хийх үүрэг хүлээж батлан даалт гаргаж байна.

Захиалагч, зөвлөхийн хооронд байгуулсан гэрээний нөхцөл болзол, түүний дагуу үзүүлэх зөвлөх үйлчилгээ, гэрээний бичиг баримтад оруулж болох аливаа өөрчлөлт, нэмэлт нь энэ батлан даалтын дагуу банкны хүлээсэн үүргийг хөндөхгүй ба дээрх өөрчлөлт, нэмэлтийн талаарх аливаа мэдэгдлийг ирүүлэх шаардлагагүй.

Энэхүү баталгаа нь гэрээний нөхцөлийн дагуу зөвлөхөд урьдчилгаа төлбөр хийгдсэн өдрөөс захиалагчид дээр дурдсан дүнтэй ижил төлбөр эргэн төлөгдтөл хүчин төгөлдөр байна.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Банкны эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Албан тушаал, нэр:

Банкны тамга:

Огноо:

Хаяг:

**ГҮЙЦЭТГЭЛИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ  
(БАНКНЫ БАТАЛГАА)**

***[Захиалагч байгууллагын нэр]***

***[Гүйцэтгэгчийн нэр]*** нь (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нь ... оны ... дугаар сарын ...-ний өдрийн ... дугаар гэрээний дагуу ***[Гэрээний нэр ба зөвлөх үйлчилгээний товч тодорхойлолт]*** (цаашид “гэрээ” гэх) ажлыг гүйцэтгэх болсонтой ХОЛБОГДУУЛАН,

Гүйцэтгэгч гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож захиалагчийн хүлээн зөвшөөрөх банкны гаргасан дор дурдсан дүнтэй батлан даалтыг захиалагчид ирүүлэхийг дээрх гэрээнд заасантай ХОЛБОГДУУЛАН,

***[Банкны нэр]*** (цаашид “Банк” гэх) нь дараах батлан даалтыг гаргаж байна:

Банк нь гүйцэтгэгчийн нэрийн өмнөөс ***[баталгааны дүн тоогоор, валют]******[дүн үсгээр, валют]*** –ээс хэтрэхгүй мөнгөн дүнтэй төлбөрийг ***[захиалагчийн нэр]***(цаашид “захиалагч” гэх)-ийн өмнө хариуцаж, гүйцэтгэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай захиалагчийн бичгээр гаргасан анхны шаардлагыг хүлээн авсан даруй үл маргалдах журмаар энэхүү төлбөрийг хийх үүрэг хүлээж байна. Ингэхдээ дээр дурдсан ***[баталгааны дүн тоогоор, валют]******[дүн үсгээр, валют]***-ийн хүрээнд захиалагчийн шаардсан аливаа дүнг ямарваа нэгэн нотолгоо, үндэслэл болон тайлбар шаардахгүй.

Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний нөхцөл болзол, эсхүл түүний дагуу гүйцэтгэх ажил, эсхүл гэрээний бичиг баримтад оруулж болох аливаа өөрчлөлт, нэмэлт нь энэ батлан даалтын дагуу банкны хүлээсэн үүргийг хөндөхгүй ба дээрх өөрчлөлт, нэмэлтийн талаарх аливаа мэдэгдлийг ирүүлэх шаардлагагүй.

Энэ баталгаа нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Банкны эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Албан тушаал, нэр:

Банкны тамга:

Огноо:

Хаяг:

**БАТЛАВ:**  
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



М. БАТГЭРЭЛ

**"ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН СТАНЦ"-ЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ  
НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
АЖЛЫН ДААЛГАВАР**

2020 он 03 сар 10 өдөр

Дугаар 2020/4-12

Улаанбаатар хот

**АЖЛЫН ДААЛГАВРЫН АГУУЛГА**

Захиалагч байгууллага	Монгол Улсын Эрчим Хүчний Яам
Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх шаардлага.	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2., 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2-ийг үндэслэн БОАЖЯ-ны ерөнхий шинжээчийн "Ерөнхий үнэлгээний дүгнэлт"-д заасны дагуу.
Гүйцэтгэх хугацаа	Гүйцэтгэгч нь БОННУ-г 2020 оны 05 сарын 01-ээс 2020 оны 10 сарын 01 хооронд боловсруулж гүйцэтгэж тайланг захиалагчид хүлээлгэж өгнө.
Гүйцэтгэгч байгууллага	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий мэргэжлийн байгууллага.
Гүйцэтгэгч компанид тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"><li>- Олон улсын стандартаар хийгдсэн байгаль орчны нөлөөллийн янз бүрийн шатны үнэлгээний ажилд оролцсон туршлагатай байх.</li><li>- Стратегийн болон салбарын байгаль орчны нөлөөллийн үнэлгээний чиглэлээр ажилласан туршлагатай байх, усан цахилгаан станц болон эрчим хүчний төслүүдэд ажиллаж байсан туршлагатай байх.</li><li>- Байгаль орчны орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг монгол, англи хэл дээр боловсруулах чадвартай байх.</li></ul>
Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний хамрах хүрээ	Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 09 сарын 18 өдрийн 357 дугаар тогтоолоор Улсын тусгай хэрэгцээнд авсан газар болон Хар ус нуур хүртлэх Ховд голын газар нутаг.




<p><b>Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тодорхойлох,</li> <li>• Болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг түүнд тохирох аргачлалаар үнэлэх,</li> <li>• Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, үр дагаварыг арилгах арга хэмжээг тодорхойлох,</li> <li>• Нөхөн сэргээх болон дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг тодорхойлох,</li> <li>• Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, орон нутгийн иргэдэд учирч болзошгүй эрсдэлийн үнэлгээ хийх,</li> <li>• Төслийн сөрөг нөлөөлөл багатай хувилбарыг сонгох,</li> <li>• Төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах,</li> <li>• Төслийн хяналт шинжилгээний хөтөлбөр боловсруулах</li> <li>• БОННУ-ийн тайлан , түүний техникийн бус хураангуйг боловсруулах,</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Уур амьсгал, агаарын чанар судалгаа</li> <li>- Гадаргын ба газрын доорхи ус УЦС-ын доод хашицын урсацын байгаль орчны нөлөөлөл</li> <li>- Голын голдирлыг түр шилжүүлэн урсгах үеийн зарцуулга</li> <li>- Ашиглалтын үед өвлийн улиралд үүсэх мөсний үзэгдлийн талаар</li> <li>- Загасны амьдрах орчин, үржлийн талаар</li> <li>- Физик бохирдол, хог хаягдал</li> <li>- Хөрс</li> <li>- Ургамал</li> <li>- Амьтан</li> <li>- Орчны физик бохирдол</li> <li>- Байгаль, түүх, соёлын дурсгалт газар</li> <li>- Ховд голын сав газрын биологийн олон янз байдал</li> <li>- Бичил уур амьсгал, түүний өөрчлөлт</li> <li>- Усан сангийн далангийн осол эрсдлийн үнэлгээ</li> <li>- Байгаль орчны асуудлууд бүрдэл хэсгүүдтэй байна.</li> </ul>
<p><b>Нийгмийн нөлөөллийн үнэлгээ:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Төслөөс нийгэм- эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тодорхойлох,</li> <li>• Төслийн хэрэгжилтийн явцад үүсч болзошгүй нийгмийн сөрөг нөлөөллийг үнэлэх,</li> <li>• Нийгмийн сөрөг нөлөөлөл багатай хувилбарыг тодорхойлох,</li> <li>• Нарийвчилсан үнэлгээний үр дүнг орон нутагт хэлэлцүүлэх,</li> <li>• Нийгмийн нөлөөллийн үнэлгээ-ний тайлан, түүний техникийн бус хураангуйг боловсруулах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Нийгэм, эдийн засгийн тухайн үеийн байдал</li> <li>- УЦС төслийн Баруун бүс нутаг болон төсөл хэрэгжих аймаг, сумын нийгэм эдийн засагт үзүүлэх эерэг болон сөрөг нөлөөллийг тодорхойлох</li> <li>- Усан сангийн байгаль орчны нөлөөлөл</li> <li>- Усан сангийн дор орох газар нутгийн байгаль орчны бүрэлдхүүн хэсгүүдийн экологи эдийн засгийн үнэлгээ / тоос, хортой хий, дуу чимээ, цахилгаан соронзон орон, хөрсөн бүрхэвч, хурдас чулуулаг , гадаргын ус / гол горхи, булаг шанд, баян бүрд / ба газрын доорхи усны нөөц, ургамалжилт / ховор, нэн ховор ургамал түүний нөөц ба ойн нөөц/, голын татам дахь хайлаас, бургас, бут сөөг амьтан аймгийн нөөц, хуурай газар, усан орчин</li> <li>- Усан сан байгуулах талбайгаас зайлуулагдах мод бут, сөөг /нийт хэмжээ, модны төрөл, шилжүүлэн суулгах, үйлдвэрлэд ашиглах, ахуйн хэрэгцээнд ашиглах, хаягдал модны хэмжээ, м%, ховор ба нэн ховор ургамал, түүний нөөц</li> </ul>

	<ul style="list-style-type: none"> <li>- Усны болон дэд бүтцийн барилга байгууламжийн нөлөөлөл</li> <li>- Газар ашиглалтын өнөөгийн байдал, төслийн орон нутгийн газар зохион байгуулалтанд үзүүлэх нөлөөлөл</li> <li>- Археологи, түүх соёлын дурсгалт зүйлс</li> <li>- Нүүлгэн шилжүүлэлт /суурин газрууд, малын бэлчээр, айл өрхүүд, өвөлжөө хаваржааны газрууд</li> <li>- Уугуул иргэд</li> <li>- Олон нийтийн санал асуулгын судалгаа гэсэн бүрдэл хэсгүүдтэй байна.</li> </ul>
Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө	<ul style="list-style-type: none"> <li>- Тухайн жилийн болон 5 жилийн байгаль хамгааллын менежментийн төлөвлөгөө</li> <li>- Хяналт шинжилгээний хөтөлбөр</li> <li>- Олон нийтийн хэлэлцүүлэг</li> <li>- Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүжилтийн төлөвлөгөө зэрэг бүрдэл хэсгүүдтэй байна.</li> </ul>
Үнэлгээг хийж гүйцэтгэх компанийн ажлын хуваарь	<ul style="list-style-type: none"> <li>- БОННУ – ын ажлын үе шатуудын төлөвлөгөө</li> </ul>

Жич: Ажлын даалгаврын дэлгэрэнгүй, БОННУ – ний АД – ын Хавсралт 1 – ийг хавсаргав.


**Танилцсан:**

Бодлого, төлөвлөлтийн  
газрын дарга

 Г. Энхтайван

**Хянасан:**

Бодлого төлөвлөлтийн газрын  
Сэргээгдэх эрчим хүчний  
хэлтсийн дарга

 О. Бавуудорж

**Боловсруулсан:**

Эрдэнэбүрэнгийн УЦС-ын Төсөл  
хэрэгжүүлэх нэгжийн удирдагч

 Ж. Лувсандандар

**Үнэлгээг хийж гүйцэтгэх компанийн  
боловсон хүчинд тавигдах шаардлага**

Дараах шалгууруудыг хангасан, төлөвлөсөн хугацаанд ажиллах боломжтой багийн мэргэжилтнүүд БОННУ-г гүйцэтгэхэд оролцоно.



**Байгаль орчин, нийгмийн үнэлгээний багийн ахлагч**

- Багийн ахлагч байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ болон байгалийн нөөцийн ашиглалтын төлөвлөлт, усны менежмент, газар төлөвлөлтийн төслүүдэд 15 – аас доошгүй жил ажилласан стратегийн болон салбарын байгаль орчны нөлөөллийн үнэлгээний чиглэлээр ажилласан туршлагатай байх, усан цахилгаан станц болон эрчим хүчний төслүүдэд ажиллаж байсан туршлагатай бол давуу тал болно.
- Олон улсын стандартаар хийгдсэн байгаль орчны нөлөөллийн янз бүрийн шатны үнэлгээний ажилд оролцсон туршлагатай байх,
- Янз бүрийн холбогдох талуудыг оролцуулсан олон чиглэлийн төслийн үйл ажиллагааг үр дүнтэй зохицуулах чадвартай нь батлагдсан байх,
- Төслийн ажилтнуудад зөвөлгөө өгөх чадвартай байх,
- Байгаль орчны менежмент, нөлөөллийн үнэлгээ, орчны төлөвлөлт мэргэжлийн чиглэлээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй байх,
- Зохион байгуулах, түргэн хугацаанд даалгаврыг биелүүлэх, болон, цагийн ачаалал даан ажиллах чадвартай,
- Төслийн ажлын үр дүн, үр ашгийг дээшлүүлэх талаар идэвхи санаачлага сайтай,
- Хувийн зохион байгуулалт болон багаар ажиллах ур чадвар сайтай байх
- Англи хэлний аман болон бичгийн өндөр чадвартай байх,
- Үнэлгээний хүрээнд компьютерийн хэрэглээний программууд дээр сайн ажилладаг байх.

**Байгаль орчны үнэлгээний ахлах мэргэжилтэн**

- Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ, байгалийн нөөцийн ашиглалтын төлөвлөлт, усны менежмент болон газар төлөвлөлтийн зэрэг төслүүд дээр 15-аас доошгүй жил ажилласан туршлагатай, стратегийн болон салбарын байгаль орчны нөлөөллийн үнэлгээний ажил хийж байсан туршлагатай байх, усан цахилгаан станц, эрчим хүчний төслүүдэд ажиллаж байсан туршлагатай байх,
- Байгаль орчны менежмент, нөлөөллийн үнэлгээ, орчны төлөвлөлт зэрэг мэргэжлээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй байх,
- Олон улсын стандартаар хэрэгжүүлсэн байгаль орчны нөлөөллийн янз бүрийн шатны үнэлгээний ажилд 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх,
- Судалгаа шинжилгээ хийх, асуудлыг зөв шийдвэрлэх чадвартай байх

- Олон улсын стандартаар хэрэгжүүлсэн байгаль орчны нөлөөллийн янз бүрийн шатны үнэлгээний ажилд 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх,
- Судалгаа шинжилгээ хийх, асуудлыг зөв шийдвэрлэх чадвартай байх
- Олон төрлийн мэдээллийг нэгтгэн дүгнэж, дүн шинжилгээ хийх чадвартай байх,
- Англи хэлний аман болон бичгийн өндөр чадвартай байх,
- Үнэлгээний хүрээнд компьютерийн хэрэглээний программууд дээр сайн ажилладаг.

### **Загас судлаач**

- Загас судлаач мэргэжлээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй байх,
- Мэргэжлийн чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх,
- Олон улсын стандартаар хэрэгжүүлж байсан байгаль орчны нөлөөллийн янз бүрийн шатны үнэлгээний ажилд оролцсон туршлагатай байх,
- Ижил төстэй бүс нутагт биологийн төрөл зүйлийн судалгаа, усны амьтад, загасны судалгааны ажлын арвин туршлагатай байх,
- Мэдээллийг боловсруулах мэргэжлийн өндөр ур чадвартай, тооцооллын загварчлал дээр ажиллаж байсан туршлагатай байх,
- Төслийн ажлын үр дүн, үр ашгийг дээшлүүлэх талаар идэвхи санаачлага сайтай ажиллах,
- Хувийн зохион байгуулалт болон багаар ажиллах ур чадвар сайтай байх
- Англи хэлний аман болон бичгийн өндөр чадвартай байх,
- Үнэлгээний хүрээнд компьютерийн хэрэглээний программууд дээр сайн ажилладаг.

### **Цэвэр усны экологич/ лимнологич**

- Усны экологич мэргэжлээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй. Мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх
- Олон улсын стандартаар хэрэгжүүлж байсан байгаль орчны нөлөөллийн янз бүрийн шатны үнэлгээний ажилд оролцсон туршлагатай байх,
- Мэдээллийг боловсруулах мэргэжлийн өндөр ур чадвартай байх,
- Төслийн ажлын үр дүн, үр ашгийг дээшлүүлэх талаар идэвхи санаачлага сайтай ажиллах,
- Англи хэлний аман болон бичгийн өндөр чадвартай байх,
- Үнэлгээний хүрээнд компьютерийн хэрэглээний программууд дээр сайн ажилладаг.

### **Гидрологич**

- Гидрологич, ус зүйч мэргэжлээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй, Мэргэжлийн чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх,
- Монгол оронд хэрэгжсэн ижил төстэй төсөл дээр оролцон ажиллаж байсан туршлагатай байх,

- Мэдээллийг боловсруулах мэргэжлийн өндөр ур чадвартай, усзүйн загварчлал дээр ажиллаж байсан туршлагатай байх,
- Төслийн ажлын үр дүн, үр ашгийг дээшлүүлэх талаар идэвхи санаачлага сайтай ажиллах,
- Англи хэлний аман болон бичгийн өндөр чадвартай байх,
- Үнэлгээний хүрээнд компьютерийн хэрэглээний программууд дээр сайн ажилладаг.

#### **Цаг уурч**

- Цаг уурч мэргэжлийн магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх, мэргэжилээрээ 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх,
- Мэдээллийг боловсруулах мэргэжлийн программуудыг эзэмшсэн, мэргэжлийн өндөр ур чадвартай байх,
- Уур амьсгалын өөрчлөлтийн ирээдүйн хандлагыг загварчлалын аргаар тооцон гаргаж байсан туршлагатай байх,
- Төслийн ажлын үр дүн, үр ашгийг дээшлүүлэх талаар идэвхи санаачлага сайтай ажиллах,
- Англи хэлний аман болон бичгийн өндөр чадвартай байх,
- Үнэлгээний хүрээнд компьютерийн хэрэглээний программууд дээр сайн ажилладаг.

#### **Гидрогеологич**

- Гидрогеологич мэргэжилээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй байх,
- Хуурай бүс нутаг, Монгол оронд эсвэл ижил төстэй бүс нутагт газрын доорх усны хайгуул судалгааны чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх, Монгол оронд хэрэгжсэн ижил төстэй төсөл дээр оролцон ажиллаж байсан туршлагатай бол давуу тал болно.
- Мэдээллийг боловсруулах мэргэжлийн өндөр ур чадвартай, тооцооллын загварчлал дээр ажиллаж байсан туршлагатай байх,
- Төслийн ажлын үр дүн, үр ашгийг дээшлүүлэх талаар идэвхи санаачлага сайтай ажиллах,
- Англи хэлний аман болон бичгийн өндөр чадвартай байх,
- Үнэлгээний хүрээнд компьютерийн хэрэглээний программууд дээр сайн ажилладаг.

#### **Геологийн инженер**

- Мэргэжилтэн нь геологийн инженер мэргэжилтэй байна.
- Геологийн ухааны магистр буюу түүнээс дээш зэрэгтэй байна.
- Хуурай бүс, Монгол Улс эсвэл ижил төстэй бүс нутагт хэрэгжиж байсан гидравликийн төслийн геологийн хайгуул, судалгааны чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх
- Мэргэжлийн ур чадвар хөгжүүлэх мэдлэгтэй, тооцооны загварчилал боловсруулж байсан туршлагатай
- Төслийн ажлын үр дүн, үр ашгийг дээшлүүлэх, талаар идэвхи санаачлага сайтай ажиллах

- Англи хэлний өндөр мэдлэгтэй
- Үнэлгээний хүрээнд хэрэглэх компьютерийн хэрэглээний программууд дээр сайн ажилладаг.

#### **Экологич**

- Экологич мэргэжлээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй. Мэргэжлийн чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх
- Монгол оронд хэрэгжсэн ижил төстэй төслүүдэд оролцон ажиллаж байсан туршлагатай байх, Олон улсын стандартаар хэрэгжүүлж байсан байгаль орчны нөлөөллийн янз бүрийн шатны үнэлгээний ажилд оролцсон туршлагатай байх.
- Мэдээллийг боловсруулах мэргэжлийн өндөр ур чадвартай байх,
- Төслийн ажлын үр дүнг дээшлүүлэх талаар идэвхи санаачлага сайтай ажиллах,
- Англи хэлний аман болон бичгийн өндөр чадвартай байх,
- Үнэлгээний хүрээнд компьютерийн хэрэглээний программууд дээр сайн ажилладаг.

#### **Биологич**

- Биологич мэргэжлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй, мэргэжлийн чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх,
- Ижил төстэй төслүүд дээр ажиллаж байсан туршлагатай байх,
- Бүс нутгийн биологийн олон янз байдалд үнэлгээ хийж байсан туршлагатай байх
- Олон улсын шаардлагын дагуу судалгаа шинжилгээ хийж байсан туршлагатай байх,
- Төслийн ажлын үр дүнг дээшлүүлэх талаар идэвхи санаачлага сайтай ажиллах,
- Англи хэлний ярианы болон бичгийн өндөр чадвартай байх,
- Үнэлгээний хүрээнд компьютерийн хэрэглээний программууд дээр сайн ажилладаг.

#### **Ургамал судлаач**

- Ургамал судлаач мэргэжлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх, хамгийн багадаа 10 жилийн ажлын туршлагатай байх
- Ижил төстэй төсөл дээр оролцон ажилласан туршлагатай байх,
- Бүс нутгийн биологийн олон янз байдалд үнэлгээ хийж байсан туршлагатай байх,
- Мэдээллийг боловсруулах мэргэжлийн өндөр ур чадвартай, тооцооллын загварчлал дээр ажиллаж байсан туршлагатай байх,
- Төслийн ажлын үр дүнг дээшлүүлэх, ажлын дэс дарааллыг тогтоох талаар идэвхи санаачлага сайтай ажиллах,
- Англи хэлний аман болон бичгийн өндөр чадвартай байх,
- Үнэлгээний хүрээнд компьютерийн хэрэглээний программууд дээр сайн ажилладаг.

### **Нийгэм, газрын мэргэжилтэн**

- Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ болон газар ашиглалт төлөвлөлт, нийгмийн нөлөөллийн үнэлгээний чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх,
- Нийгэм судлал эсвэл эдийн засагч мэргэжлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх,
- Олон улсын санхүүжилтээр хэрэгжсэн ижил төстэй төслүүдэд нийгэм-эдийн засгийн судалгаа хийж байсан туршлагатай байх,
- Судалгаа шинжилгээ хийх, асуудлыг зөв шийдвэрлэх чадвартай байх,
- Мэдээллийг боловсруулах мэргэжлийн өндөр ур чадвартай байх,
- Англи хэлний аман болон бичгийн өндөр чадвартай байх,
- Үнэлгээний хүрээнд компьютерийн хэрэглээний программууд дээр сайн ажилладаг.

### **Археологич**

- Археологи ба бусад холбогдох мэргэжлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх. Соёлын өвийн удирдлагаар 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх;
- Ижил төсөөтэй төслүүдэд ажиллаж байсан туршлагатай байх;
- Соёлын биет ба биет бус өвийг үнэлэх, холбогдох асуудлаар менежментийн төлөвлөгөө боловсруулах туршлагатай байх;
- Олон улсын хэмжээнд тавигддаг шаардлагын дагуу судалгаа явуулах туршлагатай байх,
- Төслийн үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэхэд практик арга барилыг боловсруулах санаачлагатай байх;
- Англи хэлний аман болон бичгийн өндөр чадвартай байх;
- БОННУ-ний хүрээнд компьютерийн хэрэглээний программууд дээр сайн ажилладаг;

### **Антропологич**

- Антропологи ба бусад холбогдох мэргэжлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх. Соёлын өвийн удирдлага, талуудын оролцооны чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх;
- Ижил төсөөтэй төслүүдэд ажиллаж байсан туршлагатай байх;
- Чөлөөт, урьдчилан мэдээлсэн, олон нийтийн хэлэлцүүлэг явуулах, баримтжуулах, эмэгтэйчүүд, залуучууд зэрэг нийгмийн эмзэг ба цөөнхийн бүлгийг оролцооны хөтөлбөрүүдэд хамруулах арга хэрэгсэл боловсруулах, тэднийг татан оруулах үйл явцыг удирдан явуулах туршлагатай байх;
- Төслийн талбайд соёлын эмзэг бүлгийн соёлын биет ба биет бус өвийг үнэлэх, холбогдох асуудлаар менежментийн төлөвлөгөө боловсруулах туршлагатай байх;
- Олон улсын хэмжээнд тавигддаг шаардлагын дагуу судалгаа явуулах туршлагатай байх,

- Төслийн үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэхэд практик арга барилыг боловсруулах санаачлагатай байх;
- Англи хэлний аман болон бичгийн өндөр чадвартай байх;
- БОННУ-ний хүрээнд компьютерийн хэрэглээний программууд дээр сайн ажилладаг;

#### **Газар ашиглалтын мэргэжилтэн**

- Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ болон байгалийн нөөц ашиглалтын төлөвлөлт, усны менежмент, газар эзэмшлийн албан ба албан бус тогтолцооны аль алиныг хамарсан төслүүд, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний чиглэлд 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх,
- Газар зохион байгуулалт мэргэжлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх,
- Газар зүйн мэдээллийн системийн программуудыг бүрэн эзэмшсэн байх,
- Төслийн ажлын үр дүнг дээшлүүлэх, ажлын дэс дарааллыг тогтоох талаар идэвхи санаачлага сайтай ажиллах,
- Хүмүүстэй ажиллах ур чадвар сайтай, багаар ажиллах төслийн ажилд ажиллах чадвартай байх,
- Англи хэлний аман болон бичгийн өндөр чадвартай байх,
- Үнэлгээний хүрээнд хэрэглэх компьютерийн хэрэглээний программууд дээр сайн ажилладаг.

#### **Газарзүйн мэдээллийн системийн мэргэжилтэн**

- Газарзүй, ус судлал, экологич болон бусад байгаль орчны салбарын мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байх,
- Газар зүйн мэдээллийн системийн программуудыг бүрэн эзэмшсэн байх,
- Газарзүйн мэдээллийн системийн мэргэжилтнээр ажилласан 8 жилийн туршлагатай, БОАЖ-ын яамны ашигладаг албан ёсны газарзүйн мэдээллийн системийн программ дээр 1-ээс багагүй жил ажилласан туршлагатай байх,
- Мэдээллийг боловсруулах мэргэжлийн өндөр ур чадвартай, тооцооллын загварчлал дээр ажиллаж байсан туршлагатай байх,
- Төслийн ажлын үр дүнг дээшлүүлэх, ажлын дэс дарааллыг тогтоох талаар идэвхи санаачлага сайтай ажиллах,
- Хүмүүстэй ажиллах ур чадвар сайтай, багаар ажиллах төслийн ажилд ажиллах чадвартай байх,
- Англи хэлний аман болон бичгийн өндөр чадвартай байх,
- Үнэлгээний хүрээнд хэрэглэх компьютерийн хэрэглээний программууд болон ГМС-ийн хэрэглээний программууд дээр сайн ажилладаг

#### **Хөрс судлаач**

- Хөрс судлаач мэргэжлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй, мэргэжлээрээ 10- аас доошгүй жил ажилласан туршлагатай байх,



- Олон улсын стандарт, шаардлагын дагуу судалгаа шинжилгээ хийж байсан туршлагатай байх,
- Хөрсний тархацын зураглал гаргаж байсан туршлагатай байх, мэдээллийг боловсруулах мэргэжлийн өндөр ур чадвартай байх,
- Төслийн ажлын үр дүнг дээшлүүлэх талаар идэвхи санаачлага сайтай ажиллах,
- Англи хэлний аман болон бичгийн өндөр чадвартай байх, Үнэлгээний хүрээнд хэрэглэх компьютерийн хэрэглээний программууд дээр сайн ажилладаг.

Үнэлгээг хийж гүйцэтгэх компани нь өөрийн багийн бүрэлдэхүүнийг өөр хэлбэрээр ажиллуулах тухай санал гаргах, голлох мэргэжилтний дээрх жагсаалтад ороогүй бусад мэргэжлийн чиглэлээр мэргэжилтэнг нэмж ажиллуулна.

БОННУ-ний судалгаануудыг явуулах, техник хангамж, шаардлагатай машин техникийг бүрдүүлж ажил гүйцэтгэх боломжийг хангасан байх шаардлагатай.

**Товчилсон үгсийн жагсаалт**

АУЭХС	Алтай-Улиастайн эрчим хүчний систем
ББЭХС	Баруун Бүсийн Эрчим Хүчний Систем
БНБОУ	Бүс нутгийн байгаль орчны үнэлгээ
БОМТ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
БОННУ	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ
БОУ	Байгаль орчны үнэлгээ
БОХШХ	Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
БХХ5	Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч
БЧДД	Бетон чулуун дүүргэгчтэй боомт
ГВт	Гегаватт
ДБХОУХ	Дэлхийн байгаль хамгаалах олон улсын холбоо
ДҮТ	Диспетчерийн үндэсний төв
ЗБЭХС	Зүүн бүсийн эрчим хүчний систем
Кв	Киловольт
КВт	Киловатт
МВт	Мегаватт
МУЗГ	Монгол улсын засгийн газар
НХАЗ	Нэг худалдан авагчтай загвар
ОЦҮ	Одоогийн цэвэр үнэлгээ
ПИН	Перманганатын исэлдэх чанар
СЭХ	Сэргээгдэх эрчим хүч
ТББ	Төрийн бус байгууллага
ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгж
ТУХ	Төслийн удирдах хороо
ТХГН	Төрийн хамгаалалттай газар нутаг
ТЭЗУС	Техник Эдийн Засгийн Урьдчилсан судалгаа
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТЭХС	Төвийн эрчим хүчний систем
УИХ	Улсын Их Хурал
УЦС	Усан цахилгаан станц
ҮАЗ	Үйл ажиллагааны зардал
ХЗ	Хөрөнгийн зардал
ХНБ	Хүчитгэж нягтруулсан бетон
ШЦУ	Шүлт цахиурын урвал
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо
ЭХЯ	Эрчим хүчний яам
СО	Нүүрстөрөгчийн дутуу исэл
NO2	Нитрит
NO3	Нитрат
NOx	Азотын исэл
SO2	Хүхрийн давхар исэл
К	Кали
Pb	Хар тугалга
PM2.5 ба PM10	Жижиг ширхэглэлт тоосонцор
PO43	Фосфатууд

## АГУУЛГА

<b>1. Товч танилцуулга.....</b>	<b>3</b>
1.1 Монгол улсын усны эрчим хүчний боломжит нөөц, хөгжил, өнөөгийн төлөв байдал.....	5
1.2 Монгол Улсын Засгийн газрын бодлого.....	6
1.3 Төсөл хэрэгжих бүс нутаг.....	7
1.4 Төслийн суурь судалгаа.....	9
<b>2. Ажлын зорилго, хамрах хүрээ .....</b>	<b>11</b>
2.1 Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын зорилго.....	11
2.2 Ажлын хамрах хүрээ .....	12
2.3 Байгаль орчин, төлөв байдлын судалгаа .....	13
2.4 Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ.....	13
<b>3. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ .....</b>	<b>13</b>
3.1 Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний зорилго .....	14
3.2 Уур амьсгал, агаарын чанар судалгаа.....	14
3.3 Гадаргын ба газрын доорхи ус .....	15
3.4 Физик бохирдол, хог хаягдал .....	16
3.5 Хөрс .....	16
3.6 Ургамал .....	17
3.7 Амьтан .....	17
3.8 Орчны физик бохирдол.....	18
3.9 Байгаль, түүх, соёлын дурсгалт газар.....	18
3.10 Нийгэм, эдийн засгийн байдал.....	18
3.11 Төслийн болзошгүй нөлөөллийг үнэлэх.....	19
3.14 Ховд голын сав газрын биологийн олон янз байдал (Biodiversity).....	19
3.15 Бичил уур амьсгал, түүний өөрчлөлт.....	19
3.16 Байгаль орчны асуудлууд.....	20
<b>4. Нийгмийн нөлөөллийн үнэлгээ .....</b>	<b>22</b>
4.1 Хууль эрх зүйн асуудал, бодлогын дүн шинжилгээ.....	23
4.2 Төслийн болзошгүй нөлөөллийг үнэлэх.....	24
4.2.1 Усан сангийн байгаль орчны нөлөөлөл.....	24
4.2.2 Загасны амьдрах орчин, үржлийн талаар.....	25
4.2.3 УЦС-ын доод хашицын урсацын байгаль орчны нөлөөлөл.....	26
4.2.4 Голыг зайлуулан урсгах үеийн зарцуулга.....	26
4.2.5 Ашиглалтын үед өвлийн улиралд үүсэх мөсний үзэгдлийн талаар.....	27
4.2.6 Усны болон дэд бүтцийн барилга байгууламжийн нөлөөлөл.....	27
4.2.7 Газар ашиглалт.....	28
4.2.8 Археологи, түүх соёлын дурсгалт зүйлс.....	29
4.2.9 Нүүлгэн шилжүүлэлт.....	29
4.2.10 Уугуул иргэд.....	30
4.4.11 Олон нийтийн харилцаа.....	31
<b>5. Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө.....</b>	<b>31</b>
5.1 Хяналт шинжилгээний хөтөлбөр.....	32
5.2 Олон нийтийн хэлэлцүүлэг.....	32
<b>6. Ажлын тайланг хүргүүлэх.....</b>	<b>33</b>
6.1 Тайлан хүргүүлэх шаардлага .....	33
6.2 Ажлын тайлан.....	33
6.2.1 Эхлэлийн тайлан .....	34
6.2.2 Ажлын хөтөлбөрийн санал .....	34

6.2.3 Явцын тайлан .....	34
6.2.4 БОННУ-ны тайлангийн төсөл.....	34
6.2.5 БОННУ-ны эцэслэсэн тайлан.....	34
6.2.6 Төр олон нийттэй, зөвшилцөх, харилцан ажлын тайлан .....	35
<b>7. Үнэлгээг хийж гүйцэтгэх компанийн ажлын хуваарь.....</b>	<b>35</b>
7.1 БОННУ – ын ажлын үе шатуудын төлөвлөгөө.....	35
7.2 Мэдээлэл, баримт бичгийн хяналт, өмчлөл.....	36
7.3 Үнэлгээ хийж гүйцэтгэх компанид тавигдах шаардлага.....	36
7.4 Үнэлгээ хийж гүйцэтгэх компанийн бүрэлдэхүүн.....	36

## 1. Товч танилцуулга

Өнөөгийн байдлаар Монгол улсын эрчим хүчний систем нь төвийн эрчим хүчний систем (ТЭХС), зүүн бүсийн эрчим хүчний систем (ЗБЭХС), баруун бүсийн эрчим хүчний систем (ББЭХС), Алтай-Улиастайн эрчим хүчний систем (АУЭХС), Өмнөд бүс гэсэн цахилгаан эрчим хүчний таван системээс бүрдэж байна.

### 2018 ОНЫ НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛТ, (энерги болон чадлаар)

Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем 2018 онд 8308,3 сая кВтцаг цахилгаан эрчим хүч боловсруулсан ба 1239,8 МВт чадал дамжуулсан байна. Үүний 80% буюу 6624,8 сая кВт цагийг дотоод эх үүсвэрүүд боловсруулж, 20% буюу 1683,6 сая кВт цагийг импортоор авч хангасан.

Цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл /сая кВт.ц/

Эх үүсвэр	2013	2014	2015	2016	2017	2018
ДЦС	5,014.0	5,191.3	5,415.8	5,555.9	5,826.9	<b>6,152.4</b>
ДиЦС	5.4	8.2	6.0	3.8	3.7	<b>3.7</b>
НЦС	-	0.6	0.5	0.3	19.7	<b>51.1</b>
УЦС	59.9	66.3	59.3	84.7	84.5	<b>78.2</b>
СЦС	52.9	125.4	152.5	157.5	154.4	<b>339.0</b>
<b>Нийт үйлдвэрлэл</b>	<b>5,132.2</b>	<b>5,391.8</b>	<b>5,634.1</b>	<b>5,802.2</b>	<b>6,089.2</b>	<b>6,624.4</b>

### БАРУУН БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМИЙН ЭКСПОРТ, ИМПОРТ

(ББЭХС)-ний цахилгаан хэрэглээ 2018 онд 163.2 сая кВт.ц байсан нь өмнөх оноос 8.7 сая кВт.ц буюу 5.6%-иар өссөн ба нийт хэрэглээний 28.2%-ийг Дөргөний УЦС үйлдвэрлэж, 71.8%-ийг ОХУ болон БНХАУ-аас цахилгаанаар импортлон хангасан байна.

Баруун бүсийн эрчим хүчний системийн цахилгаан эрчим хүчний хэрэглээ 2013-2018 он								
Д/д	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2013	2014	2015	2016	2017	2018
1	ЦЭХ-ний хэрэглээ	сая кВт.ц	126.5	145.9	143.5	146.8	150.8	<b>163.2</b>
2	ОХУ ба БНХАУ импорт	сая кВт.ц	90.3	106.6	111.9	103.5	105.7	<b>117.2</b>
3	Дөргөний УЦС үйлдвэрлэл	сая кВт.ц	36.2	39.3	31.6	43.3	45.1	<b>46.0</b>
4	Улсын төсвийн татаас	сая төгрөг	5,870.6	7,000.0	8,600.0	8,600.0	8,600.0	<b>8,600.0</b>



ББЭХС-ийн эрчим хүчний хомсдлыг шийдвэрлэхийн тулд Монгол Улсын Засгийн Газрын 2015 оны 4 дүгээр сарын 6-ны 133-р тогтоолоор Эрдэнэбүрэнгийн УЦС-ийн төслийг хэрэгжүүлэх шийдвэр гарсан.

"Эрдэнэбүрэнгийн УЦС" төслийн үндсэн зорилго ББЭХС-д тулгамдаж буй эрчим хүчний хомсдлыг бууруулах, тус бүсийн уул уурхай, аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлд шаардлагатай цаашид нэмэгдэх цахилгаан эрчим хүчний хэрэгцээг хангах, баруунд бүсэд сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлж өртөг багатай эх үүсвэрээс бүсийн эрчим хүчний дутагдлыг нөхөж ОХУ-ын импортын хамаарлаас гарахад чиглэж байна.

### **1.1 Монгол улсын усны эрчим хүчний боломжит нөөц, хөгжил, өнөөгийн төлөв байдал**

Монгол орны жилийн дундаж хур тунадасны хэмжээ 200-250 мм бөгөөд байгалийн бүс бүслүүрээс хамаарч 100мм/ жил-ээс 500 мм/жил (нутгийн баруун ба хойд хэсэгт жилд 400-500 мм байх бол нутгийн өмнөд хэсэгт 100-150 мм) байх ба, хур тунадасны жилийн нийт хэмжээ 305 км<sup>3</sup>, гадаргын усны жилийн дундаж урсац 22 км<sup>3</sup> байдаг.

Ус цаг уурын хүрээлэнгийн судалгаанаас харахад Монгол орны баруун, хойд хэсэгт байрлах нийт 3800 гаруй том, жижиг голуудын урсац олон жилийн дунджаар 3.46·10<sup>10</sup>м<sup>3</sup>, ба урт нь 65000км хүрэх бөгөөд 6300МВт хүчин чадалтай тул 56·10<sup>7</sup> кВт-ийн эрчим хүч гаргах боломжтой юм байна<sup>1</sup>.

Монгол орны усны эрчим хүчний анхны үнэлгээ, судалгаа 1950-аад онд хийгдэж, нийт хүчин чадлыг 3800 МВт гэж тооцсон байна (1960). Түүнчлэн 1960-аад онд Оросын "Гидроэнергиопроект" хүрээлэн, Монголын Хөдөө аж ахуйн яамны судлаачид Ховд, Сэлэнгэ, Эг, Орхон болон Туул голуудын урьдчилсан техник эдийн засгийн судалгаа

хийж нийт 1549 МВт суурилагдсан хүчин чадалтай жилдээ 7585.4 МВтц эрчим хүч гаргах боломжтой гэсэн тооцоо судалгаа гаргасан байна.

Монгол улсад өнөөгийн байдлаар 150кВт-аас 12МВт хүртэл хүчин чадал бүхий 18 усан цахилгаан станц баригдсаны 9 станц ажиллаж Баруун, Алтай-Улиастайн эрчим хүчний системд хамрагдан алслагдсан бүс нутгийг эрчим хүчээр хангаж байна. Монгол Улсад сэргээгдэх эрчим хүчний суурилагдсан хүчин чадал нь 87.4МВт байгаа нь нийт эрчим хүчний 8,13%-ийг бүрдүүлдэг ба үүний 28.175МВт (32,2%) усан цахилгаан станц, 5.425МВт (6,2%) нь нарны энерги, 53.8МВт (61,5%) салхин цахилгаан станцаас гарган авдаг байна.

## 1.2 Монгол Улсын Засгийн газрын бодлого

Эрдэнэбүрэнгийн УЦС-ыг барьж байгуулах талаар Монгол Улсын Их Хурал болон Засгийн газрын зүгээс дараах шийдвэрийг гаргаад байна:

1. УИХ-ын 2007 оны 10 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем” хөтөлбөрт **“2012-2022 онд Ховд гол дээр Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцыг барих”**.
2. УИХ-ын 2010 оны 24-р тогтоолоор баталсан Ус үндэсний хөтөлбөрийн 3.3.2-т “Ховд гол дээр урсацын тохируулга хийх, усан сан байгуулах, шилжүүлэн ашиглах боломжийн талаар судалгааг хийж, боломжтой газруудад зураг төсөл зохиох, барьж байгуулах ажлыг эхлүүлэх”, 3.3.20-т **“Эрдэнэбүрэнгийн 64МВт усан цахилгаан станцын техник эдийн засгийн үндэслэлийг хянан үзэж, боломжтой тохиолдолд бусад усан цогцолборуудтай уялдуулж гүйцэтгэх**.
3. УИХ-ын 2010 оны 48 тогтоолоор баталсан Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.5.1.7 зүйл - “Монгол улсын гадаргын усны ашиглалтыг сайжруулах үүднээс томоохон гол, мөрөнд урсацын тохируулга хийж усыг нөөцлөх, дамжуулах далд систем барьж байгуулна”;
4. УИХ-ын 2015 оны 63-р тогтоолоор баталсан Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого /2015-2030/-ын 4.1.1.4-т “Ховд гол дээр **усан цахилгаан станц баригдсан байх**”.
5. УИХ-ын 2014 оны 53-р тогтоолоор баталсан Монгол улсын Эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 6.3-т “Ховд аймгийн **Эрдэнэбүрэн сумын усан цахилгаан станцыг барьж байгуулах бэлтгэлийг хангах, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулах, төслийн нэгж ажиллуулах**” гэж заасан.
6. УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-д “2016-2020 онд нийт эрчим хүчинд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 20-д хүргэх” зорилт тавьсан.
7. Засгийн газрын 2015 оны 86-р тогтоолоор **Эрдэнэбүрэнгийн УЦС барих ТЭЗҮ-ийг шинэчлэн боловсруулж, хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх** боломжийг судлах.
8. Засгийн газрын 2015 оны 133-р тогтоолоор баталсан Концессийн зүйлийн жагсаалтанд **Эрдэнэбүрэнгийн УЦС-ын төслийг оруулсан**.
9. Эрчим хүчний сайдын 2015 оны 72 дугаар тушаалаар **Эрдэнэбүрэнгийн УЦС-ын төсөл хэрэгжүүлэх нэгж** байгуулагдан ажиллаж байна.
10. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 2018 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн Монгол Улсын Засгийн Газрын 160 дугаар тогтоолоор БНХАУ-ын ЗГ-аас МУ-н ЗГ-т олгох 1 тэрбум ам. долларын хөнгөлттэй зээлийн

хөрөнгөөр хэрэгжүүлэх төслүүдийн жагсаалтад “Эрдэнэбүрэнгийн УЦС барих” төслийг оруулсанаар санхүүжилтийн эх үүсвэр шийдэгдсэн.

11. Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц баригдах болон нуур үүсэх нутаг дэвсгэр 28000 га газрыг Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 09 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны №357 дугаар тогтоолоор улсын тусгай хэрэгцээнд авч, хилийн заагийн эргэлтийн цэгийн солбилцол, талбайн хэмжээг батлан шийдвэрлэсэн.

### 1.3 Төсөл хэрэгжих бүс нутаг

Ховд гол нь Төв Азийн гадагш урсацгүй ай савын томоохон голын нэг бөгөөд Монгол Алтай нуруунаас эх авч, өндөр уулс дундуур 516 км урсан Хар ус нуурт цутгадаг бөгөөд Хар- Ус нуурын экосистемд чухал үүрэгтэй. Ховд голын ус хурах талбай 58000 км<sup>2</sup>.

Ховд гол нь Монгол Алтайн уулархаг бүс нутгийн усны нөөцийн экологийн тэнцвэрийг хадгалахад онцгой нөлөөтэйгээс гадна их нууруудын сав газар дахь нууруудын усны балансыг тэнцвэржүүлэхэд чухал үүрэгтэй юм. Ийм томоохон урсац бүхий гол дээр олон талт зорилт бүхий боомт барих нь Монгол улсын эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад олон талын ач холбогдолтой юм.

Төлөвлөсөн УЦС нь Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын төвөөс баруун хойд зүгт 25 км-т байрлах Шижигтийн хавцалд байрладаг.

Шижигтийн хавцал нь Ховд хотоос 85 км, Улаанбаатар хотоос 1580 км, Баян-Өлгий аймгийн Баяннуур сумаас 54 км, БНХАУ-ын ШУӨЗО-ны Өрөмч хотоос 1100 км-ийн зайтай оршдог. УЦС-ын боомтыг барьж дууссаны дараа усан сан нь Баян-Өлгий аймгийн Баяннуур, Увс аймгийн Өмнөговь сумдын нутаг дэвсгэрийг хамрах болно.








### Зур.-1.3.1 Ховдын Эрдэнэбүрэнгийн УЦС-ын байршил

Усан цахилгаан станц баригдах болон нуур үүсэх нутаг дэвсгэр нь Ховд, Баян-Өлгий, Увс аймгийн уулзвар 4 сумын газар нутгийг дамнан байрладаг бөгөөд Газрын тухай хуулийн 16,1,13-ыг үндэслэн Эрчим хүчний сайдаас усан цахилгаан станц баригдах болон нуур үүсэх нутаг дэвсгэрийг улсын тусгай хэрэгцээнд авахаар №а/2445 албан тоотоор хандсаны дагуу Ховд аймгийн Иргэдийн төлөөлөгчидийн хурлын 78 тоот тогтоол, Увс аймгийн аймгийн Иргэдийн төлөөлөгчидийн хурлын А/92 тоот тогтоолоор дэмжсэн хариу ирүүлсэн. Засгийн газрын 2017 оны 287 дугаар тогтоолын хавсралт “Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хэмжээ, заагийг тогтоох, ашиглах журам”-ын 7.1-ийг үндэслэн шийдвэрлэсэн.

Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц баригдах болон нуур үүсэх нутаг дэвсгэр 28000 га газрыг Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 09 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны №357 дугаар тогтоолоор улсын тусгай хэрэгцээнд авч, хилийн заагийн эргэлтийн цэгийн солбилцол, талбайн хэмжээг батлан шийдвэрлэсэн.

Үүний дагуу Ховд, Увс, Баян-Өлгий аймгийн Засаг дарга нар болон Ховд аймгийн Мянгад Эрдэнэбүрэн сум, Увс аймаг Өмнөговь сум, Баян-Өлгий аймаг Баяннуур сумын Засаг дарга нартай “УЛСЫН ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНИЙ ГАЗРЫГ АШИГЛАХ ГЭРЭЭ”-г байгуулсан.

Газар зохион байгуулалт, геодези зурагзүйн газраас 2019 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн Улсын тусгай хэрэгцээний газрын гэрчилгээ, Улсын тусгай хэрэгцээний газрыг ашиглах гэрээ, Кадастрын зураг-ийг хүлээн авсан. Холбогдох баримтыг (Хавсралт 1) - т хавсаргав.



**Зур.-1.3.2 Ховдын Эрдэнэбүрэнгийн УЦС-ын Улсын тусгай хэрэгцээнд авсан газрын бүдүүвч**

#### **1.4 Төслийн суурь судалгаа**

2008 онд “М-Си-Эс Интернэшнл” ХХК, Япон улсын “Kyushu Electric Power Co.,Inc, “West Japan Engineering Consultants, Inc хамтран төслийн урьдчилсан-техник эдийн засгийн судалгааг гүйцэтгэсэн ба үүнд Ховд гол дээр баригдах усан цахилгаан станцын байгаль орчин, нийгэм, санхүү болон эдийн засгийн суурь судалгаа болон боломжит хувилбарын үнэлгээг хийсэн ба судалгааны тайланг Эрчим хүчний яамны судалгаа хөгжлийн төвийн техникийн зөвлөлд танилцуулж, хэлэлцүүлсэн.

Эрдэнэбүрэнгийн УЦС-ын урьдчилсан-техник эдийн засгийн судалгааны үр дүнд санал болгож буй төлөвлөж байгаа төслийн талбарыг Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын “Шижигтийн хавцал”-д барина гэж үзсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаар Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын Техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах талаар БНХАУ-ын BIDR компанитай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулахыг Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэнд зөвшөөрсөн. Үүний дагуу Эрчим хүчний сайд Даваасүрэн 2019 оны 3 дугаар сар 15-ны өдөр БНХАУ Төрийн өмчит China Water Resources Beifang Investigation Design and Research /BIDR/ компанитай Хөрөнгө оруулагч талын хөнгөлөлттэй зээлийн үндсэн шаардлага болон үнэлгээний

нөхцөлд нийцсэн хамтран ажиллах санамж бичиг-ийг эргэн төлөх нөхцөлгүйгээр байгуулсанаар судалгааны ажил эхэлж 2019 оны 10 дугаар сарын 31-ний өдөр “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” төслийн ТЭЗҮ-ний тайланг эцэслэн боловсруулж гүйцэтгэн ЭХЯ-нд хүлээлгэн өгсөн.

Шинэчилсэн ТЭЗҮ-д Газрын зургийг далангийн орчмын 20км<sup>2</sup> талбай усан сангийн 260км<sup>2</sup> талбай 1:2000 болон 1:5000 масштабтай зураглалыг шинэчлэн боловсруулсан.

Боомт байгуулах газрын сул шороон хайрга давхаргаас ул чулуун хөрсөнд хүрэх хамгийн зузаан хэсэг нь 90 метр. Төслийн талбарын боомтын орчимд голын ёроол нь элс хайрга чулуулгуудаас үелэн тогтсон, механик бүтцийн хувьд тохиромжтой, боомтод ашиглах боломжтой, ачаалал авах деформаци даах чадвараар боомтод ашиглах шаардлагыг хангаж байгаа

Газар хөдлөлтөд тэсвэртэй, барьж байгуулахад хялбар, бат бөх, үнийн хувьд боломжийн, төслийн талбарын орчимд элбэг байх байгалийн элс хайргыг боомтын дүүргэлтэнд ашиглах боломжтой зэргийг харгалзан бетон нүүртэй элс хайрга дүүргэлттэй далангийн төрлийг сонгон авсан.

#### **Эрдэнэбүрэнгийн УЦС-ын чадал болон Эрчим хүчний индекс**

	Нэгж	Тоо хэмжээ
Усны дүүрэн үеийн түвшин	М	1325.00
Үл ашиглагдах усны түвшин	М	1305.00
Усан сангийн нийт эзэлхүүн	сая м <sup>3</sup>	1140
Суурилагдсан чадал	MW	90
Жилийн дундаж эрчим хүч үйлдвэрлэлт	GWh	366
Хуурай улиралд үйлдвэрлэх дундаж үйлдвэрлэлт	GWh	166
Хуртай улирлын дундаж үйлдвэрлэх чадал	MW	54.9
Хуурай улирлын дундаж үйлдвэрлэх чадал	MW	32.2
Ажиллах цаг	Цаг	4061
Ус ашиглалтын түвшин	%	88
Тохируулгатай урсац	м <sup>3</sup> /с	131

**Эрдэнэбүрэнгийн УЦС** нь бетон нүүртэй хайрга элсэн дүүргэлттэй ус тогтоох боомт, станцын барилга, үерийн ус зайлуулах гаргалгаа, ус хальж урсах гадаргуу, ус сорох хоолой болон гаргалгаа, дамжуулах барилга зэргээс бүрдэнэ.

Боомтын дээд цэг нь 1328.00 метр. Үерийн ус өнгөрүүлэх байгууламжийн дээд доод гаргалгаа нь голын зүүн хэсэгт байрлана. Ус авах байгууламж нь голын зүүн хэсэгт боомтын хөндлөөс урсгалын дээд талдаа 200 метрт байрлана.

Дугуй хэлбэртэй түрэлтийн хоолойн туннелийн нийт урт 4835 метр. Станцын барилга нь голын зүүн эрэг талдаа хавцлын төгсгөл хэсэгт байрлана. Нийт 4 ширхэг 22,5 MW чадалтай францисс төрлийн турбин суурилагдах ба нийт 90 MW суурилагдсан хүчин чадалтай байна. Усан сан дахь усны нөөц, усан сангийн зохицуулалтын хүчин чадал, жилийн дундаж эрчим хүч, хуурай улирлын цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх,

нэгжийн эдийн засгийн үзүүлэлт зэргийг харгалзан үзэж суурилагдсан хүчин чадлыг 90 MW байхаар сонгон авсан. Хөрөнгө оруулалтын тооцоололд нэмэгдсэн өртгийн албан татвар, импортын татварыг чөлөөлж тооцсон ба газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн зардал, цахилгаан дамжуулах шугамын зардлыг оролцуулалгүй тооцсон болно.

Дээр дурьдсан үндсэн бүрэлдэхүүн хэсгээс гадна техник эдийн засгийн үндэслэлийн судалгааны явцад цаашид авч үзэх ёстой дараах дагалдах байгууламжууд шаардлагатай:

- Зам: Зам нь барилгын ажлын үед гол үүрэгтэйгээс гадна УЦС-ын ашиглалт, засвар үйлчилгээний ажлын үед ч чухал үүрэгтэй тул Эрдэнэбүрэн сумаас төслийн талбар хүртэлх замыг сайжруулах, барьж байгуулах шаардлагатай.

- Дамжуулах шугам: УЦС-ын үйлдвэрлэсэн эрчим хүчийг Мянгадын дэд станц хүртэл 220 кВ ЦДАШ, Эрдэнэбүрэн сум хүртэл 35 кВг-ын ЦДАШ ба УЦС-ын 220/110/35кВ-ын дэд станцыг шинээр барих (чадлыг сонгож) Мянгадын 110/35/10кВ-ын дэд станц, Эрдэнэбүрэн сумын 35/6 кВ-ын дэд станцыг өргөтгөх шаардлагатай.

**Барилгын ажлын үе шат:** Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд байгаль орчинд ихээхэн хэмжээний сөрөг нөлөө учирч болзошгүй байдаг тул барилгын ажлын үе шат чухал ач холбогдолтой. Тухайлбал, барилгын ажлын явцад ажилчдын түр амьдрах тосгон барьж байгуулах, техник хэрэгсэл төслийн талбарт байрлах, барилгын материал авах зорилгоор газар ухах, боомтын суурийн ухлагаас гарсан ашиглах бололцоогүй материалыг овоолох газар, барилгын материал хадгалах газар, тээврийн хэрэгсэл зэргийг тооцох ёстой.

## **2. Ажлын зорилго хамрах хүрээ**

### **2.1 Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын зорилго**

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай” хуулийн хүрээнд “Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ”-ний тайланг эрх бүхий мэргэжлийн байгууллага болох “Нью Гидро Проект” ХХК-аар хийж гүйцэтгүүлэн БОАЖЯ-аар батлуулсан.

БОАЖЯ-ны 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн албан тоотой ерөнхий шинжээч П.Цогтсайханаас ирүүлсэн “Ерөнхий үнэлгээний дүгнэлт”-д төсөл хэрэгжүүлэгч нь Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудаст заасан нарийвчилсан үнэлгээний явцад тодруулах асуудлууд, онцгойлон анхаарах чиглэлийг харгалзан Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэн 2020 оны 4 дүгээр улиралд багтаан БОАЖЯ-нд ирүүлэхийг мэдэгдсэний дагуу эрх бүхий байгууллагаар хийж гүйцэтгүүлсэн байх шаардлагатай юм.

Энэхүү үнэлгээ нь 2012 оны 5 сарын 17 – ны өдөр батлагдсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (БОНБУ) болон холбогдох бусад хууль журмын дагуу ажлын даалгаврын хүрээнд нийцүүлэн боловсруулах шаардлагатай.

Үнэлгээг хийж гүйцэтгэх компани нь байгаль орчны суурь судалгааны батлагдсан арга зүйд үндэслэн ажлыг гүйцэтгэх төлөвлөгөөг боловсруулан, шаардлагатай суурь мэдээллийг цуглуулж дээрх бодлого, хууль эрх зүйн баримт бичгүүдийн заалт,

шаардлага болон энэ даалгаврын хамрах хүрээний дагуу нарийвчилсан дүн шинжилгээ, үнэлгээ, тооцооллыг хийж зохих дүгнэлтүүдийг хийнэ.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний зорилго дараах үйл ажиллагаанд чиглэнэ. Үүнд:

- Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас тодорхой төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагаврыг урьдчилан тодорхойлж, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ тогтоох;
- Төслийн нөлөөллийн бүс ба нөлөөлөлд өртөх талбайг тодорхойлох;
- Физик, биологи, нийгэм-эдийн засаг, соёлын өнөөгийн төлөв байдал, нөхцлийг тодорхойлж, баримтжуулах;
- Өнөөгийн төлөв байдал, нөхцлийг өөрчилж болох төслийн бүтээн байгуулалт, үйл ажиллагааны үе шатны гол тулгуур бүтэц, бүрэлдэхүүн хэсэг, үйл ажиллагааг тодорхойлох;
- Үзүүлэх нөлөө, нөлөөллийг бууруулах арга хэмжээ, төслийн хувилбаруудыг тодорхойлохтой холбогдсон шийдвэр гаргалтанд олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж, санал дүгнэлтийг тусгах;
- Санал болгосон хувилбаруудаас үзүүлэх эерэг ба сөрөг нөлөөллийг тодорхойлох;
- Байгаль орчин/эдийн засаг талаас хамгийн сайн гэж тодорхойлсон хувилбараас үзүүлэх гол сөрөг нөлөөлөл (үүд)-д дүн шинжилгээ хийх;
- Сөрөг нөлөөлөл (үүд)-өөс зайлсхийх болон бууруулах эсвэл нөхөн төлөх, дүйцүүлэн хамгаалах эерэг нөлөөлөл (үүд)-ийг дэмжих арга хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэсэн боломжит, бодит, өртөг хэмнэсэн, орон нутгийн онцлогт тохирсон арга хэмжээг тодорхойлох;
- Төслийн бүтээн байгуулалтын асуудлаар цаашид авах арга хэмжээнд зориулан төсөл хэрэгжих ерөнхий боломжийг байгаль орчин/нийгмийн талаас авч үзсэн зөвлөмжийг шийдвэр гаргагчдад гаргаж өгнө.
- Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг (БОНБҮ) тухай хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу эрх авсан дотоодын аж ахуйн нэгж гүйцэтгэнэ.
- (БОНБҮ) тухай хуулийн 8.2-т заасан эрх бүхий аж ахуйн нэгж нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнгээр тайлан бэлтгэж, Байгаль орчны нөлөөллийг бууруулах арга хэмжээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулна.

## **2.2 Ажлын хамрах хүрээ**

Ховд гол дээр барих Эрдэнэбүрэнгийн УЦС-ын төсөл хэрэгжих боломжийг төслийн бүтээн байгуулалттай холбон үнэлэхийн тулд Эрдэнэбүрэнгийн УЦС-ын ТЭЗҮ-тэй уялдсан төслийн БОТБС, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ)-г Монгол Улсын доорх холбогдох хууль, журамд заасан аргачлалаар явуулна. Үүнд:

- 1. УИХ-аас 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдөр баталсан “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”**

2. Монгол улсын Засгийн газрын 2013 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 374 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт
  - **“Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”**
3. Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 1 дүгээр сарын 06-ны өдрийн А-03 дугаар тушаалын хавсралт
  - **“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам”**
4. Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 дугаар тушаалын 2 дугаар хавсралт
  - **“Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлал”**
5. Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 1 дүгээр сарын 06-ны өдрийн А-05 дугаар тушаалын хавсралт
  - **“Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тухайн жилд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”**

Эрдэнэбүрэнгийн УЦС-ыг Ховд аймгийн Эрдэнэбүрэн сум, Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын хооронд орших Шижигтийн хавцалд барих ба боомтыг барьж дуусгасны дараа үүсэх усан сан нь ихэвчлэн Баян-Өлгий аймгийн Баяннуур сум болон Увс аймгийн Өмнөговь сумын нутаг дэвсгэрт үүснэ.

Боомтоос доошхи Ховд голын хэсэг ба Хар ус нуурт үзүүлэх нөлөөллийг онцгойлон авч үзэх хэрэгтэй.

Төслийн БОТБС ба БОННУ-ний үр дүн нь хээрийн судалгааны төлөвлөлт, түүний хамрах орон зай, цаг хугацаа болон мэдээллийн олдоц, найдвартай байдал зэрэг олон хүчин зүйлсээс хамаарна. Иймд Үнэлгээг хийж гүйцэтгэх компани баг нь судалгааны хамрах хүрээг илүү нарийн тодорхойлох үүднээс өмнө хийгдсэн судалгаа, тайлан, бодлогын баримт бичгүүдтэй сайтар танилцан аргачлалын дагуу судалгааны тайланг боловсруулна.

### **2.3 Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ**

БОННУ-ний гол зорилго нь УЦС-ын төслийг хэрэгжүүлэх явцад тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгэм, оршин суугчдын эрүүл мэндэд учирч болзошгүй нөлөөллийг тодорхойлох, үнэлэх, түүний сөрөг үр дагавараас урьдчилан сэргийлэх, зайлсхийх, бууруулах, арилгах арга хэмжээг тогтооход чиглэнэ.

### **3. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ**

БОННУ- ний ажлын даалгавар нь Эрдэнэбүрэнгийн УЦС төслийн Ерөнхий үнэлгээний дүгнэлт болон байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний журам, үнэлгээний аргачлалтай маш сайн нийцсэн байх ёстой.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ нь дараах үе шаттай хийгдэнэ. Үүнд:

- Төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тодорхойлох,
- Болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг түүнд тохирох аргачлалаар үнэлэх,

- Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, үр дагаварыг арилгах арга хэмжээг тодорхойлох,
- Нөхөн сэргээх болон дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг тодорхойлох,
- Төсийн үйл ажиллагаанаас байгаль орчин, орон нутгийн иргэдэд учирч болзошгүй эрсдэлийн үнэлгээ хийх,
- Төслийн сөрөг нөлөөлөл багатай хувилбарыг сонгох,
- Төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах,
- Төслийн хяналт шинжилгээний хөтөлбөр боловсруулах
- БОННУ-ийн тайлан , түүний техникийн бус хураангуйг боловсруулах,
- Газар ашиглалтын өнөөгийн байдал, төслөөс орон нутгийн газар ашиглалтад үзүүлэх нөлөөлөл
- Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний гол зорилго, шаардлага, үнэлгээний цар хүрээг тодорхойлох
- Өмнөх судалгааны мэдээ, мэдээллийг цуглуулах, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг тодорхойлоход шаардлагатай нэмэлт судалгаа хийх,
- Судалгааны мэдээллийг эмхэтгэн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан боловсруулах.
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах зэрэг болно.

### **3.1 Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний зорилго**

Төлөв байдлын судалгаагаар өнөөгийн нөхцөл байдлыг тогтоож, баримтжуулан цаашид төслөөс үзүүлж болзошгүй нөлөөг урьдчилсан байдлаар тогтоож, БОННУ-ний хүрээнд нарийвчлан авч үзэх шаардлагатай нөхцөл, чухал ач холбогдолтой экосистемийн ба байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлох, гол нөлөөллийг үнэлэх, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, дүйцүүлэн хамгаалах менежментийн төлөвлөгөө, хяналт шинжилгээний төлөвлөгөө боловсруулахад онцгойлон анхаарах асуудлуудыг тусгана.

Иймд Үнэлгээг хийж гүйцэтгэх компани нь байгаль орчин, нийгмийн төлөв байдлын судалгааны ажлын төлөвлөгөөг боловсруулахдаа дараах асуудлууд (аргачлалд зааснаас гадна)-ыг нарийвчлан авч үзэх хэрэгтэй.

Төсөл хэрэгжсэнээр үүсч болзошгүй сөрөг нөлөөллүүд, хам болон хуримтлагдах нөлөөллийн талбайн заагийг тогтоох, тодорхойлох, газрын зурагт харуулах;

Ховд голын биологийн олон янз байдал, тэдгээрийн амьдрах орчин (төсөл хэрэгжих газрын эргэн тойронд үүсэх шууд ба шууд бус нөлөөллийн аль алинаар), ховор, устах аюулд орсон зүйлүүдийн амьдрах орчин бий болох боломж, Ховд голын сав газарт амьдардаг гол зүйлүүдийн тархац, статусыг нарийвчлан авч үзэх;

### **3.2 Уур амьсгал, агаарын чанарын судалгаа**

Үнэлгээг хийж гүйцэтгэх компани нь Бүс нутгийн уур амьсгалын онцлог, урт хугацааны ажиглалтын материалд үндэслэн сарын дундаж үзүүлэлтүүдийг тодорхойлж, цаг уур, уур амьсгалын нөхцөл байдал хүн амын амьжиргаа болон төслийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлөхийг тодорхойлно. Үнэлгээг хийж гүйцэтгэх компани нь бүс нутгийн агаарын чанарыг тодорхойлохдоо агаарын дээж авах, дээжийг лабораториар шинжлүүлнэ. Үнэлгээг хийж гүйцэтгэх компани нь дараах үзүүлэлтүүдээс чухал хэсгийг

сонгоно, үүнд: азотын исэл (NOx), хүхрийн давхар исэл (SO<sub>2</sub>), нүүрстөрөгчийн дугуу исэл (CO), жижиг ширхэглэлт тоосонцор (PM<sub>2.5</sub> ба PM<sub>10</sub>), хар тугалга (Pb), бусад хүнд металлууд, шаардлагатай бол хүлэмжийн хийг оруулж болно. Хээрийн судалгааны явцад хийсэн хэмжилт, дээжлэлт, фото зураг, лабораторийн шинжилгээний үр дүн, холбогдох газрын зургуудыг хавсаргана.

### 3.3 Гадаргын ба газрын доорх ус

Ус зүйн хээрийн судалгааны явцад төсөл хэрэгжих бүс нутгийн гадаргын усны сүлжээ (гол горхи, нуур цөөрөм, булаг шанд), гидрологийн нөхцөл, гадаргын ба газрын доорх усны нөөц, олон жилийн хэмжилтийн мэдээ, гидрологи, улирлын ба жилийн өөрчлөлтүүдийг тодорхойлно. Түүнчлэн төсөл хэрэгжих талбайн гадаргын ба газрын доорх ус ашиглалтын өнөөгийн байдал, бохирдол, нөөцийг үнэлж, үр дүнг нэгтгэж, холбогдох зургийг боловсруулна. Голын усны дулааныг УЦС-ын адгаас урсах урсацын горимд гарах өөрчлөлтөөр авч үзнэ. Мөсөн бүрхүүлийг тодорхойлж, голын адгийн мөсөн бүрхүүлд УЦС-аас үзүүлэх нөлөөг тогтоож баримтжуулна.

Төсөл хэрэгжих бүс нутгийн гадаргын усны үндсэн сүлжээ, гидрологийн баланс, нөөцийг зохих аргачлалаар тодорхойлж, зураглал хийж, зургийн тайлбар ба таних тэмдгийн хүснэгтийг гаргана.

Ус хуваарилалт, чанар, хомсдол, бохирдлын өнөөгийн байдал ба ирээдүйн хандлагыг тодорхойлж, хэмжинэ. Усны объектуудаас сорьц авч, хаягжуулан дараах үзүүлэлтүүдийг тодорхойлуулахаар стандартчиллын тохирлын гэрчилгээ бүхий дотоод, гадаадын шинжилгээний лабораториудад явуулна. Үүнд:

- Эрдсийн агуулга,
- Шим бохирдлын үзүүлэлтүүд,
- Хүчилтөрөгчийн горимын үзүүлэлтүүд (ууссан хүчилтөрөгч, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч-БХХ5, перманганатын исэлдэх чанар-ПИЧ, бихроматын исэлдэх чанар г.м)
- Хүнд металлууд: Hg, Fe, Mn, Ca, K, Na, Se, фосфор
- Тусгай үзүүлэлтүүд: нефть, нефтийн бүтээгдэхүүн, өөх тос, гадаргын идэвхт бодисууд зэрэг орно.

Үүнээс гадна газрын доорх устай харилцан нөлөөлөл байгаа эсэхийг тодорхойлж, гадаргын усны зургийг боловсруулна. Төсөл хэрэгжих байршил нь гидрогеологийн бүсийн зүй тогтлын хувьд аль хэсэгт хамаарах, тухайн сав газар, бүс, массивын онцлог, төслийн байршил нь газрын доорх усны тэжээгдлийн муж, усан хагалбар буюу усны урсац бүрэлдэх эх хэсэгт, усны хуримтлалын бүсэд, хөлийн бүсийн аль хэсэгт хамаарах, тухайн орчинд тархсан ус агуулагч үе давхаргуудын геологийн насны дараалал, байршлын зүй тогтол, тэдгээрийн коллектор шинж чанар, агуулагдаж байгаа усны гидравлик шинж чанар, газрын доорх усны хөдөлгөөний болон нөөцийн тоон үзүүлэлтүүд, химийн найрлага, чанар, нөөц горимыг судалж, тодорхойлон төсөл хэрэгжих орчны гидрогеологийн зураг, зүсэлт, схемүүдийг боловсруулна.

Шаардлагатай тохиолдолд гидроизогипсийн зураг, бохирдлын тархалтын зургуудыг боловсруулна. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрт олон жилийн цэвдэг тархсан



бол түүний зузаан, бүтцийг судалж физик шинж, дулааны горимыг тодорхойлон тухайн нутаг дэвсгэрийн цэвдгийн зургийг оруулж болно.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан судалгааны гидрогеологийн ажиглалтыг маршрутын шугам, ажиглалтын цэгийн бичлэг хийх хэлбэрээр бүхий л талбайг хамруулан явуулна. Гидрогеологийн маршрутын чиглэлийн талбайг хөндлөн огтолсон болон судалгааны объектуудыг дагасан чиглэлээр тогтоож, ажиглалтын цэгүүдийн зайг газар доорх усны илэрц, булаг, худаг, цооногийн байршлаас хамааруулан тогтооно. Судалгааны үед газар доорх усны тэжээл, хуримтлал, хөлийн бүсийг ялган тогтоох, төслийн байрлал аль бүсэд хамаарч байгааг тогтоох, төслийн үйл ажиллагаанд өртөгдөх байдлыг тогтооход голлон анхаарвал зохино.

Гидрогеологийн маршрутын судалгааны тэмдэглэлийг нягт нямбай хөтлөн ажиглалтыг тасралтгүй байдлаар явуулах шаардлагатай.

Судалгааны явцад хийсэн хэмжилт, дээжлэлт, фото зураг, лабораторийн үр дүн, холбогдох газрын зургуудыг хавсаргана.

### **3.4 Хог хаягдал, физик бохирдол**

УЦС-ыг барьж байгуулсны дараа үргэлжлэн явагдах ашиглалтын бүх хугацааны туршид гарах байгаль орчинд үзүүлэх нөлөө нь түүнийг барьж байгуулах үед гарах нөлөөнөөс ихээхэн ялгаатай учир барьж байгуулах үе шатанд онцгойлон анхаарал хандуулах шаардлагатай. Барилгын үед гарах зарим нөлөөлөл нь авч үзэж болохуйц байдаг бөгөөд харин энэ нөлөөллийг аль болох багасгахад анхаарал тавих ёстой.

Барилгын ажил явуулах хугацаанд орчинд үзүүлэх нөлөөллөөс хамгаалах арга хэмжээ нь түүнд тохирсон арга хэмжээ байдаг бөгөөд болзошгүй нөлөөлөлд тухай бүрд нь хамааруулан тохируулж арга хэмжээ авдаг. Эдгээрт ирээдүйд бий болох усан сангаас гадна ажилчдын тосгон, барилгын талбай, барилгын материалын талбай зэрэг бүх түр талбай, байгууламжууд хамаарна. Барилгын ажлын төгсгөл үед эдгээр газрыг хуучин байсан өнгө үзэмжинд нь оруулан сэргээн босгох, ургамалжилтыг аль болох анх байсан хэлбэрт ойролцоо байдалд оруулах арга хэмжээг авах шаардлагатай.

Мөн голд ойрхон явагддаг барилгын ажлын онцлог нь голын усыг бохирдуулах эрсдэл ихтэй байдаг. Усыг иймэрхүү бохирдуулдаг дараах 4 төрлийн эх үүсвэр мэдэгдэж байна. (1) Барилгын талбарт элэгдэл ихэссэнээс усны булингар нэмэгдэнэ, (2) Бетон буюу цемент нь усны рН-ыг ихэсгэдэг, (3) Машин механизмын түлш тосноос үүсэх нүүрс-устөрөгчийн бохирдол, (4) ойролцоогоор 800 хүн түр амьдрах тосгоноос үүсэх дотоод хаягдлын бохирдол зэрэг болно. Эдгээр бохирдлыг бууруулах, түүнээс зайлсхийх тохиромжтой арга хэмжээг тухай бүр авч байх шаардлагатай.

Агаарын бохирдол болон дуу чимээ нь мөн нөлөө үзүүлэх учир шаардлагатай арга хэмжээг авах хэрэгтэй.

### **3.5 Хөрс**

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний орчмын судалгаанд хамрагдсан талбайн хөрсний төрлийг тодорхойлж, түүний тархалт, морфологи хэв шинж, ус-физик-химийн чанар, үржил шим, ялзмагийн агууламжийг судалж, хөрсөн бүрхэвчийн зураглал үйлдэнэ. Судалгааны үед тухайн талбайд тархсан хөрсний морфологи шинж чанарыг

тодорхойлох болон хөрсний сорьц авах зорилгоор үндсэн (1.0-1.5 м хүртэл гүнтэй) болон хагас зүсэлт ( 50-80 см)-ийг тухайн хөрсний нийтлэг хэв шинжийг бүрэн төлөөлж чадах газрыг сонгон хийнэ. Хөрсний морфологи шинжийн бичиглэлийг хийж дууссаны дараа давхарга тус бүрээс дээж авч, фото зураг, бичлэг хийж баталгаажуулна. Дээжний хэмжээ ойролцоогоор 0.5 кг орчим байх бөгөөд газрын нэр, байршил, зүсэлтийн дугаар, дээж авсан гүн гэх мэт тэмдэглэл бүхий хаяг дээжинд хийж холбогдох лабораторид хүргэнэ.

Мөн судалгааны явцад тухайн газар нутгийн онцлог, хөрсний үржил шимт чанар, хөрсжих процессыг судлах, газар ашиглалтын хэлбэр, эдэлбэрийн төрлийг харгалзан мониторингийн цэгүүдийг сонгон анхдагч төлөв байдлын бичиглэл, хэмжилт, дээжлэлтийг хийсэн байна. Хөрсний үржил шим, бохирдлыг тодорхойлохын тулд дараах үзүүлэлтүүдийг лабораторид шинжлүүлнэ. Үүнд: рН, ялзмаг; Аммони (NH<sub>4</sub>); Нитрит (NO<sub>2</sub>); Нитрат (NO<sub>3</sub>); Фосфатууд (PO<sub>43</sub>-); Кали (K<sup>+</sup>); Нефть, нефтийн бүтээгдэхүүн; As, Hg, Cd, Pb, Ni, Cr, Se зэрэг хүнд металлууд; г.м орно. Хээрийн хэмжилт, дээжлэлт, лабораторийн шинжилгээний дүн, холбогдох зураглалыг боловсруулж хавсаргана.

### **3.6 Ургамал**

Төсөл хэрэгжих бүс нутгийн ургамлын төрөл зүйлүүдийг тодорхойлж жагсаалт гаргах, үндсэн бүлгэмдэл, тэдгээрийн хэв шинж, биомассыг тодорхойлж тайлбарын хамт боловсруулна. Ховор, ховордсон болон нутагшмал ургамлын төрөл зүйл, тэдгээрийн тархалт, хамгааллын статус зэргийг тодорхойлно. Мөн судалгааны талбайг хамарсан ургамалжилтын зураглал үйлдэнэ.

Судалгааны үед төсөл хэрэгжих талбай дах ургамлын зүйлийн бүрэлдэхүүнийг бүрэн хамарч тэдгээрийн хэмжээ, ургацын гарцыг тогтоох боломжтой газрыг сонгон ургамалжилтын бичиглэлийг хийж, ургамлан нөмрөгийн хучилтын хэмжээг нүдэн баримжааны, хучилтын проектын болон тоо-жингийн аргуудаас аль тохиромжтойг сонгон тодорхойлсон байвал зохино.

### **3.7 Амьтан**

Тухайн нутаг дэвсгэр дэх амьтны аймгийн төрөл зүйлийн бүрэлдэхүүн, тархалтын хүрээ, байршилт, шилжилт хөдөлгөөнийг тодорхойлж, аж ахуйн үйл ажиллагааны нөлөөгөөр устсан буюу дайжсан амьтан, тэдгээрийн тоо толгойн үзүүлэлт, цаашдын төлөв байдлыг тодорхойлно.

Шувуу, хоёр нутагтан, мөлхөгчид, хөхтөн, шавьжны төрөл зүйлүүдийн жагсаалтыг гаргана. Голын цутгал хэсгийн шувуудын популяцид үзүүлэх нөлөөг Эрдэнэбүрэнгийн УЦС-аас голын адгийн урсацын горимд өөрчлөлт оруулах хэсэгт судалсан байна.

Амьтны аймгийн судалгааны явцад тухайн нутаг дэвсгэрийн амьтны аймагт суурь үнэлгээ өгөх үүднээс сээр нуруугүй ба сээр нуруутан амьтдын зүйлийн бүрдлийг тогтоож, тэдгээрийн нягтшил, тоо толгойн хэмжээг тусгай арга зүйн дагуу тодорхойлох, ховор, ховордож буй, устах аюулд орж болзошгүй амьтдын жагсаалтыг гаргаж, тоо толгой, амьдрах орчны нөхцөлийн өнөөгийн төлөв байдалд үнэлгээ өгнө.

Үнэлгээг хийж гүйцэтгэх компани нь боомт барих газарт судалгаа явуулж, тэнд тархсан загасны зүйлийн жагсаалтыг гаргана. Ховордож, устаж болзошгүй зүйлийн загасны ангилалд орсон загас байгаа эсэхийг тогтоож загасны амьдрах орчны

тодорхойлолтыг гаргана. Усан сан болон голын адгийн хэсэгт амьдрах орчин хэрхэн алдагдах эсвэл нэмэгдэх боломжийг загасны зүйл бүрийн хувьд тодорхойлно. Үнэлгээг хийж гүйцэтгэх компани нь боомт барих газрын ойролцоох Ховд голын хэсэгт загасны түрс шахдаг газар байдаг эсэхийг тодорхойлно. Мөн боомт барих газрын ойр орчмын загасны нүүдлийн замналыг зүйл бүрээр тодорхойлсон байна. Усны урсгалын тодорхой хэсгүүдэд дээж авагчдыг байрлуулан загасны популяцийг тооцсон байна.

Монгол орны нугаламт амьтны зүйлийн тархац, идээшил, амьдрах орчин, дэлхийн болон бүс нутгийн ховордлын үнэлгээг Олон улсын байгаль хамгаалах холбооноос эрхлэн гаргасан шалгуураар үнэлж, Монгол улсын шувуу, хөхтөн амьтны хамгааллын статусыг улаан данс болон амьтны хамгааллын төлөвлөгөө зэрэг эх сурвалжийн мэдээллийг ашиглан тогтоох боломжтой.

### **3.8 Орчны физик бохирдол**

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрт дуу чимээ, доргио чичиргээ зэрэг биет бохирдлын эх үүсвэрүүд, тэдгээрийн өнөөгийн түвшинг тодорхойлно. Газар дээрх хэмжилт, шинжилгээний дүнг эх хувиар, холбогдох багаж, зураглалыг хавсаргана.

### **3.9 Байгаль, түүх, соёлын дурсгалт газар**

Байгаль, түүх, соёлын дурсгалт газарт онцгой сонин тогтоцтой хад чулуу, уул нуруу, гол горхи, нуур цөөрөм, хөшөө дурсгал, тусгай хамгаалалттай газар нутаг, байгалийн үзэсгэлэнт газар зэрэг хамаарагдах бөгөөд тэдгээрийн онцлог шинж, ач холбогдол, хамгааллын статус, өнөөгийн төлөв байдлыг тодорхойлж, тэдгээрийн хамгааллын арга хэмжээ, үнэлгээ, өнөөгийн удирдлагын чадавхийн талаар авч үзсэн байна.

### **3.10 Нийгэм, эдийн засгийн байдал**

Төсөл хэрэгжих бүс нутагт төслийн шууд болон шууд бус нөлөөлөлд өртөх магадлалтай сум, орон нутгийн иргэд, өрхүүд, тэдгээрийн бүртгэл, өнөөгийн амьдралын түвшин, хөдөлмөр эрхлэлт, орлогын түвшин, эзэмшил газар, үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө, ус хангамж, бэлчээр, тариалангийн талбай, мэдээлэл, нийтлэг үйлчилгээ (боловсрол, эмнэлэг, ахуйн үйлчилгээ, цахилгаан хангамж г.м)-ний хангамжийн түвшин, газар ашиглалт зэргийг судалж, дүгнэлтийг тусгана. Үүнээс гадна хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төслийн талаар мэдээллийг олон нийтэд хүргүүлж, тэдний саналыг авч тусгана.

Мөн дээрх иргэдийн эрүүл мэндийн өнөөгийн түвшин, өвчлөл, дундаж наслалт, нутагшмал ба халдварт өвчний нэрвэгдэлтийн талаар болон тэдний ариун цэвэр, орчны эрүүл ахуйн гол үндсэн үзүүлэлтүүдийг судалж тусгана.

Төсөл хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн харьяалагдах засаг захиргааны нэгж баг, сум дүүрэг, аймгийн хүн ам, нас хүйс болон хөдөлмөрийн нөөц, төсвийн орлого, зарлага, ажил эрхлэлт, дундаж орлого, аж үйлдвэр, хөдөө аж ахуй, дэд бүтцийн хөгжлийн өнөөгийн түвшин, худалдааны эргэлтийн хэмжээ зэрэг нийгмийн болон эдийн засгийн хөгжлийн түвшинг илтгэх бусад үзүүлэлтүүдийг тодорхойлж, үнэлгээ өгсөн байна.

Мөн тухайн орчинд хэрэгжиж байгаа бусад төслүүдийн талаарх товч мэдээллийг энд оруулах шаардлагатай бөгөөд энэ нь цаашид БОННУ хийхэд ихээхэн ач холбогдолтой.

### **3.11 Төслийн болзошгүй нөлөөллийг үнэлэх**

Эрдэнэбүрэнгийн УЦС-ын сонгосон байршилд үүсэх сөрөг нөлөөллийг үнэлэх, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах хамгийн сайн хувилбарыг сонгохын тулд энэ үнэлгээгээр байгаль орчин, нийгмийн төлөв байдлын нарийвчилсан үнэлгээ хийх, бодитой мэдээлэл, баримт цуглуулахыг шаардана. Энэ нөлөөллийн үнэлгээний дараа 3.4-т заасанчлан БОННУ-ээр холбогдох менежментийн төлөвлөгөө (нүүд)-ийг боловсруулсан байх ёстой.

Аливаа УЦС-ын төсөл нь хүчин чадал, хэмжээ, боомтын төрлөөсөө хамааран түүний холбогдох байгууламжуудаас хүрээлэн буй орчин, түүний био-гео-физик-хими болон экосистемд тодорхой өөрчлөлт бий болгодог.

Энд авч үзэх бусад асуудлуудын тухайд бичил уур амьсгал, усны нөөц, гол мөрний ёроолын хурдас, хагшаасны зөөгдөл, гидравликийн шинж чанар, газар хөдлөлтийн эрсдэл, чичиргээ орсон байна. Төсөл хэрэгжих газарт үер болж, энэ нь шууд ба шууд бус нөлөөллийн улмаас тухайн нутгийн газар ашиглалт, соёлын өв, нүүлгэн шилжүүлэлтийн асуудалд хүргэж болзошгүй.

### **3.14 Ховд голын сав газрын биологийн олон янз байдал (Biodiversity)**

Төсөл хэрэгжих бүс нутгийн биологийн **олон янз байдал** болон экосистемийн үйлчилгээнд төслийн зүгээс үзүүлэх урт хугацааны нөлөөллийг тодруулах нь нэлээд төвөгтэй байдаг. Гэсэн хэдий ч Үнэлгээг хийж гүйцэтгэх компани нь төсөл хэрэгжих бүс нутгийн биологийн **олон янз байдал** болон экосистемд үзүүлэх шууд болон шууд бус нөлөөллүүдийг үнэлэх шаардлагатай.

Мөн төслийн нөлөөлөлд өртөгч, сонирхогч зэрэг орон нутгийн иргэдийн биологийн төрөлжилт болон экосистемийн үйлчилгээний талаарх ойлголтуудыг уулзалт, санал асуулга хэлбэрээр тодорхойлох шаардлагатай.

Нөлөөллийг үнэлэхэд байгаль орчны төлөв байдлын судалгааны нэгдсэн үр дүнд үндэслэж экосистемд түшиглэсэн анализыг хийх их чухал юм. Үүний дараа төслийн үйл ажиллагаа, техник технологитой холбоотой үүсэх сөрөг нөлөөллүүдтэй уялдуулан авч үзэж төсөл хэрэгжих бүс нутгийн биологийн төрөлжилтэнд цаашид үзүүлэх бүхий л нөлөөллийг тодруулна.

Иймд Үнэлгээг хийж гүйцэтгэх компани нь төсөл хэрэгжих бүс нутагт өмнө цуглуулсан холбогдох мэдээлэл, материалыг нэгтгэн дүгнэж, төсөл хэрэгжих бүс нутгийн байгаль орчны чухал бүрэлдэхүүн хэсгүүдэд хийх судалгааг төслийн барилгын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулж төсөл хэрэгжих нутаг дэвсгэрт ландшафтын түвшний судалгааг хийж нөлөөлөлд өртөх экосистемийн чухал бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлно.

### **3.15 Бичил уур амьсгал, түүний өөрчлөлт**

Үнэлгээг хийж гүйцэтгэх компани нь сонгосон хөндлүүрийн хамт төсөл хэрэгжих бүс нутгийн бичил уур амьсгал, гадаргын усны баланс ямар нөлөө үзүүлэхийг судалж,

харьцуулалт хийнэ. Ховд голын сав газрын гидрологийн цаашдын нөхцлийг урьдчилан тогтоохын тулд бүс нутгийн уур амьсгалын загварчлалын систем ба бүс нутагт ажиллаж буй бусад УЦС /Дөргөний/-тай харьцуулсан үр дүнд үндэслэн бүс нутгийн уур амьсгалын өөрчлөлтийг тодорхойлсон байна.

Үнэлгээг хийж гүйцэтгэх компани нь төслийн бүтээн байгуулалтын ажлын явцад (олон тооны хүнд машин механизм, замын хөдөлгөөн өндөр байх учир) ялгарах хүлэмжийн хийн ялгаралтын хэмжээг тооцоолох мөн төсөл хэрэгжсэний дараа цахилгаан эрчим хүчний хүчин чадлыг тодорхойлон жилд үйлдвэрлэх боломжтой эрчим хүчний хэмжээг тооцож нүүрсээр ажиллаж байгаа дулааны цахилгаан станцуудтай харьцуулах замаар хүлэмжийн хийн ялгаралтанд нөлөөлөх нөлөөллийг үнэлэх шаардлагатай.

### **3.16 Байгаль орчны асуудлууд**

- Загасны популяци

Орон нутагт загасны популяцийг судлах эхний алхам бол баригдах боомтын ойролцоох гол, нуурт амьдардаг, тэнд тархсан биологийн олон янз байдлыг тогтоох юм. Орон нутгийн түвшинд ямар зүйлийн загас тархсан, тэдгээрийн экологийн ач холбогдол юу болох, эсвэл устаж болзошгүй зүйлүүд байгаа эсэхийг тогтооно. Төлөвлөгдөж байгаа боомтоос доош орших загас түрсээ шахдаг байршил нь барилгын ажлын үед болон УЦС-ын үйл ажиллагаанаас болж сөрөг нөлөөлөлд орох эсэхийг тогтооно.

- Амьдрах орчин нэмэгдэх эсвэл алдагдах эсэх

Загасны зүйлийн жагсаалтыг гаргасны дараа хийх хоёр дахь алхам бол тухайн гол мөрний экологид тэдгээр зүйл ямар ач холбогдолтой болохыг тодорхойлох юм. Гол үндсэн, устаж болзошгүй эсвэл ховордож байгаа зүйлийн ангилалд орсон загасны амьдрах орчинг тогтоох хэрэгтэй. Иймд загасны зүйлүүдийн амьдрах орчинд төслөөс ямар эерэг ба сөрөг нөлөө (нэмэгдүүлэх ба алдагдуулах) үзүүлэхийг тооцно. Голын эргийн морфологи, гидрологи, материалын шинж чанарыг тодорхойлох нь загасны амьдрах орчинг тодорхойлох ерөнхий суурь мэдээлэл болно. Эдгээр мэдээллээс эхлээд нарийн судалгаа хүртэл загасны зүйлийн популяцид үзүүлэх нөлөө ялангуяа усан сангаас Ховд голын адаг дахь амьдрах орчинд үзүүлэх эерэг ба сөрөг нөлөө (нэмэгдүүлэх ба алдагдуулах)-г тодорхойлно.

- Гол, нуурын цутгал хэсэг

Гол, нуурын цутгал хэсэг загасны зүйлүүдийн чухал амьдрах орчин байдаг. Усан санд ус хураасны дараа голын цутгал хэсэг нь загасны түрс шахах чухал орчин байдаг. Иймд байгаль орчны тогтвортой байдлын асуудалтай холбон эдгээр амьдрах орчны боломжийг судлах нь чухал байна. Түүнчлэн эдгээр амьдрах орчин усан сангийн амьдрах орчны алдагдлыг бууруулахад хувь нэмэр оруулж болно. Иймд загасны популяцид учрах саад, боомтоос унах, үл нийцсэн зохимжгүй цутгал хэсэг бий болох эсэхийг тодорхойлно. Эдгээр цутгал хэсэгт цаашид бий болох усан сангаас үзүүлэх нөлөө, тухайлбал тус орчин харь зүйл нүүдэллэн орох замнал (тус орчинд өөр амьтдын нүүдлэх зам) болох эсэхийг тодорхойлоход чухал байж болно.

- Загасны нүүдэл

Загасны ялангуяа хариус, сугас загасны нүүдлийг гол түлхүүр болгон авч үзэх хэрэгтэй. Ховд гол дээр барих боомт зарим зүйл загасны нүүдэлд саад учруулж болзошгүй юм. Иймд боомтын ойролцоо загасны нүүдэл хэрхэн хийгдэх, тухайн зүйлүүдэд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээг тодорхойлон, загас барих/загасчлах аюулгүй арга техник (жишээ нь: тор ашиглахаас зайлсхийсэн)-ийг тодорхойлно.

- Голын адаг дахь загасны популяци

Ховд гол ойролцоогоор 516 км урт. Эрдэнэбүрэнгийн УЦС-аас Хар-Ус нуур хүртэл ойролцоогоор 120 км байна. УЦС-ыг барьснаар Ховд гол болон Хар-Ус нуурын урсацын горимд өөрчлөлт гарч болзошгүй юм. Урсацын горимын нөлөөг боомтоос голын адаг хүртэлх зайд тодорхойлж, дүн шинжилгээ хийж голын адгийн амьдрах орчинд үзүүлэх нөлөө ямар байхыг тогтооно. Гол зорилго нь Ховд голын адаг, ялангуяа голын цутгалан, Хар-Ус нуурын экосистемд өөрчлөлт оруулахгүй байх явдал юм. Иймд Үнэлгээг хийж гүйцэтгэх компани нь ховор, ховордсон зүйлүүдийн амьдрах орчинг өөрчлөх эсвэл доройтуулах эсэхийг тодорхойлно.

- Байгалийн өв

Үнэлгээг хийж гүйцэтгэх компани нь Байгаль орчин, нийгмийн чухал ач холбогдолтой бүрэлдэхүүн хэсэг бүхий нуур, гол мөрний цутгалд төслөөс ямар нөлөө үзүүлэхийг үнэлэхдээ Дэлхийн байгаль хамгаалах олон улсын холбоо (IUCN) -ны холбогдох удирдамж /заавар/ -ыг баримтална.

- Ус ашиглалт

Усны урсацын горимын өөрчлөлт боомт барих газар, Ховд голын адагт гарна. Иймд томоохон хот суурин, сум тосгоны ойролцоо урсацын горимын өөрчлөлтийн нөлөө ямар байх, үйлдвэрлэлийн ба ахуйн зориулалтаар ашиглах усны хэмжээнд ямар нөлөө үзүүлэхэд дүн шинжилгээ хийнэ.

- Элэгдэл

Урсацын горимын өөрчлөлт, шинэ усан сан нь эргийн тогтвортой байдал, элэгдэл, тунадасны тэнцвэртэй байдалд нөлөө үзүүлж болно. Иймд шинэ усан сангаас Ховд голд үзүүлэх нөлөө, ус хураах явцад эргийн шугамд үзүүлэх нөлөө, цахилгаан станцийг барьж, ажиллуулснаар голын адаг дахь булингаршил нэмэгдэх эсэхийг судлах хэрэгтэй.

- Уур амьсгалын өөрчлөлт

Уур амьсгалын өөрчлөлтийн зарим үзүүлэлтээс харахад хэсэг хуурай үеийн дараагаар ширүүн устай бороо гэнэт орох байдлаар хур тунадасын хэв маягт өөрчлөлт гардаг. Иймд төсөл хэрэгжих газарт орон нутгийн ба бүс нутгийн хэмжээнд уур амьсгалын төлөв байдалд дүн шинжилгээ хийж, уур амьсгалын өөрчлөлт тухайн газарт ямар нөлөө үзүүлэхэд үнэлгээ хийнэ.

- Тектоник гадаргуу

Ховд голын бүс нутгийн хэмжээнд тектоник гадаргуу тогтоогдсон. Энэ талаарх мэдээллийг техникийн асуудал гэж үзэж, боомтоос доод хэсгийн популяцид эрсдлийн хамгийн бага түвшинд байлгах шийдлийг санал болгоно.

#### 4. Нийгмийн нөлөөллийн үнэлгээ

Энэхүү үнэлгээг Ерөнхий үнэлгээний дүгнэлтийн агуулгатай нийцүүлэн БОННУ хийх журам, аргачлал хоёрыг хослуулан хийх шаардлагатай. Үүнд:

- Төслөөс нийгэм- эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тодорхойлох,
- Төслийн хэрэгжилтийн явцад үүсч болзошгүй нийгмийн сөрөг нөлөөллийг үнэлэх,
- Нийгмийн сөрөг нөлөөлөл багатай хувилбарыг тодорхойлох,
- Нарийвчилсан үнэлгээний үр дүнг орон нутагт хэлэлцүүлэх,
- Нийгмийн нөлөөллийн үнэлгээний тайлан, түүний техникийн бус хураангуйг боловсруулах

**Оролцогч талуудын дүн шинжилгээ:** нөлөөлөлд өртөж болзошгүй хүмүүсийг тодорхойлох, байгалийн нөөцөөс хүртэх эсвэл ашиглахад гарах өөрчлөлтийн улмаас ашиг сонирхол, эрх нь хөндөгдөх байдал, аль асуудал ашиг сонирхол (зөвхөн байгалийн нөөцийн төлөө өрсөлдөөнөөр хязгаарлахгүй, ус, газрын эрх тодорхой бус байх, төслийн үр ашиг, өгөөжийн хуваарилалт, нутгийн иргэд олон нийтийн дотоод эв нэгдэл хангалтгүй байх, төслийн талаар өөр өөр байр суурьтай байх, хэлэлцүүлэг ба оролцооны чанарын асуудлыг оруулан)-ыг хамгийн ихээр хөндөж нөлөөллийг тогтоох,

**Олон нийтийн хэлэлцүүлэг, мэдээлэл харилцаа холбоо:** төслийн талаарх олон нийтийн ойлголт, тэдний санаа зовж буй асуудлуудыг тогтоож баримтжуулах, оролцогчдын бүлэг бүрт зориулсан хамтран ажиллах стратеги гаргах,

**Төслийн хувилбаруудыг үнэлэх:** төслийн боломжит хувилбаруудаар харьцуулах, үүнд: “төсөл хэрэгжихгүй байх” хувилбарыг оруулах, усны эх ба төсөл хэрэгжих бүс нутгийн аль алины хувьд төслийн тогтвортой байдал болон төслийн боломжит өртөг зардлыг үнэлэх.

**Хуримтлагдах нөлөөлөл:** усны эх ба төсөл хэрэгжих бүс нутгийн хооронд бий болох эерэг, сөрөг хуримтлагдах нөлөөллийг тодорхойлж, харьцуулах, үүнд Хар-Ус нуур болон төлөвлөж буй УЦС-ын бүтээн байгуулалтын ажлын нөлөөллийг оруулах шаардлагатай. Хуримтлагдах нөлөөллийн боломжит эх үүсвэрт ус, эрчим хүчний төслүүд, тэдгээрийн хэрэглэгчдийг авч үзэх хэрэгтэй.

**Нүүлгэн шилжүүлэлт, үүгүүл иргэдтэй холбоотой төлөвлөлтөнд үндэслэл гаргах:** Монгол улсын холбогдох хууль, журмын дагуу нүүлгэн шилжүүлэлт, уугуул иргэдэд үзүүлэх нөлөөллийн аль алины тухайд нөлөөлөлд өртөх газар нутаг тодорхой болсон тохиолдолд тухайн орон нутгийн онцлогт нийцсэн үйл ажиллагааны төлөвлөгөө шаардлагатай. Харин төслийн газар нутаг тодорхой бус шийдэгдээгүй байх тохиолдолд зөвхөн төлөвлөлт эсвэл бодлогыг авч үзэхийг шаардана.

**Нүүлгэн шилжүүлэлтэнд дүн шинжилгээ хийж, баримтжуулах:** нүүлгэн шилжүүлэхээс зайлсхийх, нүүлгэн шилжүүлэхгүй байх хувилбарыг үнэлэх, төсөлд шаардлагатай газар, нөөц-д ямар гол нөлөө үзүүлэхийг тодорхойлох (энд албан ба албан бус завсрын газар тариалан эсвэл нүүдлийн мал аж ахуй, үүсэх эрсдэл, эмзэг байдалд гол анхааран нийгмийн бүх бүлгийг тодорхойлох, ус ба газар ашиглалт/ эзэмшлийн бүх хэлбэрийг тогтоох, үзүүлэх бүх нөлөөлөл (төслийн нөлөөгөөр шилжин суурьших ба эдийн засгийн нөлөөнд өртөх хүмүүсийн аль алинд үзүүлэх)-ийг тодорхойлох, бүрэн

хэмжээний (100%) бүртгэл, нийгэм-эдийн засгийн судалгаа явуулах, хөрөнгийн өмчлөлийг баталгаажуулах, нөлөөлөлд өртөх иргэдийн өмч хөрөнгийн эзэмших хэлбэр, нөлөөллийн хүч, төрлөөр тэдний ангилалыг тодорхойлсон тодорхой шалгуурыг санал болгоно.

**Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөнд дараах үйл ажиллагаа орно:**

- Төлөвлөлтийн явцад нөлөөлөлд өртөх талуудтай хэлэлцүүлэг явуулж баримтжуулах,
- Дахин байршуулах газар, хөрөнгийг сонгоход оролцох асуудлыг багтаасан тодорхой хувилбар, нөлөөллийг бууруулах арга хэмжээ<sup>2</sup>-ний сонголт,
- Нөлөөлөлд өртөх өмч хөрөнгийн зах зээлийн болон нүүлгэн шилжүүлэлтийн зардлыг тооцох аргыг оруулан нөлөөлөлд өртөх өмч хөрөнгийн бүртгэл судалгаа гаргах,
- Үйл ажиллагааг хэрэгжүүлэх төсөв, хуваарь, нүүлгэн шилжүүлэх хуваарийг иргэний ажлын багцтай холбох,
- Шинэ газарт суурьшсан ба шинэ үйл ажиллагаанд хамрагдсан хүмүүсийн амьжиргаа дээшилсэн байх эсвэл наад зах нь өмнө олж байсан цэвэр орлогыг олдог байх, үр дүнг хэмжиж тогтоох хяналт мониторингийн механизм, индикатор орсон байна.
- ✓ **Уугуул иргэд:** олон нийт, иргэдийн дэмжлэгийг өргөнөөр бий болгоход туслах ахуй соёлд нийцсэн чөлөөт, урьдчилан мэдээлсэн хэлэлцүүлгүүдийг явуулан баримтжуулах, энэ хүрээнд:
- ✓ Уугуул иргэдийн уламжлан эзэмшиж, өмчилж, эсвэл ашиглаж, амьдарч ирсэн газар нутаг, тэдний ахуй амьдрал хамааралтай байгалийн нөөцийг тодорхойлох;
- ✓ Төслийн уугуул иргэдэд үзүүлэх эерэг ба сөрөг нөлөөг нөлөөлөлд өртөх уугуул иргэдэд урьдчилан мэдээлсэн хэлэлцүүлэгт үндэслэн үнэлэх;
- ✓ Уугуул иргэдийн байгалийн нөөцтэй ойр холбоотой байдгийг харгалзан төслөөс уугуул иргэдэд учруулах эрсдэл, эмзэг байдлыг үнэлэх;
- ✓ Нөлөөнд өртөх хүмүүсийн тухайд сөрөг нөлөөллөөс зайлсхийх ба зайлсхийх боломжгүй тохиолдолд нөлөөллийг бууруулах, эсвэл нөхөн төлөх үйл ажиллагааг төлөвлөх;
- ✓ Төслийн хүрээнд уугуул иргэдэд ахуй соёлд нь нийцсэн үр ашгийг хүртээх үйл ажиллагааг төлөвлөсөн байна.

**Хэрэгжилтийг зохион байгуулах хэлбэр:** төсөл хэрэгжүүлэхэд хамтын ажиллагаа, оролцоо нь чухал төрийн байгууллага, агентлаг, хувь хүмүүс бүхий оролцогч бүх талуудыг тодорхойлох, тодорхой үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлэх чадварыг нь үнэлэх, төлөвлөсний дагуу хэрэгжүүлэхэд шаардагдах чадавхи бүрдүүлэх бодит төлөвлөгөө орсон байна.

#### **4.1 Хууль эрх зүйн асуудал, бодлогын дүн шинжилгээ**



Төсөл амжилттай хэрэгжих нь олон улсын холбогдох гэрээ, хэлэлцээр, дотоодын хууль, эрх зүйн баримт бичигтэй нийцэж, дагаж мөрдсөн эсэхээс ихээхэн шалтгаалдаг тул төсөлтэй шууд холбогдох олон улсын гэрээ хэлэлцээр, үндэсний хууль тогтоомж, бусад эрх зүйн баримт бичгийг нарийвчлан судлах шаардлагатай. Иймд БОННУ-гээр төсөл хэрэгжүүлэхэд зайлшгүй авч үзэх үндэсний хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, хөтөлбөр, Монгол улсын нэгдэн орсон олон улсын конвенц, хоёр талт гэрээ хэлэлцээр, тэдгээрийн хүрээнд хийсэн үүрэг амлалтыг авч үзнэ.

Монгол улсын холбогдох хууль, журмын дагуу **Эрдэнэбүрэнгийн УЦС-ын төслийн БОННУ-г боловсруулахад баримтлах стандарт, арга зүйг тодорхойлсон байна.**

Үнэлгээг хийж гүйцэтгэх компани төслийн хууль, эрх зүйн хүрээнд хамаарах олон улсын гэрээ, хэлэлцээр, үндэсний хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн жагсаалтыг гаргаж, үйл ажиллагааны эхлэлийн ажлын төлөвлөгөөнд хавсаргана. Түүнчлэн судалгааны явцад шинээр гаргах шаардлагатай эрх зүйн ба бодлогын асуудлыг тусад нь авч үзвэл зохино.

Монгол улсын хууль, журмын хүрээнд баримталж буй бодлого нь олон улсын гэрээ, хэлэлцээрүүдийг тэргүүнд авч үздэг онцлогтой.

## **4.2 Төслийн болзошгүй нөлөөллийг үнэлэх**

### **4.2.1 Усан сангийн байгаль орчны нөлөөлөл**

Үнэлгээг хийж гүйцэтгэх компани нь Ховд голын урсацын горимд үзүүлэх сөрөг нөлөөллийг үнэлэх гидрологийн загварыг боловсруулах ба энэ зорилгоор мэдрэмжийн шинжилгээг хийнэ. Мөн Ховд голын сав газрын хэмжээнд ус, цаг уурын станцуудын олон жилийн хэмжилтийн мэдээ мэдээлэлд үндэслэн Ховд голын гадаргын усны нөөц/өөрчлөлтийн улирлын ба олон жилийн өөрчлөлтийг авч үзнэ. Дээр дурьдсанчлан бүс нутгийн уур амьсгалын өөрчлөлтийн үнэлгээг харгалзах хэрэгтэй.

Бүс нутгийн уур амьсгалын өөрчлөлтийн загвар, тэдгээрийн үр дүнг ашиглаж урсацын загварыг ажиллуулан усан сангийн дээд хэсэгт ирэх хамгийн их урсацыг тооцоолж үер тохиолдох магадлалыг үнэлэх шаардлагатай. Мөн усан сангаас дооших голын татам нугын экосистемд шаардлагатай экологийн хамгийн бага урсацын хэмжээг тооцоолно. (энэ хэсгийн мэдээлэл нь ТЭЗҮ-д илүү нарийн тусах учир харилцан мэдээллээ солилцох хэрэгтэй).

Дараах шалгуурт үндэслэн УЦС-ын орчмын талбайг үнэлнэ:

- Усан сангийн оновчтой хэмжээг тогтоох, усан сангийн тогтонги түвшинд хамрагдах газар нутгийг тогтоох, улмаар газар ашиглалтанд гарах өөрчлөлтийг өнөөгийн газар ашиглалттай харьцуулан үнэлэх, тодорхойлох,
- Аливаа сөрөг нөлөөллийг багасгахын тулд усан сангийн нөлөөлөлд өртсөн талбайг багасгах боломжийг судлах,
- Ховд гол дээр хаалт бий болсноос үүдэн байгалийн амьдрах орчинд нөлөөлөх боломжийг тодорхойлох, ялангуяа загасны нүүдэл, шилжих хөдөлгөөнийг тодорхойлох, улмаар загас өнгөрүүлэх байгууламжийн хамгийн зөв төлөвлөлтийг хийх,

- Усан сангийн тогтонги түвшинээс агаар мандалд алдагдах ууршилтыг тооцоолон Ховд голын усны горимд үзүүлэх нөлөөллийг үнэлэх,
- Усан сангаас дооших экологийн урсацыг (Хар ус нуур хүртэл) үнэлэх,
- Усан сангийн зуны ба өвлийн горим болон усны температурыг тодорхойлох, усан сангаас голын цутгалан, загасны популяцид үзүүлэх нөлөөллийг үнэлэх,
- Усан сангаас усны чанарт үзүүлж болзошгүй нөлөөллийг үнэлэх, биологийн болон химийн хэрэгцээт хүчилтөрөгчийн өөрчлөлтийг судлах, улмаар усан орчин болон усан орчны амьдралд нөлөөлж болзошгүй нөлөөллийг үнэлэх (органик бохирдол, сээр нуруугүй амьтанд үзүүлэх нөлөөллийг үнэлэх, замагны өсөлтөөс үүсч болох аливаа үйл явц процессыг үнэлэх гэх мэт)
- Усан сангийн дүүргэлтийн хугацаа болон тухайн үеийн экологийн алдагдлыг тогтоох,
- Усан сан дахь голын хагшаасны хуримтлалын хэмжээг үнэлэн, хагшаасыг хязгаарлах боломж зэргийг судална.

#### **4.2.2 Загасны амьдрах орчин, үржлийн талаар**

Загасны шилжилт хөдөлгөөн, нүүдэлд сөрөг нөлөө багатай, үржлийн нөхцлийг хэвээр байлгах зорилгоор усны урсац болон түвшинг загасны экологид тохируулан тооцно. Загасны амьдрах орчны тогтвортой байдлын дүн шинжилгээ нь усан сангийн дүүргэлтийн болон ашиглалтын үед загасны амьдрах орчинг хамгаалах, нөхөн сэргээх боломжийг олгоно. Усан санд байх загасны тэжээлийн эх үүсвэрийг бий болгох, загасны жарамгай, жараахай болон өсвөр насны загасыг гэмтээхгүй байхаас урьдчилан сэргийлж хамгаалалтын байгууламжийг орчин үеийн арга, технологиор оновчтой хийх, загасыг гэмтээхгүй байхаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг тусгасан байна. Загасны амьдрах орчин алдагдах, сайжрах боломжийг усан сан ба голын адагт тооцсон байна.

Ус зүйн параметр, тооцоог сайн тооцож бодсоны үндсэн дээр хавар, зуны улиралд шар усны үерийг зохицуулан урсгах, бага болон дунд устай жилүүдэд өвлийн горимыг зөв зохицуулах тооцоо үндэслэлийг инженер техникийн судалгаанд оруулсан байна. Хавар загасны үржил явах үед усны температурын ямар ч нөхцөлд байгаль дах загасны үр хөврөлийн хөгжил, мөн загас үржүүлгийн газраас зориудаар үржүүлэн тавьсан бие даан амьдрах чадвартай жарамгай, жараахайн хөгжил хэвийн явагдахаар усны урсацыг тохируулах арга хэмжээг тооцох, усан сан бүсчлэлийг тодорхой гаргаж, тэр дундаа зохиомлоор үржлийн субстрат гаргах бололцоог тооцоолон оруулна. Усны хэмийн өөрчлөлтийн нөлөөг адгаас боомт хүртэлх зайд загасны түрс шахдаг хэсэгт судална.

Усны урсацыг байгалийн горимтой нь ойролцоо байлгах, усны амьтад тэр дундаа загас чөлөөтэй шилжих эсвэл дасан зохицоход хялбар боломжийг хангахыг эрмэлзэнэ.

Тухайн орчинд амьдрах загасны зүйлийн бүрэлдэхүүнийг бүрэн тогтоож, Шивэр хадран, Монгол хадран, Алтайн сугас болон Нохой сугас загасны тархац байршил, үржих болон идээшлэх газрыг тогтоох, тэдгээрийг хамгаалах арга хэмжээг төлөвлөнө.

Загас үржүүлгийн газрын байгууламжийн хүчин чадал, бүтэц, үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг үнэлж, байршлын сонголт, технологийн дүгнэлт, төлөвлөлтийг

гаргана. Эцэст нь загас үржүүлгийн байгууламжийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг гаргана.

#### **4.2.3 УЦС-ын доод хашицын урсацын байгаль орчны нөлөөлөл**

Боомт барих болон голын байгалийн урсацыг өөрчилснөөс зэрлэг ан амьтдын амьдрах орчин, нүүдлийн зам хаагдах эсэх (загасны шилжин нүүх хэсэг) болон газрын доройтол зэрэг болзошгүй сөрөг нөлөөллийг тогтоон үнэлнэ.

Усан сан дүүргэх үед үүсэх голын байгалийн урсацад гарах өөрчлөлт, түүний нөлөөллийг төслийн эхний үе шатанд тодорхойлох хэрэгтэй. Дүүргэлт хийх үеийн УЦС-ын боомтоос доош экологийн урсацыг тодорхойлсон байх ёстой. Усан санд үлдэх усны урсацын хэмжээ нь (ялангуяа Хар ус нуурын цутгал дээр болон Ховд голын ай сав дахь ургамал, амьтны аймаг) байгаль орчны асуудал зэргийг шийдвэрлэх усаар хангахад хүрэлцэхүйц байх ёстой. Тиймээс экологийн боломжит динамик урсацыг тогтоосон байх хэрэгтэй.

УЦС-ын үйл ажиллагаа явагдаж байх үеийн голын байгалийн урсацын өөрчлөлтийн нөлөөллийг тодорхойлно. УЦС-ын үйл ажиллагаа горимдоо байхад боомтын илүүдэл ус халиагуураар голын доод урсацыг их, бага түвшинд шилжүүлэх нь голын байгалийн урсацад ямар өөрчлөлт үзүүлэхийг тогтооно. Ийнхүү зохиомлоор голын урсацыг өөрчлөх нь боомтын доод хашицын урсацын экосистемд нөлөөлж болох юм.

Хариус, Алтайн сугас зэрэг загас, усны бусад төрөл зүйл амьтдын хувьд боомт нь давашгүй саад болох тул Ховд голын дээд, доод хашицын урсацын дагуух загасны нүүдлийн замд учирах аливаа саад тотгорыг тогтооно. Тиймээс загас өнгөрүүлэх байгууламж, үржүүлэх цөөрөм, эсвэл усан санд загас үржүүлэх аж ахуй эрхлэх зэргээр мэдэгдэж буй арга хэрэгслээр нөлөөллийг бууруулах арга хэмжээг судална.

Үерийн усанд автаж болзошгүй боомтын хэсгийг тодорхойлж тухайн хэсгийн барилгын ажлын зам, боомтын талбай, дэд бүтэцтэй хэрхэн холбогдохыг тогтооно. Орон нутгийн иргэдийн загасчлалын бүсийг тодорхойлон загасны тоо толгойд нөлөөлөх нөлөөлөл болон түүнийг бууруулах оновчтой арга замыг онцлон авч үзнэ.

Үерээс болж боомтод болон боомтоос доошхи хэсгүүдэд учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодорхойлно.

#### **4.2.4 Голыг зайлуулан урсгах үеийн төслийн тооцоо зарцуулга**

УЦС-ын боомтыг барих үед голыг зайлуулан урсгах ажилд тооцсон төслийн тооцоот үерийн хэмжээ нь төслийн үзүүлэлтүүд, барилгын ажлын дэс дараалал, төслийн талбарын улирлын ус зүйн болон ус цаг уурын үзүүлэлтүүдээс шууд хамаарна. Урсацын дийлэнхи хэсэг хуримтлагддаг хавар болон зуны сард үерийн хэмжээг тооцож байх нь барилгын ажлын үед үүсэж болзошгүй эрсдлийг тооцоход чухал байдаг.

Ус цаг уурын харуулуудын судалгаагаар шар усны үерийн ажиглагдсан хамгийн их хэмжээ ус судлалын Ховд-Өлгий харуулд 1966 онд 841 м<sup>3</sup>/с, Ховд-Баянуур харуулд 500 м<sup>3</sup>/с (1984), Ховд-Мянгад харуулд 726 м<sup>3</sup>/с 1969 онд хүрсэн байна. Ажиглагдсан хур борооны үерийн хамгийн их хэмжээ Ховд-Өлгий харуулд мөн 1966 онд 480 м<sup>3</sup>/с, Ховд-

Баяннуур харуулд 391 м<sup>3</sup>/с (1988), Ховд-Мянгад харуулд 649 м<sup>3</sup>/с 1969 онд хүрсэн байна.

Шар усны үерийн урсацын зузаан өндөр уулын бүс, бүслүүрт 100 мм, түүнээс доош томоохон голуудын дагууд 80-4 мм хүрч буурна 100 жилд нэг удаа тохиох магадлалтай шар усны үер 840-1010 м<sup>3</sup>/с хүрэх бол хур борооны үерийнх 535-850 м<sup>3</sup>/с байна.

#### **4.2.5 Ашиглалтын үед өвлийн улиралд үүсэх мөсний үзэгдлийн талаар**

Өвлийн улиралд Ховд гол нь хөлдөж мөсөн бүрхүүлтэй байдаг тул боомтоос дооших хэсгийн мөсний үзэгдэлийг судалгааны хүрээнд онцгойлон авч үзэх хэрэгтэй. Энэ нь байгаль орчны хамгаалалтын асуудлаас гадна усан цахилгаан станцаас дооших хэсэгт амьдардаг хүмүүс болон суурингуудын аюулгүй байдалтай холбоотой төдийгүй мөн усан цахилгаан станцын найдвартай ажиллагааны байдалд хамаарах асуудал юм. Иймд энэ асуудлыг маш ул суурьтай судалж үзэх шаардлагатай. Нөлөөллийн үнэлгээг хийхдээ доорхи асуудлуудыг зайлшгүй судална:

Өвлийн улиралд усан сангаас гарсан ус боомтоос доош хэр хол үргэлжлэхийг тодорхойлоно.

Голд мөс үүсч түгжрэл үүсэх эрсдлийг тодорхойлно. Ийнхүү үүссэн мөсөн түгжрэл нь голын усыг боож түвшнийг нь өргөснөөс станцын ажиллагаанд үзүүлэх сөрөг нөлөө, эрсдлийг тогтооно. Мөн ийм мөсөн түгжрэл задарснаас боомтоос дооших хэсэгт үзүүлэх эрсдэлийг судална.

Турбины ажиллагаанаас үүсэх цохилтын долгионы нөлөөлөл (мөс өргөгдөх, мөсийг эвдэлж хагалан доош урсгах, бүлээн урсгал мөсөн доогуур урсах зэрэг)-ийг судална.

УЦС-ийн өвлийн улиралд оргил ачааллын үеийн байгаль орчинд үзүүлэх нөлөөлийг судална.

#### **4.2.6 Усны болон дэд бүтцийн барилга байгууламжийн нөлөөлөл**

УЦС-ын боомт барих газар нь зөвхөн боомт байрлах хэсэг газар биш бөгөөд харин боомтын барилгын ажил явагдах томоохон талбайг хамаарна. Барилгын ажлын явцад энэ газарт хэд хэдэн түр байгууламжийг барьж байгуулах ба тэнд барилгын ажилд хэрэглэх байгууламж, тоног төхөөрөмжүүд байрлана. Барилгын ажлын үе шатанд боомт барих газар нь Байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд авч үзэх чухал хэсэг байна. Үүнд боомт барих газарт хамаарах Ховд голын эргийн хоёр тал болон барилгын ажлын явцад ашиглах бүх түр байгууламж барих газарт багтана. Станцын барилга болон хуваарилах байгууламжийг байрлуулах газар мөн багтана.

УЦС-ыг байгуулснаар боомтоос доош байрлах Ховд голын зарцуулга өөрчлөгдөнө. Энэ нь тухайн нутагт оршин суудаг ард иргэд болон байгаль орчны хэд хэдэн үзүүлэлтэд нөлөөлнө.

Боомтоос доошхи Ховд голын усны чанар, горимын өөрчлөлтийг голын сав газар, Хар ус нуурт нөлөөлөх аливаа нөлөөллийг үнэлнэ-

Цаашид Ховд голын усны хүчилтөрөгчийн агууламжийн усан сангийн мөсөн бүрхүүлтэй ба мөсөн бүрхүүлгүй байх үеийн төлөвийг тодорхойлно. Хүчилтөрөгчийн агууламж хэмжээ нь өвлийн сүүл үед загасны популяцид үзүүлэх нөлөөллийн талаар шинжилгээ хийнэ.

Боомт, усан сан, ус авах барилга, УЦС зэрэг усны барилга байгууламжууд, ус дамжуулах хоолой, насос станц, авто зам, цахилгаан дамжуулах шугам зэрэг дэд бүтцийн инженерийн барилга байгууламжийг барих үеийн болон ашиглалтын үеийн байгаль орчны нөлөөллүүдийг тооцон үзэж сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээг төлөвлөнө. Үүнд:

- Усан сан бий болсноор гарах боломжит эерэг, сөрөг нөлөөг үнэлэх, (усан тээвэр, амралт, аялал жуулчлал, загасны аж ахуй, усан спорт, загас агнуур)
  - Байгалийн үзэсгэлэнт газар нутаг, тусгай болон орон нутгийн хамгаалалттай нутагт хэрхэн нөлөөлж болохыг авч үзэх.
  - Барилга байгууламжид өртөгдөж болох талбайн гидрогеологийн нөхцөл, газрын доорх усны чанар, горимд орж болох өөрчлөлтийн нөлөөлөл,
  - Геологи, газар хөдлөлтийн эрсдлийн үнэлгээ хийж, геологийн онцгой бүсийг зурагт тэмдэглэн үзүүлэх,
  - Усны барилга байгууламж, ажилчдын суурин болон цахилгаан хангамжийн шугам, тоноглолуудыг барьж байгуулах, ашиглах үеэр экосистемд үзүүлэх нөлөөг тогтоох,
  - Орон нутгаас их хэмжээний барилгын материал олборлох, үйлдвэрлэх, зөөх нөлөөллийг тодруулах,
  - Цахилгаан цугам трассыг сонгохдоо байгалийн үзэсгэлэнт газар, аялал жуулчлал, соёлын үнэт зүйлийг хамгаалах хувилбарыг сонгох,
  - Цахилгаан дамжуулах шугамыг барих, ашиглах явцад түүний трассын дагуу биологийн төрөл зүйл, хэвийн орчинд нөлөөлөх эрсдлийг тогтоох
  - Трассын дагуу ургамлын нөмрөгийг хамгаалах, нөхөн сэргээх хугацааг сайжруулах талаар арга хэмжээ авч, трассын огтлолцолыг хуурай байлгах, үерээс хамгаалах арга хэмжээ авах,
- Барилгын болон үйл ажиллагааны явцын хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулах.

#### **4.2.7 Газар ашиглалт**

УЦС нь урт хугацаандаа эдэлбэр газрын ашиглалтанд нөлөөлдөг. Усан сангийн хүчин чадал болон усан сангийн хэмжээнээс хамаарч их хэмжээний газар нутаг усанд автдаг бөгөөд энэхүү үйл явц нь бүс нутгийн өнөөгийн газар ашиглалтын хэлбэрийг өөрчилж байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон нийгмийн олон асуудалд шууд болон шууд бусаар нөлөөлдөг. Ялангуяа, УЦС-ын урсацын тохируулгаас (усны түвшингийн өөрчлөлт) хамаарч усан сангийн дээд болон доод голын татам нугын экосистемд нөлөөлдөг.

Татмын бүсэд томоохон хэмжээний талбай усанд автах, голын эх ба адгийн усны түвшин ба урсац өөрчлөгдөх, бүтээн байгуулалт, хөгжлийн үйл ажиллагаатай холбоотой

усны урсацад тохируулга хийх, томоохон хэмжээний усан сан байгуулах зэрэг ажлын үр дүнд газар ашиглалтад өөрчлөлт гардаг. Өвлийн улиралд үүсэх гол мөрний мөсөн бүрхүүлийн өөрчлөлтийг тооцоолох шаардлагатай. Энэ чиглэлээр Үнэлгээг хийж гүйцэтгэх компани дараах ажлуудыг гүйцэтгэнэ:

- Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, ялангуяа төслийн нөлөөлөлд өртөх газар нутгийн өнөөгийн газрын зохион байгуулалт болон ашиглалтын төрлийг нарийвчлан тодорхойлох, зураглалыг зохих масштабаар гарган хавсаргана.

- Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь улсын эсвэл орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт орших тохиолдолд тус нутаг дэвсгэрийн үнэлгээг хийж, хамгааллын горим, байршилын талаарх мэдээлэл, зураглалыг гарган хавсаргана.

- төслийн барилгын бүтээн байгуулалтын үе шатанд өртөх газар нутгийн хэмжээг тодорхойлох, зураглалыг зохих масштабаар гарган хавсаргана.

- орон нутгийн хөгжлийн чиг хандлагыг судлах, УЦС баригдсаны дараах газар ашиглалтын өөрчлөлтийг өнөөгийн нөхцөл байдалтай харьцуулах, нүүлгэн шилжүүлэлт хийх шаардлагатай объектыг тодорхойлох, зураглалыг зохих масштабаар гарган хавсаргана.

- төслийн нөлөөлөлд өртөж байгаа сум тус бүрээр эдэлбэр газрын ашиглалтын хэтийн төлөвлөлийг гаргаж, шаардлагатай тохиолдолд өнөөгийн газар зохион байгуулалтын төлөвлөлтөнд өөрчлөлт оруулах талаар санал, зөвлөмж боловсруулсан байна.

#### **4.2.8 Археологи, түүх соёлын дурсгалт зүйлс**

Өнөөгийн байдлаар төслийн нутаг дэвсгэрт археологи, түүх соёлын дурсгалт зүйлс хараахан илрээгүй байна<sup>3</sup>. Гэхдээ соёлын өвийг хамгаалах арга хэмжээг Монгол Улсын холбогдох хууль, журмын дагуу төлөвлөх шаардлагатай.

Төлөвлөж байгаа усан сан, гидротехникийн барилга байгууламж, замын болон эрчим хүч дамжуулах трассын дагууд археологийн нарийвчилсан хайгуул судалгааг явуулна. Төслийн бүс нутагт соёлын өвийн менежментийн төлөвлөгөөг Монгол Улсын холбогдох хууль, журмын дагуу боловсруулан гаргана.

#### **4.2.9 Нүүлгэн шилжүүлэлт**

Үнэлгээг хийж гүйцэтгэх компани баг анхан шатны судалгааны тайлан, зөвлөмж, ТЭЗҮ, байгууламжийн зураг төсөлд үндэслэн хүн амын нүүлгэн шилжүүлэх хэрэгцээ шаардлагыг судалж, төсөлд шаардлагатай газрын талбайн хэмжээ, газар ашиглалтын хэрэгцээ, төслийн бүтээн байгуулалт ба үйл ажиллагааны явцад хийгдэх эдийн засгийн ба шилжүүлэлтийн нөлөөллийг тодорхойлно.

БОННУ-ний ажлын хүрээнд санхүүжилтийн эх үүсвэрийг үл харгалзан төслийн бүтээн байгуулалт, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахад шаардлагатай байнгын ба богино хугацааны газар ашиглалт, худалдан авалтын хэрэгцээг тодорхойлно. Энэхүү ажлыг хийхэд авто зам, үндсэн зам, богино хугацаанд ашиглах зам, голын хоёр талыг холбосон зам, түр хадгалах газар, ажилчдын суурин, дамжуулах шугам, хоолой зэргийг

харгалзана. Мөн БОННУ-ний ажлын хүрээнд төслийн хэрэгжүүлсний улмаас алдагдах газар, үл хөдлөх хөрөнгийн цар хэмжээ, онцлогийг үнэлж, газар болон аливаа нөөцөд хүрэх замыг хязгаарлах эсэхийг тодорхойлж, төслийн нөлөөнд өртсөн иргэдийг нүүлгэн шилжүүлэх, тэдгээрийн эдийн засгийн асуудлыг шийдвэрлэх шаардлагыг нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөнд тусгана.

Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөг боловсруулахдаа нөлөөлөлд өртөх иргэдийн 100 хувийн тооллого, тэдгээрийн эд хөрөнгийн судалгааг хийж, суурь үндсэн нөхцлийн нийгэм-эдийн засгийн судалгаа хийж, нөлөөлөлд өртөх бүх хүмүүс (тэдний эзэмшлийн статусыг үл харгалзан)-г үзүүлэх аливаа нөлөөллийн матриц боловсруулж, байгууллага, иргэдийн эд хөрөнгө, газар (хувийн ба түрээсийн аль алины)-ыг нөхөн төлөх зардлыг тооцоолж, эдгээрийн эд хөрөнгийг буулгах, нүүлгэн шилжүүлэх, нөхөн сэргээх хувилбарыг тодорхойлно.

Нүүлгэн шилжүүлэлтэнд хамрагдах хүмүүстэй хэлэлцүүлэг зохион байгуулж, тэдгээрт нүүлгэн шилжүүлэлтийн хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх үйл явцад оролцох боломж олгоно. Үнэлгээг хийж гүйцэтгэх компани баг нь нөлөөлөлд өртөх иргэд, оршин суугчидтай санал солилцож, нүүлгэн шилжүүлэх ажлын хувилбарт тэдний санал дүгнэлтийг тусгана.

Үнэлгээг хийж гүйцэтгэх компани нь Монгол Улсын холбогдох хууль, журамд тавигдсан шаардлагын дагуу нүүлгэн шилжүүлэлтэнд хамрагдах зорилтот бүлгийн нийгэм, соёлын онцлог шинжийг судалж, тэдний амьжиргааны өнөөгийн эх үүсвэрийг тодорхойлж, албадан нүүлгэн шилжүүлэлтийг боломжит түвшин хүртэл бууруулахыг эрмэлзэнэ.

Нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой гарах зардал, нөхөн төлбөрийг Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан байна.

#### **4.2.10 Уугуул иргэд**

Үнэлгээг хийж гүйцэтгэх компани нь төслийн нутаг дэвсгэрийн уугуул иргэдийн нийгмийн нөлөөлөлтэй холбоотой асуудлыг судлана. Ингэхдээ төслийн газар нутагт уугуул иргэдтэй холбоотой хүчин зүйлийг судалж, эерэг ба сөрөг нөлөөллийн талаар хэлэлцүүлэг хийнэ.

Үнэлгээг хийж гүйцэтгэх компани нь уугуул иргэдэд төслөөс үзүүлэх эерэг ба сөрөг нөлөөллийн нийгмийн судалгаа хийнэ. Сөрөг нөлөө нь ноцтой тохиолдолд төслийн хувилбаруудыг дахин хянаж, шинээр боловсруулна. Нийгмийн үнэлгээний ажлын хүрээнд төслийн үйл ажиллагаанд өртөх уугуул иргэдийн нийгэм, соёл, эмзэг байдлыг судлана. Үүнд:

- Уугуул иргэдтэй холбоотой онцлогийг соёлын өвөөр нь тодорхойлж, өмнө хийгдсэн судалгаа, үнэлгээний материалыг судалж үзнэ.
- Уугуул иргэдийн үе дамжин амьдарч суурьшсан нутаг дэвсгэрт орших оюуны ач холбогдолтой, тахилгатай, байгалийн газруудыг тодорхойлно.

Үнэлгээг хийж гүйцэтгэх компани баг нь хүн ам зүй, нийгмийн, соёлын, ба улс төрийн индикаторууд, өвлөж ирсэн газар нутаг, амьдралын хэв маяг, эсвэл байгалийн нөөц хүртэх боломж хамгийн чухал индикаторуудыг тодорхойлно.

Нийгмийн энэ үнэлгээг боловсруулсны дараа төслөөс нутгийн уугуул иргэдэд үзүүлэх сөрөг ба эерэг нөлөөллийг үнэлж, эдгээр нөлөөллийг зохицуулах төлөвлөгөөг нутгийн иргэд, орон нутгийн засаг захиргааны байгууллагууд, нийгмийн манлайлагч нарт ил тод байдлаар танилцуулж тэдгээртэй хэлэлцүүлэг хийнэ. Үнэлгээг хийж гүйцэтгэх компани нь энэ хэлэлцүүлгийн үйл явцын талаарх дэлгэрэнгүй тэмдэглэлийг хөтлөнө.

#### **4.2.11 Олон нийтийн харилцаа**

Төслийн оролцогч гол талуудтай төслийн хувилбаруудыг хэлэлцэх замаар олон нийтийн харилцааг хангана. Үнэлгээг хийж гүйцэтгэх компани нь албан ёсны вэб хуудас нээж олон нийттэй зөвшилцөх, харилцан ярилцах, тэдгээрийг үйл ажиллагаанд оролцуулах, боломжийг олгоно.

### **5. Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө**

Үнэлгээг хийж гүйцэтгэх компани Монгол Улсын холбогдох хууль, журмын дагуу төслийн хэрэгжилт, үйл ажиллагааны явцад байгаль орчин, нийгмийн нөлөөлөл, эрсдлээс зайлсхийх, нөлөөллөөс урьдчилан сэргийлэх боломжгүй тохиолдолд тэдгээрийг бууруулах, багасгах болон хяналт шинжилгээ явуулах Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг (БОМТ) боловсруулна.

Зардлын тооцоонд нүүлгэн шилжүүлэлтийн тооцоо, соёлын өвийг хамгаалах, уугуул иргэдийн амьдралын нөхцлийг бууруулахаас сэргийлэх, ан амьтдыг хамгаалахтай холбоотой зардлыг оруулсан байх шаардлагатай. Үнэлгээг хийж гүйцэтгэх компани нь урт хугацааны хяналт шинжилгээний төлөвлөгөө, холбогдол зардлын тооцоолол, арга зүйг боловсруулж, зөрчлийн торгуулийн талаар энэхүү төлөвлөгөөнд тусгасан байна.

Энэ ажлын даалгаврын гол зорилго нь төслийн бүтээн байгуулалтын үед тавигдах байгаль орчин, нийгмийн шаардлагыг тодорхойлж, гарч болзошгүй аливаа байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөллийг бууруулах, шаардлагатай менежментийн төлөвлөгөөг боловсруулж, тэдгээрийн хэрэгжилтийн хүрээг тодорхойлоход оршино.

Тус төлөвлөгөөнд Эрдэнэбүрэнгийн УЦС-ын боомт, дэд станц, ЦДАШ, эдгээрийн барилгын ажилтай холбоотой бүх стандартыг тусгана. Мөн ажилчдын амьдрах байрны менежмент, мөрдөх сахилга батын журмын талаар тусгана.

Үнэлгээг хийж гүйцэтгэх компани нь төлөвлөгөөнд дараах бүрэлдэхүүн хэсгүүдийг тусгасан байна. Үүнд:

1. Соёлын биет нөөц (төслийн явцад илрүүлсэн олдвортой холбоотой журам)-ийн менежментийн төлөвлөгөө;
2. Газрын эзэмшил, нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө;
3. Түр хугацаагаар нөлөөлөлд өртсөн ба карьерт ашигласан газруудын нөхөн сэргээлтийн төлөвлөгөө;



4. Байгалийн амьдрах орчны менежментийн төлөвлөгөө;
5. Барилга байгууламж ба үйл ажиллагааны явцад ажилчид, олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөө;
6. Олон нийтийн харилцааны хөтөлбөр;
7. Замын хөдөлгөөн, тээвэрлэлтийн төлөвлөгөө;
8. Бүтээн байгуулалт, үйл ажиллагааны явцад үүсэх тоосжилт, дуу чимээг бууруулах, хяналт тавих ажлын төлөвлөгөө;
9. Барилгын ажлын талбайг гадны нөлөөнөөс хамгаалах, ажилчдын суурин/кэмпийн менежментийн төлөвлөгөө;
10. Уугуул иргэдийн хөгжлийн төлөвлөгөө;
11. Барилгын ажлын явцад гарах хатуу хог хаягдлыг зайлуулах, нөлөөллийг бууруулах төлөвлөгөө;
12. Боомт, усан сангийн аюулгүй ажиллагааны төлөвлөгөө;
13. Боомтоос доош (Хар ус нуур хүртэл) татмын экосистемийг хамгаалахад чухал үүрэгтэй байгалийн урсацыг хамгийн бага боломжит түвшинд байлгах 3-аас доошгүй хувилбарыг үнэлэх;
14. Урт хугацааны хяналт, шинжилгээний төлөвлөгөө;
15. Болзошгүй эрсдлийн төлөвлөгөө;
16. БОМТ–г хэрэгжүүлэгч байгууллага, оролцогч талуудын гүйцэтгэх үүрэг, хариуцлага, тэдний чадавхийн үнэлгээг;
17. БОМТ–г хэрэгжүүлэх зөвлөмж;

Нөлөөллийг бууруулах төлөвлөгөөг барилгын болон ашиглалтын үе шатуудад зориулж хоёр тусдаа боловсруулна. Үнэлгээг хийж гүйцэтгэх компани нь эрсдэл, нөлөөллийг бууруулах оролцогч байгууллага, этгээдийг тогтооно. Нөлөөллийн хяналтыг долоо хоног, сар, жилээр төлөвлөж хэрэгжүүлнэ.

### **5.1 Хяналт шинжилгээний хөтөлбөр**

Хяналт шинжилгээний хөтөлбөрийг 10 жилээс доошгүй хугацаагаар нарийвчлан боловсруулна. Энэ хөтөлбөрт хийх ажлын жагсаалтыг тусгаж, хяналт шинжилгээний индикаторыг тодорхойлсон байна.

### **5.2 Олон нийтийн хэлэлцүүлэг**

Төслийн ТЭЗҮ, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний баримт бичгийг олон нийтээр хэлэлцүүлэх ажлыг Монгол Улсын холбогдох хууль, журмын дагуу олон нийттэй хэлэлцэх, мэдээллийг ил тод болгох тухай бодлогын удирдамж болон дэд бүтцийн томоохон төслүүдийн асуудлаар олон улсын практикт нийтлэг хэрэглэдэг үйл ажиллагааны дагуу явуулна. Олон нийттэй хэлэлцэх нь төслийн нөлөөллийн үнэлгээ, нөлөөлөл бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг илүү үндэслэлтэй болгож, төслийг өртөг хэмнэлттэй, цаг хугацаанд боловсруулж, хэрэгжүүлэхэд чухал туслах механизм болдог.

Орон нутгийн засаг захиргааны байгууллага, байгаль орчны менежмент, ТХГН-ийн асуудал хариуцдаг байгууллагуудын төлөөлөлтэй бүлгээр уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулна.

Олон нийтийн хэлэлцүүлэг, мэдээлэл харилцааны хөтөлбөрийг БОННУ-ний үеэс эхлүүлэн цаашид төслийн хэрэгжилтийн явцад ялангуяа гол томоохон бүтээн байгуулалтын үйл ажиллагааны явцад үргэлжлүүлнэ.

Үнэлгээг хийж гүйцэтгэх компани баг олон нийтэд мэдээлэл хүргэх, санал дүгнэлтийг нь авах, тэдэнд мэдээлэл авах хүсэлтээ илгээх боломж олгосон албан ёсны цахим хуудас ажиллуулна. Энэ цахим хуудаст төслийн ТЭЗҮ, БОТБС , БОННУ-ний тайланг байршуулсан байна. Төсөл батлах болон төслийн бүтээн байгуулалтын ажил эхлэхийн өмнө орон нутгийн иргэд, оршин суугчдыг мэдээллээр хангахад онцгой анхаарал хандуулна.

## **6. Ажлын тайланг хүргүүлэх**

### **6.1 Тайлан хүргүүлэх шаардлага**

Эрх бүхий аж ахуйн нэгж нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнгийн тайлан болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулна.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд дараах асуудлыг тусгана:

- Төсөл хэрэгжих орчны байгаль орчны төлөв байдал
- Төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл, тэдгээрийн эрчим, тархалт, үр дагаврыг тогтоосон тооцоо, судалгааны үр дүн;
- Төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж;
- Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсгэж болзошгүй бохирдлыг бууруулахад боломжит арга технологийг ашиглах зөвлөмж;
- Төслийн үйл ажиллагаанаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн эрсдэлийн үнэлгээ;
- Байгаль орчны мезежментийн төлөвлөгөөний зорилт, хамран хүрээ, шалгуур үзүүлэлтүүд;
- Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн нийтийн хурлын санал, тэмдэглэл;
- Төсөл хэрэгжих газрын түүх соёлын үнэт зүйлс, төслийн онцлогтой уялдсан бусад асуудал зэрэг.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд төсөл хэрэгжүүлэгчээс албан ёсоор санал авсан байх шаардлагатай.

### **6.2 Ажлын тайлан**

Үнэлгээг хийж гүйцэтгэх компани нь ажлын даалгаврын дагуу боловсруулсан аливаа бичиг баримтыг Захиалагчид хүлээлгэн өгнө. Үнэлгээг хийж гүйцэтгэх компани нь асуудлыг цаг тухайд нь шийдвэрлэх үүднээс төслийн хэрэгжилтийн явцын сар бүрийн тайланг бичгээр ирүүлнэ. Эхлэлийн тайлан, сарын ажлын явцын тайлан болон бусад бүх

тайланг **Монгол, Англи хэл** дээр бэлтгэсэн байх ёстой. Эхлэлийн тайланд ажлын төлөвлөгөө, хуваарийг тодорхой тусгасан байна.

Тусгай ба ерөнхий төсөл болон эцсийн тайланг Монгол, Англи хэл дээр бэлтгэнэ. Эцсийн тайлангийн төслийг захиалагчид буюу Эрчим хүчний яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Эрдэнбүрэнгийн УЦС-ын ТХН болон олон нийтийн төлөөлөгчдөд хүргүүлэн санал авна.

Бүх тайлангуудыг гэрээнд заасан тоо хэмжээгээр Монгол, Англи хэл дээр хэвлэн бэлтгэж цахим хэлбэрээр тус тус ирүүлнэ.

Үнэлгээг хийж гүйцэтгэх компани нь БОННУ, БОТБС-ны судалгаанд хавсрагдах газрын зургийн жагсаалтыг гаргана. Доор дурдсан бүх тайланг **Монгол, Англи хэл** дээр гаргаж хуваарийн дагуу ТХН-ээр дамжуулан Захиалагчид хүргүүлнэ.

### **6.2.1 Эхлэлийн тайлан**

Энэ тайланд төлөвлөгөөний дагуу нийт эцсийн бүтээгдэхүүний талаар нэгдсэн тайлбар (хийгдэх холбогдох ажлын төлөвлөгөөний талаарх тайлбарын хамт) өгсөн байх бөгөөд тайланг гэрээ байгуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор ТХН-д ирүүлнэ.

### **6.2.2 Ажлын хөтөлбөрийн санал**

Санал болгож буй ажлын хөтөлбөрийг гэрээ байгуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Захиалагчид ирүүлнэ.

### **6.2.3 Явцын тайлан**

Гэрээнд гарын үсэг зурсны дараа сар бүр ТХН-д явцын тайланг ирүүлнэ. Явцын тайланд гэрээнд заасан ажлын даалгаврын биелэлтийн гүйцэтгэл, учирч буй хүндрэл, зорилгыг биелүүлэхийн тулд авч хэрэгжүүлэх боломжит өөр арга замын талаар оруулна.

### **6.2.4 БОННУ-ний тайлангийн төсөл**

Байгаль орчин, нийгмийн үнэлгээний тайланг хавсралтад заасан хугацаанд багтаан хүлээлгэн өгнө. Энэхүү тайлангийн зорилго нь гол асуудлуудыг танилцуулах, холбоотой мэдээлэл, баримт мэдээлэл цуглуулахад оршино.

Тайлан нь байгаль орчин, нийгмийн асуудлыг хураангуйлсан байх бөгөөд Байгаль орчин, нийгмийн үнэлгээний эцсийн тайлангийн бүтцийн талаар нарийвчлан тодорхойлж оруулсан байна. Энд Аюулгүй ажиллагааны тусгай бодлогын шаардлагыг хангасан тухай тайлангуудын төслийг хавсаргана.

### **6.2.5 БОННУ-ний эцэслэсэн тайлан**

Байгаль орчин, нийгмийн үнэлгээний эцсийн тайланг хавсралтад заасан хугацаанд багтаан хүлээлгэн өгнө. Тайланд хийгдсэн бүх ажлыг нарийвчлан оруулж дүн шинжилгээ өгнө. Өмнө хийсэн тайлан болон Захиалагч, бусад талуудаас авсан саналыг тусгах бөгөөд бичгээр өгсөн саналаас гадна семинар, хяналтын уулзалтууд дээр яригдаж хэлэлцсэн асуудлыг мөн хамруулна.

Байгаль орчин, нийгмийн үнэлгээний эцсийн тайланг төсөл хэрэгжүүлэх нэгжид хүлээлгэж өгөх ба энэхүү ажлын удирдамжийн шаардлагын дагуу Аюулгүй ажиллагааны

бодлогын шаардлагыг хангасан тухай дагалдах тайлангуудыг хамруулах ба Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, Соёлын биет өмчийн менежментийн төлөвлөгөө, Нүүлгэн шилжүүлэлтийн бодлогын хамрах хүрээ, Нүүлгэн шилжүүлэх ажлын төлөвлөгөөг хамруулна.

#### **6.2.6 Төр олон нийтгэй, зөвшилцөх, харилцан ажлын тайлан**

Энэ тайланг доор заасан хуваарийн дагуу төсөл хэрэгжүүлэх нэгжид танилцуулна. ТХН-ийн ТУХ нь тайланг хянаж, хурлын тэмдэглэлд гол саналуудыг тусган баримтжуулсан байна.

Харилцах, зөвшилцөх хөтөлбөрийн тайланг төсөл хэрэгжүүлэх нэгжид хүлээлгэж өгөх ба баримт мэдээллүүдийн электрон хувь, уулзалтуудын тэмдэглэлүүдийг оруулна.

#### **7. Үнэлгээг хийж гүйцэтгэх компанийн ажлын хуваарь**

Үнэлгээг хийж гүйцэтгэх компанийн ажлыг Захиалагч нь ТХН-ээр дамжуулан хянах ба Засгийн Газрын бусад яам, агентлаг болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах болно. Энэхүү хамтын ажиллагаа нь эрдэм шинжилгээний байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд болон төрийн бус байгууллагууд хоорондын харилцаа, уялдаа холбоог хангах болно.

Дээр дурдсан тайланг боловсруулахад шаардлагатай үйл ажиллагааны хуваарийг дараах хүснэгтэд харуулав. Үнэлгээг хийж гүйцэтгэх компани нь гэрээнд гарын үсэг зурснаар үүрэгт ажлаа эхлүүлнэ. Үнэлгээг хийж гүйцэтгэх компанид нь ажлын нарийвчилсан төлөвлөгөө болон хуваарийг гаргаж, ТУН болон хөндлөнгийн хяналтын багт танилцуулан баталгаажуулна.

#### **7.1 Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын үе шатуудын**

##### **төлөвлөгөө**

<b>Д.д</b>	<b>Зорилт</b>	<b>Сар</b>
1	БОННУ-ний ажлын хөтөлбөрийг хүлээлгэж өгөх	0.5
2	БОННУ-ний тайлангийн бүтцийг дагалдах тайлангуудын хамт хүлээлгэж өгөх (явцын тайлан)	2
3	БОННУ-ний тайлангийн төслийг хүлээлгэж өгөх	3
4	Төр, олон нийтгэй зөвшилцөх, харилцан ажлын тайланг хүлээлгэж өгөх	3
5	Байгаль орчин нийгмийн үнэлгээний эцсийн тайланг хүлээлгэн өгөх	4

## **7.2 Мэдээлэл, баримт бичгийн хяналт, өмчлөл**

Үнэлгээг хийж гүйцэтгэх компанид хүргүүлсэн бүхий л мэдээ, мэдээлэл, оюуны өмчийн эрх, өмчлөл, тусгай зөвшөөрөл зэрэг нь зөвхөн тус төслийн хүрээнд хийгдэх судалгаа, үнэлгээний ажилд ашиглагдана.

Үнэлгээг хийж гүйцэтгэх компанид хүргүүлсэн бичиг баримт болон мэдээ/мэдээллийг ТХН-ийн бичгээр илэрхийлсэн зөвшөөрөлгүйгээр задруулж болохгүй.

## **7.3 Үнэлгээг хийж гүйцэтгэх компанид тавигдах шаардлага**

Үнэлгээг хийж гүйцэтгэх компани болон түншлэл нь нь олон улсын хэмжээнд төслийн хамрах хүрээ болон тулгарч буй бэрхшээл ижил төстэй төсөл хэрэгжүүлсэн туршлагатай байна. Үнэлгээг хийж гүйцэтгэх компани нь өөрийн чадварыг нэмэгдүүлэх зорилгоор хамтарсан болон туслан гүйцэтгэгчтэй байж болно.

## **7.4 Үнэлгээг хийж гүйцэтгэх компанийн бүрэлдэхүүн**

Дараах шалгууруудыг хангасан, төлөвлөсөн хугацаанд ажиллах боломжтой багийн мэргэжилтнүүд БОННУ-г гүйцэтгэхэд оролцоно.

### **Байгаль орчин, нийгмийн үнэлгээний багийн ахлагч**

- Багийн ахлагч байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ болон байгалийн нөөцийн ашиглалтын төлөвлөлт, усны менежмент, газар төлөвлөлтийн төслүүдэд 15-аас доошгүй жил ажилласан туршлагатай, стратегийн болон салбарын байгаль орчны нөлөөллийн үнэлгээний чиглэлээр ажилласан туршлагатай байх, усан цахилгаан, эрчим хүчний төслүүдэд ажиллаж байсан туршлагатай бол давуу тал болно.
- Олон улсын стандартаар хийгдсэн байгаль орчны нөлөөллийн янз бүрийн шатны үнэлгээний ажилд оролцсон туршлагатай байх,
- Ижил төстэй төсөлд болон Засгийн газар, иргэний нийгэм, олон нийттэй ажилласан туршлагатай байх,
- Олон улсын шаардлагын дагуу судалгаа шинжилгээ хийж байсан туршлагатай байх,
- Янз бүрийн холбогдох талуудыг оролцуулсан олон чиглэлийн төслийн үйл ажиллагааг үр дүнтэй зохицуулах чадвартай нь батлагдсан байх,
- Төслийн ажилтнуудад зөвөлгөө өгөх чадвартай байх,
- Байгаль орчны менежмент, нөлөөллийн үнэлгээ, орчны төлөвлөлт мэргэжлийн чиглэлээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй байх,
- Зохион байгуулах, түргэн хугацаанд даалгаврыг биелүүлэх, болон, цагийн ачаалал даан ажиллах чадвартай,
- Төслийн ажлын үр дүн, үр ашгийг дээшлүүлэх талаар идэвхи санаачлага сайтай,
- Хувийн зохион байгуулалт болон багаар ажиллах ур чадвар сайтай байх
- Англи хэлний аман болон бичгийн өндөр чадвартай байх,
- Үнэлгээний хүрээнд компьютерийн хэрэглээний программууд дээр сайн ажилладаг.

### **Байгаль орчны үнэлгээний ахлах мэргэжилтэн**

- Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ, байгалийн нөөцийн ашиглалтын төлөвлөлт, усны менежмент болон газар төлөвлөлтийн зэрэг төслүүд дээр 15-аас доошгүй жил ажилласан туршлагатай, стратегийн болон салбарын байгаль орчны нөлөөллийн үнэлгээний ажил хийж байсан туршлагатай байх, усан цахилгаан, эрчим хүчний төслүүдэд ажиллаж байсан туршлагатай байх,
- Байгаль орчны менежмент, нөлөөллийн үнэлгээ, орчны төлөвлөлт зэрэг мэргэжлээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй байх,
- Олон улсын стандартаар хэрэгжүүлсэн байгаль орчны нөлөөллийн янз бүрийн шатны үнэлгээний ажилд 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх,
- Судалгаа шинжилгээ хийх, асуудлыг зөв шийдвэрлэх чадвартай байх
- Олон төрлийн мэдээллийг нэгтгэн дүгнэж, дүн шинжилгээ хийх чадвартай байх,
- Англи хэлний аман болон бичгийн өндөр чадвартай байх,
- Үнэлгээний хүрээнд компьютерийн хэрэглээний программууд дээр сайн ажилладаг

### **Загас судлаач**

- Загас судлаач мэргэжлээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй байх,
- Мэргэжлийн чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх,
- Олон улсын стандартаар хэрэгжүүлж байсан байгаль орчны нөлөөллийн янз бүрийн шатны үнэлгээний ажилд оролцсон туршлагатай байх,
- Ижил төстэй бүс нутагт биологийн төрөл зүйлийн судалгаа, усны амьтад, загасны судалгааны ажлын арвин туршлагатай байх,
- Мэдээллийг боловсруулах мэргэжлийн өндөр ур чадвартай, тооцооллын загварчлал дээр ажиллаж байсан туршлагатай байх,
- Төслийн ажлын үр дүн, үр ашгийг дээшлүүлэх талаар идэвхи санаачлага сайтай ажиллах,
- Хувийн зохион байгуулалт болон багаар ажиллах ур чадвар сайтай байх
- Англи хэлний аман болон бичгийн өндөр чадвартай байх,
- Үнэлгээний хүрээнд компьютерийн хэрэглээний программууд дээр сайн ажилладаг.

### **Цэвэр усны экологич/ лимнологич**

- Усны экологич мэргэжлээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй. Мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх
- Олон улсын стандартаар хэрэгжүүлж байсан байгаль орчны нөлөөллийн янз бүрийн шатны үнэлгээний ажилд оролцсон туршлагатай байх,
- Мэдээллийг боловсруулах мэргэжлийн өндөр ур чадвартай байх,
- Төслийн ажлын үр дүн, үр ашгийг дээшлүүлэх талаар идэвхи санаачлага сайтай ажиллах,
- Англи хэлний аман болон бичгийн өндөр чадвартай байх,
- Үнэлгээний хүрээнд компьютерийн хэрэглээний программууд дээр сайн ажилладаг.

### **Гидрологич**

- Гидрологич, ус зүйч мэргэжлээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй, Мэргэжлийн чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх,
- Монгол оронд хэрэгжсэн ижил төстэй төсөл дээр оролцон ажиллаж байсан туршлагатай байх,
- Мэдээллийг боловсруулах мэргэжлийн өндөр ур чадвартай, усзүйн загварчлал дээр ажиллаж байсан туршлагатай байх,
- Төслийн ажлын үр дүн, үр ашгийг дээшлүүлэх талаар идэвхи санаачлага сайтай ажиллах,
- Англи хэлний аман болон бичгийн өндөр чадвартай байх,
- Үнэлгээний хүрээнд компьютерийн хэрэглээний програмууд дээр сайн ажилладаг.

### **Цаг уурч**

- Цаг уурч мэргэжлийн магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх, мэргэжилээрээ 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх,
- Мэдээллийг боловсруулах мэргэжлийн програмуудыг эзэмшсэн, мэргэжлийн өндөр ур чадвартай байх,
- Уур амьсгалын өөрчлөлтийн ирээдүйн хандлагыг загварчлалын аргаар тооцон гаргаж байсан туршлагатай байх,
- Төслийн ажлын үр дүн, үр ашгийг дээшлүүлэх талаар идэвхи санаачлага сайтай ажиллах,
- Англи хэлний аман болон бичгийн өндөр чадвартай байх,
- Үнэлгээний хүрээнд компьютерийн хэрэглээний програмууд дээр сайн ажилладаг.

### **Гидрогеологич**

- Гидрогеологич мэргэжилээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй байх,
- Хуурай бүс нутаг, Монгол оронд эсвэл ижил төстэй бүс нутагт газрын доорх усны хайгуул судалгааны чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх, Монгол оронд хэрэгжсэн ижил төстэй төсөл дээр оролцон ажиллаж байсан туршлагатай бол давуу тал болно.
- Мэдээллийг боловсруулах мэргэжлийн өндөр ур чадвартай, тооцооллын загварчлал дээр ажиллаж байсан туршлагатай байх,
- Төслийн ажлын үр дүн, үр ашгийг дээшлүүлэх талаар идэвхи санаачлага сайтай ажиллах,
- Англи хэлний аман болон бичгийн өндөр чадвартай байх,
- Үнэлгээний хүрээнд компьютерийн хэрэглээний програмууд дээр сайн ажилладаг.

### **Геологийн инженер**

- Мэргэжилтэн нь геологийн инженер мэргэжилтэй байна.
- Геологийн ухааны магистр буюу түүнээс дээш зэрэгтэй байна.
- Хуурай бүс, Монгол Улс эсвэл ижил төстэй бүс нутагт хэрэгжиж байсан гидравликийн төслийн геологийн хайгуул, судалгааны чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх

- Мэргэжлийн ур чадвар хөгжүүлэх мэдлэгтэй, тооцооны загварчилал боловсруулж байсан туршлагатай
- Төслийн ажлын үр дүн, үр ашгийг дээшлүүлэх, талаар идэвхи санаачлага сайтай ажиллах
- Англи хэлний өндөр мэдлэгтэй
- Үнэлгээний хүрээнд хэрэглэх компьютерийн хэрэглээний програмууд дээр сайн ажилладаг.

#### **Экологич**

- Экологич мэргэжлээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй. Мэргэжлийн чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх
- Монгол оронд хэрэгжсэн ижил төстэй төслүүдэд оролцон ажиллаж байсан туршлагатай байх, Олон улсын стандартаар хэрэгжүүлж байсан байгаль орчны нөлөөллийн янз бүрийн шатны үнэлгээний ажилд оролцсон туршлагатай байх.
- Мэдээллийг боловсруулах мэргэжлийн өндөр ур чадвартай байх,
- Төслийн ажлын үр дүнг дээшлүүлэх талаар идэвхи санаачлага сайтай ажиллах,
- Англи хэлний аман болон бичгийн өндөр чадвартай байх,
- Үнэлгээний хүрээнд компьютерийн хэрэглээний програмууд дээр сайн ажилладаг.

#### **Биологич**

- Биологич мэргэжлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй, мэргэжлийн чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх,
- Ижил төстэй төслүүд дээр ажиллаж байсан туршлагатай байх,
- Бүс нутгийн биологийн олон янз байдалд үнэлгээ хийж байсан туршлагатай байх
- Олон улсын шаардлагын дагуу судалгаа шинжилгээ хийж байсан туршлагатай байх,
- Төслийн ажлын үр дүнг дээшлүүлэх талаар идэвхи санаачлага сайтай ажиллах,
- Англи хэлний ярианы болон бичгийн өндөр чадвартай байх,
- Үнэлгээний хүрээнд компьютерийн хэрэглээний програмууд дээр сайн ажилладаг.

#### **Ургамал судлаач**

- Ургамал судлаач мэргэжлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх, хамгийн багадаа 10 жилийн ажлын туршлагатай байх
- Ижил төстэй төсөл дээр оролцон ажилласан туршлагатай байх,
- Бүс нутгийн биологийн олон янз байдалд үнэлгээ хийж байсан туршлагатай байх,
- Мэдээллийг боловсруулах мэргэжлийн өндөр ур чадвартай, тооцооллын загварчилал дээр ажиллаж байсан туршлагатай байх,
- Төслийн ажлын үр дүнг дээшлүүлэх, ажлын дэс дарааллыг тогтоох талаар идэвхи санаачлага сайтай ажиллах,
- Англи хэлний аман болон бичгийн өндөр чадвартай байх,
- Үнэлгээний хүрээнд компьютерийн хэрэглээний програмууд дээр сайн ажилладаг.



### **Нийгэм, газрын мэргэжилтэн**

- Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ болон газар ашиглалт төлөвлөлт, нийгмийн нөлөөллийн үнэлгээний чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх,
- Нийгэм судлал эсвэл эдийн засагч мэргэжлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх,
- Олон улсын санхүүжилтээр хэрэгжсэн ижил төстэй төслүүдэд нийгэм-эдийн засгийн судалгаа хийж байсан туршлагатай байх,
- Судалгаа шинжилгээ хийх, асуудлыг зөв шийдвэрлэх чадвартай байх,
- Мэдээллийг боловсруулах мэргэжлийн өндөр ур чадвартай байх,
- Англи хэлний аман болон бичгийн өндөр чадвартай байх,
- Үнэлгээний хүрээнд компьютерийн хэрэглээний програмууд дээр сайн ажилладаг.

### **Археологич**

- Археологи ба бусад холбогдох мэргэжлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх. Соёлын өвийн удирдлагаар 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх;
- Ижил төсөөтэй төслүүдэд ажиллаж байсан туршлагатай байх;
- Соёлын биет ба биет бус өвийг үнэлэх, холбогдох асуудлаар менежментийн төлөвлөгөө боловсруулах туршлагатай байх;
- Олон улсын хэмжээнд тавигддаг шаардлагын дагуу судалгаа явуулах туршлагатай байх,
- Төслийн үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэхэд практик арга барилыг боловсруулах санаачлагатай байх;
- Англи хэлний аман болон бичгийн өндөр чадвартай байх;
- БОННУ-ний хүрээнд компьютерийн хэрэглээний програмууд дээр сайн ажилладаг;

### **Антропологич**

- Антропологи ба бусад холбогдох мэргэжлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх. Соёлын өвийн удирдлага, талуудын оролцооны чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх;
- Ижил төсөөтэй төслүүдэд ажиллаж байсан туршлагатай байх;
- Чөлөөт, урьдчилан мэдээлсэн, олон нийтийн хэлэлцүүлэг явуулах, баримтжуулах, эмэгтэйчүүд, залуучууд зэрэг нийгмийн эмзэг бацөөнхийн бүлгийг оролцооны хөтөлбөрүүдэд хамруулах арга хэрэгсэл боловсруулах, тэднийг татан оруулах үйл явцыг удирдан явуулах туршлагатай байх;
- Төслийн талбайд соёлын эмзэг бүлгийн соёлын биет ба биет бус өвийг үнэлэх, холбогдох асуудлаар менежментийн төлөвлөгөө боловсруулах туршлагатай байх;
- Олон улсын хэмжээнд тавигддаг шаардлагын дагуу судалгаа явуулах туршлагатай байх,
- Төслийн үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэхэд практик арга барилыг боловсруулах санаачлагатай байх;

- Англи хэлний аман болон бичгийн өндөр чадвартай байх;
- БОННУ-ний хүрээнд компьютерийн хэрэглээний программууд дээр сайн ажилладаг;

#### **Газар ашиглалтын мэргэжилтэн**

- Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ болон байгалийн нөөц ашиглалтын төлөвлөлт, усны менежмент, газар эзэмшлийн албан ба албан бус тогтолцооны аль алиныг хамарсан төслүүд, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний чиглэлд 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх,
- Газар зохион байгуулалт мэргэжлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх,
- Газар зүйн мэдээллийн системийн программуудыг бүрэн эзэмшсэн байх,
- Төслийн ажлын үр дүнг дээшлүүлэх, ажлын дэс дарааллыг тогтоох талаар идэвхи санаачлага сайтай ажиллах,
- Хүмүүстэй ажиллах ур чадвар сайтай, багаар ажиллах төслийн ажилд ажиллах чадвартай байх,
- Англи хэлний аман болон бичгийн өндөр чадвартай байх,
- Үнэлгээний хүрээнд хэрэглэх компьютерийн хэрэглээний программууд дээр сайн ажилладаг.

#### **Газарзүйн мэдээллийн системийн мэргэжилтэн**

- Газарзүй, ус судлал, экологич болон бусад байгаль орчны салбарын мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байх,
- Газар зүйн мэдээллийн системийн программуудыг бүрэн эзэмшсэн байх,
- Газарзүйн мэдээллийн системийн мэргэжилтнээр ажилласан 8 жилийн туршлагатай, БОАЖ-ын яамны ашигладаг албан ёсны газарзүйн мэдээллийн системийн программ дээр 1-ээс багагүй жил ажилласан туршлагатай байх,
- Мэдээллийг боловсруулах мэргэжлийн өндөр ур чадвартай, тооцооллын загварчлал дээр ажиллаж байсан туршлагатай байх,
- Төслийн ажлын үр дүнг дээшлүүлэх, ажлын дэс дарааллыг тогтоох талаар идэвхи санаачлага сайтай ажиллах,
- Хүмүүстэй ажиллах ур чадвар сайтай, багаар ажиллах төслийн ажилд ажиллах чадвартай байх,
- Англи хэлний аман болон бичгийн өндөр чадвартай байх,
- Үнэлгээний хүрээнд хэрэглэх компьютерийн хэрэглээний программууд болон ГМС-ийн хэрэглээний программууд дээр сайн ажилладаг

#### **Хөрс судлаач**

- Хөрс судлаач мэргэжлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх,
- Олон улсын стандарт, шаардлагын дагуу судалгаа шинжилгээ хийж байсан туршлагатай байх,
- Хөрсний тархацын зураглал гаргаж байсан туршлагатай байх, мэдээллийг боловсруулах мэргэжлийн өндөр ур чадвартай байх,
- Төслийн ажлын үр дүнг дээшлүүлэх талаар идэвхи санаачлага сайтай ажиллах,

- Англи хэлний аман болон бичгийн өндөр чадвартай байх, Үнэлгээний хүрээнд хэрэглэх компьютерийн хэрэглээний програмууд дээр сайн ажилладаг.

Үнэлгээг хийж гүйцэтгэх компани нь өөрийн багийн бүрэлдэхүүнийг өөр хэлбэрээр ажиллуулах тухай санал гаргах, голлох мэргэжилтний дээрх жагсаалтад ороогүй бусад мэргэжлийн чиглэлээр мэргэжилтэнг нэмж ажиллуулна.

Үнэлгээг хийж гүйцэтгэх компани нь нарийвчилсан ТЭЗҮ-г хийсэн гадны компанитай нягт хамтран ажиллах шаардлагатай хурал, уулзалт, олон нийтийн хэлэлцүүлэгт зориулж холбогдох материалуудыг англи, монгол хэл дээр бэлтгэсэн байх шаардлагатай.

Үнэлгээний тайланг **англи болон монгол хэл** дээр тус бүр 4 хувь мөн CD болон DVD дээр бэлтгэн Төсөл хэрэгжүүлэх нэгжид хүлээлгэн өгнө.

БОННУ-ний судалгаануудыг явуулах, техник хангамж, шаардлагатай машин техникийг бүрдүүлж ажил гүйцэтгэх боломжийг хангасан байх шаардлагатай. Төслийн Үнэлгээг хийж гүйцэтгэх компани нь Улаанбаатар хотод оффистай байх шаардлагатай.